



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



ХБХХЕГ/202110004

БАГЦ 6

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ /МОНИТОРИНГ/


ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



Захиалагч: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Зөвлөх: Мэргэжлийн социологичдын холбоо ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо ТББ-ийн ТҮНШЛЭЛ





2019, 2020, 2021



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

7 дугаар хороо, Эрхүүгийн гудамж

Утас/Факс: 976-77032222, 77772001

Мэйл: info@gadpwd.gov.mn

Веб сайт: <http://www.gadpwd.gov.mn>

МЭРГЭЖЛИЙН СОЦИОЛОГИЧДЫН ХОЛБОО ТББ

4 давхар, 107-р байр, Цэлмэг тэнгэр хотхон, 20-р хороо

Хан-Уул дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс

Утас/Факс: 976-99031523

Мэйл: zorigt.8@gmail.com

Веб сайт: <http://www.psa.mn>

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ЗУРАГ, КЕЙС, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
КЕЙСИЙН ЖАГСААЛТ	5
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	8
НЭГ. ОРШИЛ	9
ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЗҮЙ, АРГАЧЛАЛ	10
2.1 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	10
Үндэслэл	10
Зорилго	11
Ажлын хамрах хүрээ	11
Хөтөлбөрийн оролцогч талууд.....	11
Үнэлгээний аналитик үйл ажиллагааны хүрээ	12
Үнэлгээний арга зүйг боловсруулсан үндэслэл	14
Судалгааны ажлыг чанартай, өндөр түвшинд гүйцэтгэсэн баталгаа	14
Түншлэгч байгууллагын хамтын ажиллагаа	14
Хөндлөнгийн үнэлгээний арга зүйн зураглал	15
Хөтөлбөрийн үнэлгээний хүрээнд хийгдсэн ажлууд	17
Үнэлгээний мэдээлэл цуглуулсан арга	19
2.2 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ	21
Бэлтгэл үе шат	21
Мэдээлэл цуглуулагчдыг сургаж бэлтгэсэн байдал	24
Үнэлгээний мэдээлэл цуглуулалт	25
Үнэлгээний мэдээлэл боловсруулалт	26
Нууцлал.....	26
Үнэлгээний ажлын чанар.....	26
Мэдээлэл цуглуулсан багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны төлөвлөгөө.....	27
Судалгааны хязгаарлагдмал байдал, саад бэрхшээл.....	28

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	29
3.1 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	29
3.2 ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДЭМЖЛЭГИЙН ХЭРЭГЖИЛТ	33
3.3 САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	41
3.1 Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилт	41
3.3.2 ТББ-д санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилт	51
3.3.3 Аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилт	53
3.4 АЖИЛ ОЛГОГЧИД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	55
3.5 ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	64
3.6 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	69
3.7 “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР” ЗААЛТ БҮРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	72
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	92
4.1 ДҮГНЭЛТ	92
4.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт	96
4.1.2 Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт	97
4.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт	99
4.1.4 Цар тахлын үед ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт	100
4.1.5 Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт.....	100
4.2 ЗӨВЛӨМЖ	102
ХАВСРАЛТ	106
ХАВСРАЛТ 1.....	106
ХАВСРАЛТ 2.....	123

ХҮСНЭГТ, ЗУРАГ, КЕЙС, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, дүн шинжилгээ	17
Хүснэгт 2. Тоон судалгааны түүвэрлэлт.....	20
Хүснэгт 3. Үнэлгээний мэдээлэл цуглуулалтын хуваарь	25
Хүснэгт 4. ХБИХЭДХ-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл	29
Хүснэгт 5. Аймаг, дүүргийн ХХҮГХ-ээс ирүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн тоон мэдээ (2019-2021 он).....	0
Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын төрөл, байршил	31
Хүснэгт 7. Цогц арга хэмжээний шалгуур үзүүлэлт, судлах асуудал.....	33
Хүснэгт 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэн ажиллах байгууллагууд	33
Хүснэгт 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилт, дэд арга хэмжээ бүрээр	34
Хүснэгт 10. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд оролцож санхүүжилт авсан иргэдийн тоо.....	41
Хүснэгт 11. Зарцуулсан санхүүжилтийн хэмжээ /мянган төгрөг/.....	42
Хүснэгт 12. Хамрагдсан иргэний ангилал	47
Хүснэгт 13. Хамрагдсан ажил олгогчдын тоо.....	55
Хүснэгт 14. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (мянган төгрөг)	56
Хүснэгт 15. Дэмжлэг авсан ААН-ын ажлын байр бий болгосон болон хадгалсан ажлын байрны тоо	57
Хүснэгт 16. Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэгт хамрагдсан иргэдийн тоо.....	64
Хүснэгт 17. Хамрагдсан ААНБ-ын тоо, Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, Хадгалсан ажлын байрны тоо	65
Хүснэгт 18. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн сургалтын байгууллагууд (2021 он).....	69
Хүснэгт 19. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэх хүснэгт	92
Хүснэгт 20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлыг байрыг дэмжих хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл	95

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үнэлгээний хамрах хүрээ	11
Зураг 2. Хөтөлбөрийн оролцогч талууд	12
Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний аналитик үйл ажиллагааны хүрээ (Analytical Framework)	13
Зураг 4. Түншлэгч байгууллагын хамтын ажиллагаа	15
Зураг 5. Хөндлөнгийн үнэлгээний ажлын арга зүйн зураглал	16
Зураг 6. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний мэдээлэл цуглуулсан арга... ..	19

Зураг 7. Судалгааны гарын авлага	21
Зураг 8. ХБИ, ААНБ-уудаас авсан үнэлгээний асуулга	23
Зураг 9. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс авсан үнэлгээний асуулгын маягт	23
Зураг 10. Мэдээлэл цуглуулах судлаач нарт сургалт хийж байгаа нь	24
Зураг 11. Мэдээлэл цуглуулалтын аюулгүй ажиллагаа	27
Зураг 12. Судалгаанд хамрагдсан Багануур дүүргийн ХБИ Э-ийн гэрийн бүслүүр томж, борлуулах өрхийн бизнес	45
Зураг 13. Судалгаанд хамрагдсан ХБИ Г-ын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал	45

КЕЙСИЙН ЖАГСААЛТ

Кейс 1	40
Кейс 2	40
Кейс 3	44
Кейс 4	45
Кейс 5	46
Кейс 6	46
Кейс 7	46
Кейс 8	48
Кейс 9	48
Кейс 10	48
Кейс 11	49
Кейс 12	49
Кейс 13	49
Кейс 14	49
Кейс 15	49
Кейс 16	50
Кейс 17	52
Кейс 18	52
Кейс 19	52
Кейс 20	54
Кейс 21	58
Кейс 22	60
Кейс 23	60
Кейс 24	60
Кейс 25	62
Кейс 26	62
Кейс 27	62
Кейс 28	63
Кейс 29	63

Кейс 30	63
Кейс 31	66
Кейс 32	67
Кейс 33	67
Кейс 34	67
Кейс 35	67
Кейс 36	68
Кейс 37	68
Кейс 38	68
Кейс 39	68
Кейс 40	70
Кейс 41	70
Кейс 42	71

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Хамрагдсан арга хэмжээ, бүсээр	32
График 2. Цогц арга хэмжээнд хамрагдагчдын авсан дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг)	35
График 3. Бэрхшээлийн төрөл.....	36
График 4. Цогц арга хэмжээнд оролцсон ХБИ-ын нас.....	38
График 5. Хүйс.....	38
График 6. Цогц арга хэмжээнд оролцсон ХБИ-ийн боловсролын түвшин.....	39
График 7. Ажлын байрны нэр (төрөл, чиглэл).....	39
График 8. ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх	40
График 9. Эргэн төлөх нөхцөлтэйгээр авсан дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг).....	44
График 10. Ажлын байрны тогтвортой байдал иргэдийн хариулсан байдал	44
График 11. Хамрагдсан иргэдийн ангилал.....	47
График 12. ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх	48
График 13. ТББ-уудад олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг)	51
График 14. ТББ-д эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгож байгаа нь зөв эсэх	51
График 15. ААН-үүдэд олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг)	53
График 16. Үйл ажиллагааны чиглэл (ААН).....	53
График 17. Зээлийн эргэн төлөлтийн хувь.....	54
График 18. НДШ төлдөг байдал	График 19. Төслийн тогтвортой байдал
54	
График 20. ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчийн авсан дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг).....	57
График 21. Хамрагдсан иргэдийн бэрхшээлийн төрөл, хувиар	59
График 22. Хамрагдсан иргэний бэрхшээлийн төрөл	59
График 23. Хамрагдсан иргэдийн нас, хувиар	60

График 24. Хамрагдсан иргэдийн нас.....	60
График 25. Хамрагдсан иргэдийн хүйс, хувиар.....	61
График 26. Хамрагдсан иргэдийн хүйс	61
График 27. Энэ арга хэмжээ нь ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх	62
График 28. Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдаж авсан дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг).....	65
График 29. Түрээсийн дэмжлэг эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх.....	66

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	-	Аж ахуйн нэгж байгууллага
ААН	-	Аж ахуйн нэгж
БЗД	-	Баянзүрх дүүрэг
БГД	-	Баянгол дүүрэг
БХД	-	Багахангай дүүрэг
БНД	-	Багануур дүүр
ЗДТГ	-	Засаг даргын Тамгын газар
ЗБН	-	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
МСХ	-	Мэргэжлийн социологичдын холбоо
МХЕГ	-	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НД	-	Налайх дүүрэг
НДЕГ	-	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	-	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБ	-	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НӨАТ	-	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУХБ	-	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
СБД	-	Сүхбаатар дүүрэг
СХД	-	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	-	Төрийн бус байгууллага
ТБАГУТУГ	-	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар
ЧД	-	Чингэлтэй дүүрэг
ШҮ	-	Шалгуур үзүүлэлт
УБ	-	Улаанбаатар хот
ХБХХЕГ	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий Газар
ХБХЭЭХ	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо
ХБИ	-	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХ	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХБИХЭДХ	-	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
ХУД	-	Хан-Уул дүүрэг
ХХҮЕГ	-	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГХ	-	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар хэлтэс
ХЭҮЗ	-	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХХК	-	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
N	-	Эх олонлогийн хэмжээ
n	-	Түүврийн хэмжээ

НЭГ. ОРШИЛ



[2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр]

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ /МОНИТОРИНГ/

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын захиалгаар “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо” ТББ-ийн түншлэл БАГЦ-6 “**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ /мониторинг/ хийх**” (ХБХХЕГ/202110004) зөвлөх үйлчилгээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг судлаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг илрүүлж, тодорхойлох, шийдэх аргачлал бүхий санал зөвлөмж боловсруулахыг зорьлоо.

Судалгааны анхдагч мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргаар Олон улсын Социологийн холбооны “Ёс зүйн стандарт кодекс”, “Гүнзгийрүүлсэн болон өгөгдлийн шинжилгээг багтаасан зах зээлийн, нийгмийн болон олон нийтийн санаа бодлын судалгаа”-ны (ISO 20252:2019) олон улсын стандартыг баримтлан цуглуулж, зохих аргачлалын дагуу анхдагч мэдээлэлд боловсруулалт хийж тайлан, зөвлөмж боловсрууллаа.

Тайлан дахь дүгнэлт, үр дүн нь судалгаанд оролцогч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын байр суурь, үнэлгээ болон судалгааны явцад цуглуулсан анхдагч өгөгдөл, мэдээлэлд шууд үндэслэсэн. Судалгааны ажлыг гүйцэтгэх, мэдээлэл цуглуулах, зөвшөөрөл хүсэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын (ХБХХЕГ) хамт олонд талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр: Тэргүүн, Н.Батзориг

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр: “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Цэлмэг тэнгэр хотхон, 107-р барилга, 4 давхарт

Холбоо барих мэдээлэл (утас, э-мэйл): Г: 976 99031523

www.psa.mn

zorigt.8@gmail.com





ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.1 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Үндэслэл

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн 27 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг багтаасан, хүртээмжтэй хөдөлмөрийн зах зээлийг бий болгох, ажлын байрны орчинд хүлээн зөвшөөрөгдөх, сонгосон ажлын үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох боломжийг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, ажлын байранд тавигдах шаардлага, хөлслүүлэн ажиллуулах, ажил олгох, ижил ажилд адил цалин хөлс олгох зэргээр хөдөлмөрийн харилцаанд алагчлахгүй байх, төрийн албанд ажиллуулахыг дэмжих, сургалтанд хамруулах, ажлын байранд дадлагажуулах, хувиараа бизнес эрхлэхийг дэмжих, албадан хөдөлмөрөөс хамгаалах гэж тусгасан байдаг.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, тэднийг дэмжихэд орон нутгийн үүрэг хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх талаар дээрх конвенцүүдийн үндсэн зарчим, зүйл заалтад нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох чиглэлээр бичил аж ахуй эрхлэхийг хүссэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх, зээлийн хүүг нөхөн олгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд өөрт нь болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн тусламж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулахаар тус тус тусгасан байдаг.

Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17, 18 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл (шинэчилсэн найруулгын 144), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7, 15.1.4, 22.1.7, 23.5, 31.2.4, 32.2 “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд жил бүр хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ”, “Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.9 хуулиар эрх олгосон бол захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих”, Монгол Улсын Засгийн газрын 321 дүгээр тогтоол “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 2 сарын 9-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 9.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдал, Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйл болон хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (мониторинг) хийх, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам” болон бусад холбогдох хууль тогтоомжууд нь үндэслэл болж байна.

Зорилго


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (мониторинг) хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлоход үнэлгээний үндсэн зорилго оршиж байсан.

Мөн “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.1-д “Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино” гэж заасны дагуу хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтэд тоон болон чанарын үнэлгээ өгөх зорилготой ажилласан.

Ажлын хамрах хүрээ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэд улсын хэмжээнд, сүүлийн 3 жилд (2019, 2020, 2021) авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн байдалд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (мониторинг) хийсэн.

Зураг 1. Үнэлгээний хамрах хүрээ



Хөтөлбөрийн оролцогч талууд

1. Эмнэлэг, хөдөлмөр магадлах комиссын хүчин төгөлдөр шийдвэртэй, бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүн
2. Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж байгаа төрийн бус байгууллага


Зураг 2. Хөтөлбөрийн оролцогч талууд



Үнэлгээний аналитик үйл ажиллагааны хүрээ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний Аналитик үйл ажиллагааны хүрээ (Analytical Framework)-г дараах байдлаар тодорхойлсон (Зураг 3).

Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний аналитик үйл ажиллагааны хүрээ (Analytical Framework)



Үнэлгээний арга зүйг боловсруулсан үндэслэл

Хөндлөнгийн үнэлгээний ажлын хүрээнд нийгмийн судалгаанд хэрэглэгддэг олон улсын нийтлэг онол, арга зүй, тэргүүн туршлага, шинжлэх ухааны аргачлалд тулгуурлан, өөрийн байгууллагад мөрдөгдөж буй арга зүй, стандарт дүрэм журамд үндэслэн **“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (мониторинг) хийх”** ажлын арга зүйг боловсруулсан. Арга зүйг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан. Үүнд:

1. Захиалагчийн зүгээс судалгааны ажлын даалгаварт дурдсан ажилбар бүрийг бүрэн дэлгэрэнгүй түвшинд хамарсан байх;
2. Олон улсын болон үндэсний түвшинд хэрэглэгдэж буй нийтлэг арга зүй, тэргүүн туршлагад үндэслэсэн байх, судалгааны үе шат тус бүрд ёс зүйн болон мэргэжлийн стандартуудыг дагаж мөрдөх;
3. Шинжлэх ухааны болон практикийн үндэслэл, нотолгоотой, ач холбогдолтой арга зүйг сонгосон байх;
4. Аргачлал, арга зүй, зохион байгуулалт нь эдийн засгийн болон ажлын эцсийн үр дүнгийн хувьд үр ашигтай байх зэрэг болно.

Судалгааны ажлыг чанартай, өндөр түвшинд гүйцэтгэсэн баталгаа

1. Үнэлгээний төслийн удирдагч нь төсөл хөтөлбөрийн үнэлгээ, хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр олон судалгааны ажлыг удирдаж ажиллаж байсан туршлагатай судлаач бөгөөд судалгааны ажлыг удирдан явуулах, зохион байгуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх тал дээр мэргэжлийн хүн юм.
2. Мэдээлэл цуглуулалтын үйл явцыг сайтар хянаж, алдаагүй мэдээлэл цуглуулалтыг хийж гүйцэтгэсэн. Ингэхийн тулд үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ISO 20252:2012 үндэсний стандарт болон олон улсын СОЦИОЛОГИЙН ХОЛБООНЫ ёс зүйн дүрмийг сайтар мөрдөж ажилласан болно.
3. Баримт бичгийн судалгааны арга зүйг ашиглахдаа мэдээлэл цуглуулсан судлаачдыг чадавхжуулах, харилцааны үр чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр 1-2 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.

Түншлэгч байгууллагын хамтын ажиллагаа

“Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ нь 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо” ТББ-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Санамж бичгийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх судалгаа болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж, тухайн чиглэлийн судалгааны аргачлал, технологи, сүүлийн үеийн дэвшилтэт арга хэрэгслийг нэвтрүүлэх, судалгааны чанар, судлаачдын мэдлэгийг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр сургалт, судалгааны эрдэм шинжилгээний олон талт арга хэмжээ зохион байгуулах, судалгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхчүүдийг хөгжүүлэх, хамгаалах, хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хөгжлийн бэрхшээлээс үүдсэн ялгаварлан гадуурхалтаас ангид байх талаар төрийн болон бизнесийн байгууллагууд, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, түгээхэд идэвх санаачилгатай хамтран ажиллах талаар

тусгасан. Энэ хүрээнд хөндлөнгийн үнэлгээний мэдээлэл цуглуулалтыг 21 аймаг, 9 дүүрэгт салбартай “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо” ТББ (ХБХЭЭХ) хийж гүйцэтгэсэн. Харин хөтөлбөрийн заалт бүрийн дүн шинжилгээн дээр хууль, эрх зүйн судалгааны “Эрх зүйн соёл” ТББ-тай хамтран ажилласан.

Зураг 4. Түншлэгч байгууллагын хамтын ажиллагаа




ХБХЭЭХ-ний олж авсан мэдлэг, сургамж

1. ХБИХЭДХ-ийг сайн судалж, энэ чиглэлээр бусдад холбоондоо зөвлөгөө өгөх 30 гаруй хүний нөөцтэй болсон.
2. Төрийн байгууллагаас мэдээлэл авах арга барилд суралцсан.
3. Судалгааны мэдээлэл цуглуулалт хийх аргазүйн чадвараа нэмэгдүүлсэн.
4. Багаар ажиллах чадвар сайжирсан.

Хөндлөнгийн үнэлгээний арга зүйн зураглал

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (мониторинг) хийх” зөвлөх үйлчилгээний арга зүйн зураглалыг Зураг 5-д харуулав.

Зураг 5. Хөндлөнгийн үнэлгээний ажлын арга зүйн зураглал



Хөтөлбөрийн үнэлгээний хүрээнд хийгдсэн ажлууд

Хүснэгт 1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, дүн шинжилгээ

№	Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	Дэд шалгуур үзүүлэлт	Нэмэлт дүн шинжилгээ	Хөтөлбөрийн үр дүн	Он
1	ХБХ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо дэд арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болсон ажлын байрны тоо	<ol style="list-style-type: none"> Дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо дэд арга хэмжээ тус бүрээр Зарцуулсан хөрөнгийн хэмжээ Бий болсон ажлын байрны тоо 	<p>-Бэрхшээлийн төрөл, нас, хүйс, боловсрол</p> <p>-Ямар ажлын байранд зуучлагдсан төрөл, чиглэлээр</p> <p>-Тус арга хэмжээ нь ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх</p>	30 хүнийг хамруулж, ажлын байртай болгосон байна.	2021
2	Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан иргэн, аж ахуй нэгж байгууллага дэд арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болсон ажлын байрны тоо	<ol style="list-style-type: none"> Арга хэмжээнд хамрагдсан иргэн, аж ахуй нэгж байгууллага дэд арга хэмжээ тус бүрээр Зарцуулсан хөрөнгийн хэмжээ Бий болсон ажлын байрны тоо 	<p>-ХБИ-ийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх</p> <p>-Хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл</p> <p>-НДШ төлдөг эсэх</p> <p>-Төслийн тогтвортой байдалд дүн шинжилгээ хийж санал зөвлөмж боловсруулах</p> <p>-ТББ-д эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгож байгаа нь зөв эсэх</p>	600 орчим иргэн, ААНБ-ыг хамруулж ажлын байр бий болгосон байна.	2019-2021
3	ХБИ-нд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан ажил олгогчийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болгосон болон хадгалсан ажлын байрны тоо	<ol style="list-style-type: none"> Дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан ажил олгогчийн тоо Зарцуулсан хөрөнгийн хэмжээ Бий болгосон болон хадгалсан ажлын байрны тоо 	-Хамрагдсан иргэдийн бэрхшээлийн төрөл, боловсрол, нас, хүйсээр	80 орчим ажил олгогчийг хамруулж, 90 орчим ажлын байр бий болгосон байна.	2021
4	Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хадгалсан ажлын байрны тоо	<ol style="list-style-type: none"> Дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуй нэгж байгууллагын тоо Зарцуулсан хөрөнгийн хэмжээ Хадгалсан ажлын байрны тоо 	-Одоо олгож буй түрээсийн төлбөрийн хэмжээ нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх	300 орчим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, ажлын байр хадгалсан байна.	2021
5	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамрагдсан хүний тоо, хүйсээр, сургалтын төрлөөр, мэргэжлээр	<ol style="list-style-type: none"> Сургалтанд хамрагдсан хүний тоо Хүйсээр 	-Сургалтанд хамрагдсан хүний нас, сургалтын	350 орчим хүнийг хамруулах ба хамрагдсан	2021

		<p>3. Сургалтын төрлөөр 4. Мэргэжлээр</p>	<p>хугацаа, мэргэжлийн төрөл, -Эзэмшүүлж буй ур чадвар нь тухайн иргэний болон ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх -Сургалтын дадлага хийлгэдэг эсэх -Төгсөгчдийн ажилд зуучлагдсан байдал -Сурагчдын сэтгэл ханамж -Сургалтанд суусан эсэх -Нэг хүнд ногдох зардлын хэмжээ зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх</p>	<p>иргэдийн 70-аас доошгүй хувь нь мэргэшлийн чадамжийн гэрчилгээтэй болсон байна.</p>	
6	<p>Хөтөлбөрийн заалт бүрд дүн шинжилгээ хийж, хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, цаашид нэмэлт өөрчлөлтийн санал зөвлөмж боловсруулах</p>	<p>1. Заалт бүрд дүн шинжилгээ хийх 2. Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох 3. Нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулах</p>	-	<p>Заалт бүрийн хэрэгжилтийн үнэлгээ</p>	2021

Үнэлгээний мэдээлэл цуглуулсан арга

Судлах асуудал тус бүрийн мэдээллийн эх үүсвэрийг нэгтгэж багцлан дараах гурван аргыг хослуулан үнэлгээний мэдээллийг цуглуулан триангуляц хийсэн.


Зураг 6. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний мэдээлэл цуглуулсан арга

1. Баримт бичгийн шинжилгээ

1.1 Бэлэн судалгаа, мэдээлэл



Хоёрдогч мэдээлэл



Судалгаанд ашиглах хоёрдогч тоон мэдээлэл, судалгаа

2. Чанарын судалгаа

2.1 Гол мэдээлэгчтэй хийх ярилцлага (КИ)



30 гол оролцогч талын буюу аймаг, дүүргийн ХХҮГ, хэлтсийн мэргэжилтэн, зорилтот бүлгийн төлөөлөл



Ярилцлагын тэмдэглэл (транскрипт) болон бичлэг

3. Тоон судалгаа

3.1 Нүүр тулсан ярилцлага



Дэмжлэг хамрагдсан 523 ААНБ, ХБИ-ээс авсан тоон судалгаа



Судалгааны өгөгдөл

Үнэлгээний тайлан

- Үнэлгээний үр дүн
- Дүгнэлт, санал зөвлөмж

- Баримтын шинжилгээ: бэлэн байгаа судалгаа, тайлан, статистик тоо мэдээллийг цуглуулж шинжилгээ хийх.** Баримтын шинжилгээний үр дүнгээр судалгааг хийх шалтгаан, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлт, харьцуулалтын хэлбэр, мэдээлэл цуглуулалтын аргыг нарийвчлан тодорхойлох, судалгааны хэрэглэгдэхүүн буюу үнэлгээний асуулга, гарын авлага, ярилцлагын удирдамжийг боловсруулсан. Түүнчлэн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, тэдгээрийн тоон болон чанарын дүнг шууд тайлбарлахад баримтын шинжилгээний үр дүнг ашигласан. Баримтын шинжилгээний мэдээлэл цуглуулалтыг зөвлөх багийн голлох мэргэжилтнүүд буюу багийн ахлагч, холбогдох харилцааг хариуцсан мэргэжилтнүүд гардан гүйцэтгэсэн.
- Чанарын судалгаа:** Чанарын судалгааны хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн гол мэдээлэгчид буюу гол оролцогч талууд болох албан тушаалтан, мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан – гүнзгийрүүлсэн ярилцлагыг хийсэн. Чанарын судалгааны мэдээлэл цуглуулалтыг ХБХЭЭХ-ны ажилтнууд, голлох мэргэжилтнүүд буюу багийн ахлагч, холбогдох харилцааг хариуцсан мэргэжилтнүүд гардан гүйцэтгэсэн. Чанарын судалгааны хүрээнд 30 оролцогчтой ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан.

3. **Тоон судалгаа:** Тоон судалгааны хүрээнд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 5 арга хэмжээнд хамрагдсан зорилтот бүлэг буюу ХБИ, ажил олгогч, ААНБ, ТББ-уудаас 523 оролцогчтой нүүр тулсан ярилцлагын аргаар асуулга судалгааг хийсэн. Тоон судалгааны мэдээлэл цуглуулалтыг ХБХЭЭХ-ны 21 аймаг, 9 дүүргийн ажилтнууд, голлох мэргэжилтнүүд хийж гүйцэтгэсэн. 2021 оны байдлаар 234 байгууллага, 2274 ХБИ, нийт 2508 иргэн, ААНБ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсанаас тоон судалгаанд 234 байгууллага, 329 ХБИ, нийт 419 иргэн, ААНБ-ыг хамруулахаар төлөвлөсөн. Судалгааны явцад бид нийт 523 оролцогчоос судалгаа авснаас 357 нь ХБИ, 70 ТББ, 81 ХХК, 14 бусад хэлбэрийн бүтэц байлаа.

Хүснэгт 2. Тоон судалгааны түүвэрлэлт

Бүс	Судалгаанд оролцогчдын төрөл				Нийт
	Иргэн (ХБИ, эцэг эх, асран хамгаалагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч)	ТББ	ХХК	Бусад	
Баруун	39	1	6	4	50
Хангайн бүс	104	7	9	2	122
Төвийн бүс	60	4	6	-	70
Зүүн бүс	35	-	11	5	51
Улаанбаатар	119	58	49	4	230
Нийт	357	70	81	15	523



2.2 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Бэлтгэл үе шат

Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгслийг боловсруулах: Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгсэл (Survey instruments) гэдэгт дараах зүйлсийг хамруулан авч үзсэн.

1. ХХҮГХ-ээс авах үнэлгээний асуулга маягт;
2. Иргэн, ААНБ-аас авах үнэлгээний асуулга;
3. Ярилцлага авагч нарт зориулсан гарын авлага;
4. Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ашигласан бусад бүртгэлийн болон үйл ажиллагааны баримтжуулалтын хуудаснууд

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг нүүр тулсан ярилцлагын арга (**FACE TO FACE INTERVIEW**)-ыг ашиглан PAPI (цаасаар судалгаа авах) болон CATI (утсаар судалгаа авах) аргыг ашиглан өгөгдлийг цуглуулсан. Аливаа судалгааны үр дүн ярилцлага авагчид судалгааны болон асуулт тус бүрийн зорилго, ач холбогдлыг зөв ойлгосон эсэх, судалгаанд оролцогчидтой нягт хамтран ажиллаж үнэн зөв мэдээллийг авч чадсан эсэхээс шууд хамаардаг учраас ярилцлага авагчдад зориулсан гарын авлага судалгааны чухал хэсэг болдог.

Зураг 7. Судалгааны гарын авлага

ХБХХЕГ/202110004

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ /МОНИТОРИНГ/ СУДАЛГААНЫ ГАРЫН АВЛАГА

2022.01.27

Захиалагч: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
Зөвлөх: Мэргэжлийн социологичдын холбоо ТББ

ГАРЫН АВЛАГА

ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хамрах хүрээ: Улсын хэмжээнд (21 аймаг, 9 дүүрэг)

2019, 2020, 2021

Хөтөлбөрийн оролцогч талууд:

1. Эмнэлэг, хөдөлмөр магадлах комиссын хүчин төгөлдөр шийдвэртэй, бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүн
2. Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг эрх ашгийг хамгаалах чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж байгаа төрийн бус байгууллага

Хамрах хугацаа: Сүүлийн 3 жилд (2019, 2020, 2021)

Мэдээлэл цуглуулах хугацаа: 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал 30 хоног

Маягт асуулга: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 3.8: "Хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээндүүдийн жишиг загварыг ХБХХЕГ-ын дарга, ХХҮЕГ-ын дарга тус тус батална. Тайлангийн маягтад хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрт хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд маягтыг ХНХЯ-ны саналыг үндэслэж батална."

Иймд ярилцлага авагчдад зориулсан гарын авлагыг боловсруулсан бөгөөд энэ нь дараах агуулгын багтаасан. Үүнд:

- Танилцуулга (үнэлгээний талаарх ерөнхий танилцуулга болон гарын авлагын агуулга)
- Үнэлгээний танилцуулга (Хөндлөнгийн үнэлгээний зорилго, ач холбогдол, судалгааны хамрах хүрээ, судалгааны нэгж)
- Үнэлгээний зохион байгуулалт (Зохион байгуулалтын бүтэц, судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа, дараалал)
- Ярилцлага хийх зөвлөмж (Ярилцлагыг зөв эхлүүлэх зарчмууд, судалгаанд оролцогч нартай сайн харилцаа үүсгэх зөвлөмжүүд, харилцааны зөвлөмжүүд)
- Асуулгыг бөглөх зааварчилгаа (асуулгыг бөглөх ерөнхий зааварчилгаа, асуулт, хариулт бүрийн тайлбар, тодорхойлолт)
- Бусад лавлагаа материалууд (Асуулгад хэрэглэгдэх стандарт ангиллууд, тэдгээрийн код, тайлбар, хэмжих нэгжийн жагсаалт, тэдгээрийн хөрвүүлэх итгэлцүүрүүд гэх мэт)
- Утсаар ярих зааварчилгаа (Компьютер асаахаас эхлэн ажиллуулах, унтраах хүртэлх бүх тайлбар)

Судалгааны гарын авлагаас гадна хоёр төрлийн судалгааны асуулгын хуудас буюу мэдээллийн маягт боловсруулсан. Судалгааны асуулгыг ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 5 үндсэн арга хэмжээ, 9 дэд арга хэмжээний хүрээнд зохиомжлон боловсруулсан болно. Эдгээр асуултаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх ойлголт, хүлээлт, үнэлэмж, зан үйл зэргийг илрүүлэх тусгай асуултуудыг оруулж өгсөн.

“Зах зээлийн, олон нийтийн санаа бодлын болон нийгмийн судалгаа: Нэр томъёоны тайлбар болон үйлчилгээний шаардлага” ISO20252:2019 стандартын 4.4.1-д заасан:

1. Судалгааны асуулт, хэрэглэгдэж буй үг хэллэг, нэр томъёо нь судалгаанд оролцогчдод ойлгомжтой, хоёрдмол утгыг илэрхийлэхгүй, эргэлзээ төрүүлэхгүй байх;
2. Олон улсын болон үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, хэрэглэгддэг ойлголт тодорхойлолт, ангилал кодыг ашигласан байх;
3. Мэдээлэл боловсруулалтыг хялбарчлах, мэдээлэл оруулалтыг алдааг багасгах үүднээс асуултын хариултыг боломжит түвшинд кодчилсон байх” гэсэн зарчмыг баримталж асуулгыг боловсруулсан.

Зураг 8. ХБИ, ААНБ-удаас авсан үнэлгээний асуулга

ГАРЫН АВЛАГА		ГАРЫН АВЛАГА	
Нэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн арга хэмжээнд хамрагдсан иргэн, ААНБ-удаас авах мэдээллийн МАЯГТ			
Q1	Судалгаанд оролцогчийн төрөл:	1. Иргэн (ХБИ, эцэг эх, асран хангаалагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч) 2. Төрийн бус байгууллага 3. ХОХ 4. Бусад / _____ /	
Q2	Судалгаанд оролцогчийн нэр:	/ _____ /	
Q3	Регистрийн дугаар:	/ _____ /	
Q4	Хамрагдсан арга хэмжээ:	1. Хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ (цогц арга хэмжээ) 2. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ 4. Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ 5. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээ	
1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ (цогц арга хэмжээ)			
Q1.1	Авсан дэмжлэгийн хэмжээ (төгрөгөөр)	/ _____ /	
Q1.2	Бий болгосон ажлын байрны тоо:	/ _____ /	
Q1.3	Бэрхшээлийн төрөл:	1. Харрах эрхтэний 2. Сонсоглын 3. Хэл ярианы 4. Хөдөлгөөний 5. Оюун улаан, сэтгэцийн 6. Хавсарсан 7. Бусад / _____ /	
Q1.4	Нас:	/ _____ /	
Q1.5	Хүйс:	1. Эрэгтэй 2. Эмэгтэй	
Q1.6	Боловсролын түвшин:	1. Магистр болон түүнээс дээш 2. Бакалаврын 3. Тусгай дунд (МСУТ, Коллекч төгссөн) 4. Бурэн дунд боловсролтой 5. Бурэн бус дунд 6. Бага 7. Боловсрол зэмшмэггүй	
Q1.7	Ажлын байрны нэр (төрөл, чиглэл)	/ _____ /	
Q1.8	ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцжэ байгаа эсэх:	1. Нийцсэн 2. Нийцээгүй	
Q1.9	Нийцээгүй бол илгээд:	/ _____ /	
2. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ			
Q2.1	Авсан дэмжлэгийн хэмжээ (төгрөгөөр)	/ _____ /	
Q2.2	Бий болгосон ажлын байрны тоо:	/ _____ /	
Q2.3	Иргэн бол: Ажлын байрны тогтвортой байдал	1. Тогтвортой 2. Тогтворгүй	
Q2.4	Хамрагдсан иргэний ангилал:	1. Өрхийн үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч ХБИ 2. Байнгын асрагаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг эх	
Q2.5	ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцжэ байгаа эсэх:	1. Нийцсэн 2. Нийцээгүй	
Q2.6	ТББ бол: ТББ-д эргэн төлөгдөх нөхцөлүүдээр олгож байгаа нь зөв эсэх:	1. Зөв 2. Буруу 3. Хэлж нэдэггүй	
Q2.7	ААН бол: Үйл ажиллагааны чиглэл	/ _____ /	
Q2.8	ААН бол: НДШ төлдөг эсэх	1. Төлдөг 2. Төлдөггүй	
Q2.9	ААН бол: Төслийн тогтвортой байдал	1. Тогтвортой 2. Тогтворгүй	
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ			
Q3.1	Авсан дэмжлэгийн хэмжээ (төгрөгөөр)	/ _____ /	
Q3.2	Бий болгосон ажлын байрны тоо:	/ _____ /	
Q3.3	Хадгалсан ажлын байрны тоо	/ _____ /	
Q3.4	Хамрагдсан иргэний бэрхшээлийн төрөл:	1. Харрах эрхтэний 2. Сонсоглын 3. Хэл ярианы 4. Хөдөлгөөний 5. Оюун улаан, сэтгэцийн 6. Хавсарсан 7. Бусад / _____ /	
Q3.5	Хамрагдсан иргэний нас:	/ _____ /	
Q3.6	Хамрагдсан иргэний хүйс:	1. Эрэгтэй 2. Эмэгтэй	
Q3.7	Энэ арга хэмжээ нь ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцжэ байгаа эсэх:	1. Нийцсэн 2. Нийцээгүй	
4. Цар тухлын үед ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ			
Q4.1	Авсан дэмжлэгийн хэмжээ (төгрөгөөр)	/ _____ /	
Q4.2	Хадгалсан ажлын байрны тоо:	/ _____ /	
Q4.3	Олгож буй түрээсийн төлбөрийн хэмжээ нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцжэ байгаа эсэх:	1. Нийцсэн 2. Нийцээгүй	
5. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах			
Q5.1	Нэг хүнд ногдож зардлын хэмжээ (төгрөгөөр)	/ _____ /	

Зураг 9. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс авсан үнэлгээний асуулгын маягт

ХОЁР. АЙМАГ, ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР, ХЭЛТЭСЭЭС АВАХ МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ													
Шалгуур үзүүлэлт 2: Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ													
№	Дэд арга хэмжээ	Тоо			Зарцуулсан санхүүжилтын хэмжээ (төг)			Бий болгосон ажлын байрны тоо			Ажлын байрны тогтвортой байдал	Хамрагдсан иргэний ангилал	ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцжэ байгаа эсэх
		2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он			
1	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох	[]	[]	[]	[]	[]	[]	[]	[]	[]	1. Тогтвортой 2. Тогтворгүй	Өрхийн үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч ХБИ [] Байнгын асрагаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг эх []	1. Нийцсэн 2. Нийцээгүй
Шалгуур үзүүлэлт 3: Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх													
Он	Хамрагдсан ажил олгогчийн тоо	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (төг)	Бий болгосон ажлын байрны тоо	Хадгалсан ажлын байрны тоо	Хамрагдсан иргэд/ бэрхшээлийн төрлөөр	Хамрагдсан иргэд / Нас	Хамрагдсан иргэд / Хүйс						
2019 он	[]	[]	[]	[]	Харгах эрхтэний [] Сонсоглын [] Хэл ярианы []	18 хүртэлх [] 19 – 34 нас [] 35 – 44 нас []	Эрэгтэй [] Эмэгтэй []						

Шалгуур үзүүлэлт 4: Ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх

Он	Хамрагдсан иргэдийн тоо	Хамрагдсан ААНБ-ын тоо	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (төг)	Хадгалсан ажлын байрны тоо	Олгож буй түрээсийн төлбөрийн хэмжээ нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх
2019 он	[]	[]	[]	[]	1. Нийцсэн 2. Нийцээгүй
2020 он	[]	[]	[]	[]	1. Нийцсэн 2. Нийцээгүй
2021 он	[]	[]	[]	[]	1. Нийцсэн 2. Нийцээгүй

ТА БҮХ АСУУЛТАА БҮРЭН АСУУСАН УУ? ӨӨРИЙГӨӨ ДАХИН НЭГ ШАЛГААРАЙ.

Мэдээлэл цуглуулагчдыг сургаж бэлтгэсэн байдал

Сургалтанд Мэргэжлийн социологичдын холбооны зөвлөх үйлчилгээний ажилд ажиллах бүх ажилтнууд болон ХБХЭЭХ-ны аймаг бүрийн салбарын төлөөллийг хамруулсан. Судалгаанд ажиллах багын гишүүдийг нөөцтэй байхаар сургалтанд хамруулсан.

Судалгааны ажилд оролцож буй хүн бүр нь судалгааны зорилго, ач холбогдол, үйл ажиллагааны зохион байгуулалт, асуулга дахь нэр томъёо, асуулгыг хэрхэн бөглөх талаар сайтар ойлголттой байх нь судалгааны үр дүнд чухал ач холбогдолтой. Иймээс зөвлөх үйлчилгээний ажил эхлэхэд багийн бүрэлдэхүүн болох удирдагч, судалгааны менежер, мэдээлэл цуглуулах багын гишүүдийг хамруулсан сургалтыг зохион байгуулж, ажлын талаар цогц мэдээллийг биечлэн өгсөн.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэл цуглуулалтыг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 3 дугаар сарын 11-ний өдрийн хооронд 45 судлаачийн бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний мэдээлэл цуглуулалтыг 2 сарын хугацаанд зохион байгуулахаар төлөвлөж ажилласан.

Зураг 10. Мэдээлэл цуглуулах судлаач нарт сургалт хийж байгаа нь





Сургалтын сэдэв тус бүрээр Powerpoint программ дээр presentation бэлтгэсэн. Мэдээлэл цуглуулах ярилцлага авагч нарт зориулсан сургалтыг Мэргэжлийн социологичдын холбооны (МСХ) тэргүүн Н.Батзориг ХБХЭЭХ-ны багтай хамтран явуулсан.

Үнэлгээний мэдээлэл цуглуулалт

Үнэлгээ, мониторинг хийхэд шаардлагатай өгөгдөл, мэдээлэл, тайланг захиалагч ХБХХЕГ болон ХХҮЕГ, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрд хэрэгцээтэй тоон болон чанарын мэдээллийг сүүлийн 3 жилээр 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс авсан болно. Мэдээлэл авах зохион байгуулалтыг ХБХХЕГ-тай хамтран албан бичиг өгөх, биечлэн болон утсаар холбогдох байдлаар зохион байгуулсан.

Хөтөлбөрийн үнэлгээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “Цар тахлын үед ах ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийг холбогдох заалтуудыг харгалзан үзсэн.

Хүснэгт 3. Үнэлгээний мэдээлэл цуглуулалтын хуваарь

№	Үйл ажиллагаа	Хөтөлбөрийн үр дүн	2022 он /7 хоногоор/							
			1 сар				2 сар			
			1	2	3	4	1	2	3	4
3.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад үзүүлэх дэмжлэг	30 хүн								
3.2	Санхүүгийн дэмжлэг олгох	600 орчим иргэн, ААНБ								
3.2.1	<i>Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох</i>									
3.2.2	<i>ТББ-д санхүүгийн дэмжлэг олгох</i>									
3.2.3	<i>ААН-д санхүүгийн дэмжлэг олгох</i>									
3.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх	80 ажил олгогч, 90 ажлын байр								
3.4	Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх	300 орчим иргэн, ААН								
3.5	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах	350 орчим хүн								

Үнэлгээний мэдээллийг сонгогдсон ААНБ болон ТББ тус бүрээр зочилж ганцаарчилсан ярилцлагын аргаар цуглуулсан. Судлаачийн аюулгүй байдлыг хангах үүднээс Улаанбаатар хотод хорооны хэсгийн ахлагч, аймагт багийн ХХҮ-ийн газар хэлтсийн ажилтнуудыг хөтөчөөр ажиллуулсан.

Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн сүүлийн 3 жилийн мэдээнээс түүврийн аргаар (8-10 хүн тутамд) асуумжийн дагуу судалгааг авсан. Ярилцлага авах хүмүүс хоорондын адил тэгш харилцааг эрхэмлэн бие биенээ сонсох, хүндлэх, нээлттэй хэлбэрээр судалгаагаа авсан болно.

Мэдээлэл цуглуулалтыг хариуцсан ХБХЭЭХ-ноос фэйсбүүкийн групп чат болон хаалттай групп нээж, хөдөлмөр эрхлэлтийн мониторингийн мэдээлэл цуглуулах судлаачиддаа мэдээлэл өгөх, мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулж ажилласан. Ковидын хөл хориотой байсан тул халдвар хамгааллыг нягт барьж ажиллахыг анхааруулан сануулж, гэрээнд тусгаж ажилласан.

Үнэлгээний мэдээлэл боловсруулалт

Үнэлгээний мэдээллийг оруулах, шалгах, засварлахдаа тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CsPro багц программ, мэдээллийн үр дүнг нэгтгэж боловсруулах, холбогдох хүснэгтүүдийг тооцох ажлыг STATA, SPSS программыг тус тус ашиглан гүйцэтгэсэн.

1. Чанарын судалгааны мэдээллийг кодлох, компьютерт шивж оруулах, ярилцлагын протоколыг баримтжуулах
2. Тоон судалгааны мэдээллийг SPSS болон STATA программ ашиглан боловсруулсан.
3. Үнэлгээний үр дүнгийн үзүүлэлт болон хүснэгтийг нийт дундаж, аймгийн түвшинд тооцсон. Тооцооллыг зөвхөн судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ААНБ-ын хувьд төлөөлөх чадвартай байхаар хийсэн.

Нууцлал

Үнэлгээний тоон мэдээллийг судалгааны зорилгын дагуу нэгдсэн анализ, дүн шинжилгээ хийхэд ашигласан. Судалгаанд ажиллаж байгаа бүх шатны ажилтнууд судалгааны мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээж, нууцлалын гэрээ байгуулж ажилласан. Мөн судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллийг судлаачид нууцлах үүргийг зөвлөх байгууллагын дотоод журмын дагуу хэрэгжүүлж, захиалагч байгууллагад энэ талаарх холбогдох мэдээллийг өгсөн.

Үнэлгээний ажлын чанар

Үнэлгээний мэдээллийг чанартай цуглуулахын тулд дараах зарчмыг баримталж ажилласан.

1. Ажиллах ажилтнууд нь батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдсан.
2. Ажиллах ажилтнууд нь нарийн заасан зааврын дагуу ажлын чиг үүргийг баримталж ажилласан.
3. Үнэлгээний мэдээлэл цуглуулах явцад хяналт тавих ажлыг судалгааны багийн ахлагч хариуцаж зохион байгуулсан.
4. Сонгогдсон түүврийн нэгж бүрийг судалгаанд бүрэн хамруулах талаар судалгааны бүх шатны ажилтнууд чармайлт тавьж ажилласан. Шаардлагатай тохиолдолд

судалгаанд хамрагдаж байгаа орон нутгийн захиргааны дэмжлэгийг авч хамтран ажилласан.

Уг судалгаа нь PAPI буюу хэвлэмэл байдлаар авч байгаа учраас мэдээллийн сан давхар үүсгэсэн. Ирсэн датаны логик уялдаа холбоо, бичиглэлийн болон үг, үсгийн алдаа байгаа эсэхийг хянан засварлаж өгөгдлийг бэлэн болгосон. Мэдээллийн санг CPro, SPSS, MS-EXCEL программууд дээр үүсгэсэн. Тайлан боловсруулах ажлыг багийн ахлагч, судлаачид, түншлэгч байгууллагын төлөөлөл хамтран гүйцэтгэсэн.

Мэдээлэл цуглуулсан багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны төлөвлөгөө

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг хийхэд судлаачдын аюулгүй байдлыг хангах нь хамгийн чухал юм. Тиймээс бид энэ тал дээр онцгой анхаарал хандуулан ажилласан бөгөөд дараах үе шатуудыг заавал мөрдөж ажилласан. Үүнд:

Зураг 11. Мэдээлэл цуглуулалтын аюулгүй ажиллагаа

1. Хөгжлийн бэрхшээлийн иргэд, ААНБ-тай хамтран ажиллаж байсан туршлагатай ярилцлага авагчдаар багаа бүрдүүлэх	2. Судлаачдын аюулгүй байдлыг хангах үүднээс заавал олгогдох зүйлсийг бүрдүүлэх, бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалгах	3. “Аюулгүй ажиллагааны дүрэм” танилцуулах, болон тухайн мэдээлэл цуглуулалтын ажлын онцлогтой холбоотой гарах бусад зүйлсийг заавал танилцуулж сургалт орох	4. “Аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн биелэлт, хэрэгжилтэд судалгааны менежер болон мэдээлэл цуглуулах багийн ахлагч байнга хяналт тавих, хэрэгжилтийг хангах
--	---	--	--

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд 30-40 мэдээлэл цуглуулагчыг ажиллуулсан бөгөөд байгаль цаг уурын нөхцөл байдал, гэмтэж бэртэх, өвлийн улирал таарсан, цагаан сарын баяр давхацсан зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан мэдээлэл цуглуулагч нарын аюулгүй байдлыг хангах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Мэдээлэл цуглуулагч нарыг “Тэнгэр даатгал” компанийн Гэнэтийн осол, хөдөлмөрийн чадвараа түр алдалтын даатгалд хамруулсан.
2. Мэдээлэл цуглуулагч нарт судалгааны мэдээлэл цуглуулах ажилтан мөн гэдгийг батлах түр үнэмлэх олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энд ISO20252:2019 стандартын хавсралт В.3 “Мэдээлэл цуглуулах ажилтны үнэмлэх (ID)” хэсэгт заасныг баримтлан ажилласан. Мөн гүйцэтгэгч байгууллагын гэрээ, албан бичгийг тогтмол авч явах үүрэг өгсөн.
3. Мэргэжлийн социологичдын холбооны “Аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг бүх ярилцлага авагчид болон багийн ахлагчид, судалгааны менежерүүд үйл ажиллагааны үе шат бүрд дагаж мөрдөж ажилласан.
4. Мэдээлэл цуглуулагч нарын аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах багаж хэрэгслээр хангасан.
 - Хурц тусдаг гар чийдэн
 - Чанга дуу гаргагч /шүгэл/

5. Мэдээлэл цуглуулагч нарын талбар дээр ажиллах цагийн хуваарийг өвлийн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр журамд заасан нөхцөлөөр (ажлын 6 цагаар) тодорхойлсон.

Судалгааны хязгаарлагдмал байдал, саад бэрхшээл

Төрийн байгууллагаас мэдээлэл авахад хүндрэлтэй байдал:

1. ХХҮХ, ХБХХЕГ-уудаас ирүүлсэн судалгаа хангалттай бус байсан. Зарим байгууллагын утас, хаяг тодорхой бус, дугаар андуурсан гэх мэт асуудлууд гарсан. Аль дүүрэг, аймаг нь тодорхойгүй байсны улмаас бүх хүн рүү нэг бүрчлэн ярьж, аймаг дүүргийг нь тодруулах ажлыг ХБХХЕГ-аас ирсэн зарим оны дутуу мэдээллийн дагуу хийж гүйцэтгэсэн.
2. Таван аймгийн ХХҮГ-т очиход ХБХХЕГ-ын албан тоотыг тоохгүй, харьяа дээд байгууллагаас нь албан тоот ирээгүй болохоор цааргалж, дахин ХБХХЕГ-аас албан тоот авч хүргүүлж байж мэдээллээ авсан.
3. “ХХҮЕГ-аас зөвшөөрөл авч байж үнэлгээний мэдээлэл өгнө” гэх зэргээр мэдээлэл цуглуулах хугацаа хойшилсон.
4. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллага болон иргэд ААН-үүдтэй холбоо уялдаатай байх, бүртгэл шинэчлэх ажлуудыг ХХҮГ болон ХБХХЕГ тогтмол хийх шаардлага үүссэн.
5. Төрийн холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээллийн байршил болон утас, ажил олгогч нь тодорхойгүй байсан тул зарим аймгийн статистикийн хэлтсээс дэмжлэг авч ажилласан.
6. ХХҮХ-ийн судалгаа, мэдээлэл хангалтгүй, шаардлага хангахгүй, зарим аймаг, дүүргийн хариуцсан мэргэжилтэн нь солигдсоноос шинэ мэргэжилтэн нь өнгөрсөн оны үйл ажиллагааг мэдэхгүй байсан. Өөрөөр хэлбэл ажил хүлээлцэх үйл явц төрийн албанд муу хийгдэж байна.
7. Зарим судалгаанд оролцогч судалгаанд мэдээлэл цуглуулсан судлаачийг хэл амаар доромжлох, хувийн нууц учир судалгааны асуултад хариулахгүй байх зэрэг асуудал үүсгэсэн.

I ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хөндлөнгийн үнэлгээний өгөгдлийг үндсэн 3 эх сурвалжаас бүрдүүлсэн.

1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс бэлдсэн асуулгын маягтын дагуу авсан тоон мэдээлэл
2. ХБИХЭДХ-ийн арга хэмжээнд хамрагдсан иргэн, ААНБ-аас түүврийн аргаар авсан санал асуулгын дүн
3. ХХҮЕГ болон ХБХХЕГ-аас ирүүлсэн статистик бүртгэлийн тоон мэдээлэл

Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс ирүүлсэн мэдээллийн нэгтгэл

Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс (цаашид ХХҮГХ гэх)-ээс ирүүлсэн мэдээллийн хүрээнд хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан хүн, байгууллага, зарцуулсан хөрөнгө болон бий болгосон ажлын байрны тоог сүүлийн 3 жилийн байдлаар харвал:

- 2019 онд хөтөлбөрт нийт 5,622 хүн хамрагдаж, 2020 онд энэ тоо 49 хувиар буурч 2,844 болсон бол 2021 онд дахин 21 хувиар өсөж 3440 хүрээд байна.
- Харин 2019 онд 3.5 тэрбум төгрөг зарцуулсан бол 2020 онд 10 хувиар буурч 3.3 тэрбум төгрөг, 2021 онд 47 хувиар нэмэгдэж 6.4 тэрбум төгрөг болсон байна.
- Бий болгосон ажлын байрны тоо 2019 онд 1,161 байсан бол 2020 онд 6.2 хувиар буурч 1089, 2021 онд 16 хувиар нэмэгдэж 1265 хүрээд байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т дунджаар 3969 хүн, 279 байгууллага хамрагдаж, 1171 ажлын байр бий болж, 4.4 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 4. ХБИХЭДХ-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Он	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Хувь
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	
1.	2019 он*	4992	4,020,080.00	5622	3,542,869.68	88.1%
2.	2020 он**	4989	4,197,840.0	2844	3,376,910.9	80.4%
3.	2021 он***	2848	8,377,308.5	3440	6,432,839.54	76.7%
ДУНДАЖ		4276	5,531,742.83	3969	4,450,873.37	81.7%

Хүснэгт 5. Аймаг, дүүргийн ХХҮГХ-ээс ирүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн тоон мэдээ (2019-2021 он)

№	Хөтөлбөр/Арга хэмжээ	2019 он*				2020 он**				2021 он***			
		Хамрагдсан хүн	Байгуулага	Зарцуулсан хөрөнгө	Бий болсон ажлын байр	Хамрагдсан хүн	Байгуулага	Зарцуулсан хөрөнгө	Бий болсон ажлын байр	Хамрагдсан хүн	Байгуулага	Зарцуулсан хөрөнгө	Бий болсон ажлын байр
1	Цогц арга хэмжээ	-	237	-	-	-	274	-	-	79	325	13,490	42
2	Санхүүгийн дэмжлэг	643		2,057,950	790	723		2,068	780	696		2,471	805
3	Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх	910		160,500	-	174		115,324	-	227		248,888	-
4	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	2254		66,698		1094		31,710		1334		54,900	
5	ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх	41		146,307	69	41		181,980	40	49		275	44
Нийт		5,622	237	3,542,869.68	1161	2,844	274	3,376,910.9	1089	3440	325	6,432,839.54	1265

* Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

** ХХҮЕГ-аас ирүүлсэн мэдээлэл, 2020 оны нэгтгэл

*** ХХҮЕГ-аас ирүүлсэн мэдээлэл, 2021 оны нэгтгэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн арга хэмжээнд хамрагдсан иргэн, ААНБ-уудын судалгаанд хамрагдсан байдал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр /цаашид ХБИХЭДХ гэх/-ийн оролцогчдыг иргэн (ХБИ, эцэг эх, асран хамгаалагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч), төрийн бус байгууллага, ХХК, нөхөрлөл /ЗБН/ ба ТБАГУТУГ гэсэн 4 төрөлд хувааж, аймаг, бүс, хамрагдсан арга хэмжээ зэргээр харьцуулан үр дүнг харууллаа.

Судалгаанд оролцогчийн төрөл

Энэхүү үнэлгээний хүрээнд нийтдээ 523 иргэн, ААНБ-уудаас амжилттай судалгаа авснаас 56 хувь (295) нь орон нутгаас, 44 хувь (229) нь Улаанбаатар хотын иргэд, ААНБ-ууд байна. Судалгаанд оролцогчдын төрлийг байршил, бүс, аймаг нийслэлээр харьцуулан хүснэгт 5-д харуулав.

Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын төрөл, байршил


№	Байршил, бүс, аймаг, нийслэл	Иргэн (ХБИ, эцэг эх, асран хамгаалагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч) /Тоо/	Төрийн бус байгууллага /Тоо/	ХХК /Тоо/	Нөхөрлөл /ЗБН/, ТБАГУТУГ /Тоо/	Нийт/тоо
	Баруун бүс	40	1	6	4	51
1	Баян-Өлгий	8	-	-	-	8
2	Завхан	8	-	-	-	8
3	Увс	14	-	-	-	14
4	Ховд	10	1	6	4	21
	Хангайн бүс	104	7	9	1	121
1	Архангай	22	4	-	-	26
2	Баянхонгор	13	-	-	-	13
3	Булган	10	2	2	-	14
4	Орхон	16	-	-	1	17
5	Өвөрхангай	30	-	1	-	31
6	Хөвсгөл	13	1	6	-	20
	Төвийн бүс	61	4	7	-	72
1	Говьсүмбэр	9	-	6	-	15
2	Дархан-Уул	19	4	-	-	23
3	Дорноговь	4	-	-	-	4
4	Дундговь	17	-	1	-	18
5	Сэлэнгэ	2	-	-	-	2
6	Төв	10	-	-	-	10
	Зүүн бүс	35	-	11	5	51
1	Дорнод	15	-	7	2	24
2	Сүхбаатар	11	-	1	-	12
3	Хэнтий	9	-	3	3	15
	Бүсийн хэмжээнд	240	12	33	10	295
1	Сонгинохайрхан	29	4	8	-	42

2	Сүхбаатар	16	9	2	1	28
3	Багахангай	13	-	-	-	13
4	Налайх	13	1	2	-	16
5	Баянзүрх	12	16	13	-	41
6	Чингэлтэй	10	9	9	3	31
7	Баянгол	9	8	3	-	20
8	Хан-Уул	8	11	12	-	31
9	Багануур	7	-	-	-	7
Улаанбаатар/ Дүүргийн нэр		117	58	49	4	228
Улсын хэмжээнд нийтдээ		357	70	82	14	523

Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл, Q1, N=523

Ажлын байр шинээр бий болгох, хадгалахад чиглэсэн төсөл, санал, санаачлагыг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй ХБИХЭДХ-ийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд нийт судалгаанд хамрагдсан оролцогчдын 66.1 хувь (330) нь хамрагдсан бол ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 14.3 хувь (76) нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 13.7 хувь (73) нь, хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ (цогц арга хэмжээ)-нд 2.4 хувь (41) нь, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд 2.6 хувь (13) нь тус тус хамрагдсан байна.

График 1. Хамрагдсан арга хэмжээ, бүсээр



- Мэдэхгүй
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээ
- Хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ (цогц арга хэмжээ)
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ
- Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ
- Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ

Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл, Q1, N=523

3.2 ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДЭМЖЛЭГИЙН ХЭРЭГЖИЛТ

Цогц арга хэмжээ



Зорилтот түвшин

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

30

79 (263%)

Үнэлгээний хүрээнд цогц арга хэмжээнд хамрагдсан хүний тоо тус бүрээр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болсон ажлын байрны тоо, бэрхшээлийн төрөл, нас хүйс, боловсрол, ямар ажлын байранд зуучлагдсан төрөл, чиглэлээр болон тус арга хэмжээ нь ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг тодруулахыг зорьсон.

Хүснэгт 7. Цогц арга хэмжээний шалгуур үзүүлэлт, судлах асуудал

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	Дэд шалгуур үзүүлэлт	Нэмэлт дүн шинжилгээ	Хөтөлбөрийн үр дүн	Хамрах он
ХБХ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо дэд арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болсон ажлын байрны тоо	<ol style="list-style-type: none"> Дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо дэд арга хэмжээ тус бүрээр Зарцуулсан хөрөнгийн хэмжээ Бий болсон ажлын байрны тоо 	<ul style="list-style-type: none"> Бэрхшээлийн төрөл, нас, хүйс, боловсрол Ямар ажлын байранд зуучлагдсан төрөл, чиглэлээр Тус арга хэмжээ нь ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх 	30 хүнийг хамруулж, ажлын байртай болгосон байна.	2021

Эх үүсвэр: Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар

2021 онд хэрэгжүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх цогц арга хэмжээний хүрээнд “30 хүнийг хамруулж, ажлын байртай болгосон байна” гэж тусгасан билээ. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг ХБХХЕГ хариуцаж ажилладаг бөгөөд 2021 оны байдлаар 14 байгууллагад 790,000,000 төгрөгийн санхүүжилт олгож 79 ажлын байрыг бий болгосон байна. Үүнээс одоогоор 68 ажлын байр нь тогтвортой буюу хамрагдсан ХБИ нь НДШ төлж байгаа ба ажлын байрны тогтвортой байдал 87 хувь байна.

Хүснэгт 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэн ажиллах байгууллагууд

№	Байгууллагын нэр	Байгууллагын регистр	Ажлын байр	Санхүүжилтийн хэмжээ
1	Итгэлт бүтээмж төв ТББ	8041229	5	50,000,000
2	Технож бизнес инкубатор төв ТББ	1088165	5	50,000,000
3	Саруул ухаан ТББ	8033226	4	40,000,000
4	Монголын хүний нөөцийн менежментийн холбоо	1042653	6	60,000,000
5	Нэг ч иргэнийг ардаа орхихгүй ТББ	8296081	5	50,000,000

6	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр сургалтын үндэсний төв	8108943	8	80,000,000
7	Хөдөө орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд туслах дэмжих төв	1077619	5	50,000,000
Нийт			38	380.000.000
1	Монголын экспорт, импортыг дэмжих үндэсний төв	8240558	5	50,000,000
2	ХБИ-дийн бизнес инкубатор төв	1081241	12	120,000,000
3	МХБИБайгууллагын үндэсний холбоо	1010239	2	20,000,000
4	"Футур" сургалтын төв	2293862	10	100,000,000
5	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо	1010964	8	80,000,000
6	Цогц үйлчилгээ ТББ	8228302	2	20,000,000
7	Сүүн сэтгэлийн дэм ТББ	8233756	2	20,000,000
Нийт			41	410.000.000
НИЙТ ДҮН			79	790.000.000

Эх үүсвэр: ХБХХЕГ, Цогц арга хэмжээний дэмжлэг үзүүлэх тушаал, 2021 он

Харин ХХҮЕГ-аас ирүүлсэн мэдээллээр нийт 271 хүн, 89 ААНБ хамрагдаж, 83 ажлын байр бий болгож 814,490,000 төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилт, дэд арга хэмжээ бүрээр

Хөтөлбөр/Арга хэмжээ		ХБХХЕГ	Нийт
Хөдөлмөрт бэлтгэх	Хамрагдсан хүний тоо	79	109
	Үүнээс: Эмэгтэй	51	71
	Сургалтын байгууллагын тоо	14	19
	Ажилд зуучлагдсан хүний тоо	41	42
	Үүнээс: Эмэгтэй	27	28
	Зарцуулсан хөрөнгө(төгрөг)		13,490.0
Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах	Хамрагдсан хүний тоо	79	79
	Үүнээс: Эмэгтэй	51	51
	Ажлын байранд зуучлагдсан хүн	41	41
	Үүнээс: Эмэгтэй	27	27
	Бэлтгэгдсэн хөтөч, дохион хэлмэрч, чиглүүлэгч, орон зайн чиг баримжааны сургагч багш	1	1
	Ажил олгогчийн тоо	21	21
	ТББ-н тоо	6	6
	Зарцуулсан хөрөнгө(төгрөг)		-
Ажлын байранд нь дадлагажуулах	Хамрагдсан хүний тоо	41	41
	Үүнээс: Эмэгтэй	26	26
	Ажил олгогчийн тоо	21	21
	Зарцуулсан хөрөнгө(төгрөг)		-
Ажлын байрны орчинд хөгжлийн бэрхшээлтэй ажилтны онцлогт нийцүүлэн хэрэгцээт	Хамрагдсан хүний тоо	41	42
	Үүнээс: Эмэгтэй	26	27
	Ажил олгогчийн тоо	21	22
	Зарцуулсан хөрөнгө (төгрөг)		10,000

тохируулга хийх			
Нийт дүн	Хамрагдсан хүний тоо	240	271
	Үүнээс: Эмэгтэй	154	175
	ААНБайгууллагын тоо	83	89
	Ажлын байрны тоо	82	83
	Үүнээс: Эмэгтэй	54	55
	Зарцуулсан хөрөнгө (төгрөг)	790,000	813,490.0
Эх үүсвэр: ХХҮЕГ-аас ирүүлсэн мэдээлэл, 2022 он			

Цогц арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэйн улмаас нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцож чадахгүй байгаа иргэдийг хамруулж, тухайн иргэдийг байнгын ажлын байртай болгож, ажлын байрандаа дадлагажих хүртэл уг үйлчилгээг 12 сарын хугацаанд үзүүлэх бөгөөд байнгын ажлын байртай болсноор цогц арга хэмжээ дуусгавар болно. ХБИ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх тус арга хэмжээг дараах байдлаар зохион байгуулдаг. Үүнд:

- Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ
- Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх
- Ажлын байранд нь дадлагажуулах
- Ажлын байрны орчинд хөгжлийн бэрхшээлтэй ажилтны онцлогт нийцүүлэн хэрэгцээт тохируулга хийх арга хэмжээнүүдийг авч ажилладаг байна.


Цогц арга хэмжээний зардлын хэмжээ нэг ажлын байранд 10.0 сая хүртэлх төгрөг байх бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөтөч, дохионы хэлний орчуулагч болон хувийн туслахын үйлчилгээг энэ зардалд багтаан хэрэгжүүлнэ гэж хөтөлбөрт заасан байна.

Авсан дэмжлэгийн хэмжээ

Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 41 иргэн, ААНБ-аас судалгаа хамрагдсанаас 25 нь ХБИ, 10 нь ТББ, 6 нь ХХК байсан. Уг цогц арга хэмжээнд төвийн бүс, хангайн бүс болон нийслэлийн 8 дүүрэг /СХД-ээс асуулгад оролцоогүй/ хамрагдсан ба эдгээр 41 иргэн, ААНБ нийтдээ 757,172,000 төгрөгийн дэмжлэг авсан байна.

Нийт дэмжлэгийн 94.2 хувь буюу 713,442,000 төгрөгийг нийслэлийн 8 дүүргийн ХБИ, ААНБ авсан байгаа ба үүнээс СБД 200,000,000 төгрөгийн дэмжлэг авсан нь хамгийн өндөр дүнтэй байна. Харин төвийн бүс 35,740,000 төгрөг, хангайн бүс 7,990,000 төгрөгийн дэмжлэг авсан.

График 2. Цогц арга хэмжээнд хамрагдагчдын авсан дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг)



Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 1, Q1, N=40


Тус арга хэмжээнд хамрагдсан ААНБ болон ХБИ дэмжлэгийн хүрээнд үүсээд байгаа бэрхшээлүүдийн талаар ганцаарчилсан ярилцлага хэлбэрээр чанарын судалгаа авсан. Судалгаагаар ХБИ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд олгогдож буй санхүүжилтийг авахад төсөлд тусгагдсан тоон дүнгээр санхүүжилт олгодоггүй, бууруулж олгож байгаа нь шаардлагатай тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн түүхий эд, материал бусад шаардлагатай хэрэгслийг цогцоор худалдан авч чадахгүйд хүрч зарим тохиолдолд бүр төслөө хэрэгжүүлэх боломжгүй болдог байна.

Мөн ковид-19 цар тахлаас шалтгаалсан эрүүл мэндийн болон санхүүгийн бэрхшээл нь үйл ажиллагааны тогтворгүй байдлыг үүсгэж байгаа тул үйл ажиллагааг тогтворжуулахын тулд санхүүжилтийг нэмэх, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөтөч, дохионы хэлний орчуулагч, хувийн туслах, ажлын байран дахь дадлагажуулагчийг тогтмол ажиллуулж хэвших шаардлагатай гэж санал бодлоо илэрхийлсэн.

Хөгжлийн бэрхшээлийн төрөл

Цогц арга хэмжээнд хамрагдсан ХБИ-ийн бэрхшээлийн төрлийг тодорхойлох асуулгад өгөгдсөн сонголтуудаас бусад гэсэн сонголтыг 33 хувь (15) нь, хөдөлгөөний бэрхшээлтэй гэж 26 хувь (12) нь, харах эрхтний бэрхшээлтэй гэсэн сонголтыг 20 хувь (9), 13 хувь (7) нь сонголын, хэл ярианы болон хавсарсан бэрхшээл тус бүр 4 хувь (3)-тай байна.

График 3. Бэрхшээлийн төрөл




Эх үүсвэр: Иргэдээс авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 1, Q3, N=46

Нас

Цогц арга хэмжээнд хамрагдсан иргэдийг насны бүлгээр харахад 40-49 насныхан 41 хувь (16), 50-59 насныхан 33 хувь (13)-ийг эзэлж байна.

График 4. Цогц арга хэмжээнд оролцсон ХБИ-ын нас




■ 40-49 нас ■ 50-59 нас ■ 20-29 нас ■ 30-39 нас ■ 60-аас дээш нас

Эх үүсвэр: Иргэдээс авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 1, Q4, N=39

Хүйс

Харин хүйсийн хувьд эмэгтэйчүүд 57 хувь (28)-ийг, эрэгтэйчүүд 43 хувь (18)-ийг эзэлж байна.

График 5. Хүйс




Эх үүсвэр: Иргэдээс авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 1, Q4, Q5, N=39

Боловсролын түвшин

Цогц арга хэмжээнд хамрагдсан ХБИ-ийн 39 хувь (16) нь бүрэн дунд боловсролтой, 24 хувь (10) нь бакалаврын боловсролтой, 22 хувь (9) нь бүрэн бус дунд боловсролтой гэж хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлтээс харахад ХБИ-ийн боловсролын түвшний 85 хувь нь бүрэн дунд, бакалавр, бүрэн бус дунд боловсролыг эзэмшсэн байгаа нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөөтэй гэсэн дүгнэлтийг хийж болно.

График 6. Цогц арга хэмжээнд оролцсон ХБИ-ийн боловсролын түвшин




Эх үүсвэр: Иргэдээс авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 1, Q6, N=45

Ажлын байрны нэр төрөл, чиглэл

ХБИ-ийн ажиллаж байгаа ажлын байрны нэр (төрөл, чиглэл)-ийг харвал 46 хувийг оёдол, эсгүүр, гагнуур, гар урлалын, харин дугуй засвар, засварын үйлчилгээ, МАА болон махны чиглэл, үсчин, гоо сайхан, маникур, бариа засал, хоол үйлдвэрлэл, цагаан идээ боловсруулах чиглэлд тус бүр 12 хувийг эзэлж байна. Үлдсэн 6 хувийг хөдөлмөрийн биржийн зуучлагч, менежер, график дизайн, теллер гэсэн чиглэл эзэлж байна.

График 7. Ажлын байрны нэр (төрөл, чиглэл)




Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 1, Q7, N=33

ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх

Асуулгад аймаг, орон нутгаас 14 иргэн, ААНБ, Улаанбаатар хотоос 24 иргэн, ААНБ хариулт өгсөн байна. Аймаг, орон нутгийн иргэдийн нийцсэн гэж хариулсан 86 хувийг задалж харвал 11 нь иргэн, 1 ААНБ багтаж байгаа бол нийцээгүй гэж хариулсан 14 хувийг задалж харвал 1 нь иргэн, 1 нь ААНБ байна.

Улаанбаатар хотын хувьд 92 хувь нь нийцсэн гэж хариулсны 13 нь иргэн, 9 ААНБ харагдаж байгаа бол үлдсэн 8 хувь нь нийцээгүй гэж хариулсан байна. (1 иргэн, 1 ААНБ). Үүнээс харахад цогц арга хэмжээ нь Улаанбаатар хотын иргэн, ААНБ-уудад нийцсэн арга хэмжээ болсон нь харагдаж байна.

График 8. ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх



Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 1, Q8, N=38

ХБИ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ нь ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байгаа шалтгааны талаар ХБИ-тэй ярилцахад үйлдвэрлэлийн түүхий эд, материалын үнэ нэмэгдсэн нь хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа ХБИ-дэд хүндээр тусч үйл ажиллагаагаа зогсооход хүрсэн тохиолдлууд их байна.

Мөн ААНБ-уудад ХБИ-ийг ажиллуулахын тулд ажлын байрны тохируулга хийхэд санхүүгийн болон тэдэнд зориулсан техник, багаж хэрэгсэл байхгүй зэрэг асуудлууд үүсдэг байна.

Кейс 1

“Эсгий шаахай хийнэ гээд хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдсан боловч одоогоор эсгий шаахайгаа хийж эхлээгүй байгаа. Эсгийний олдоц бага, түүхий эдийн үнэ нэмэгдсэн. Одоо дэлгүүр ажиллуулж байгаа.”
-БЗД-ийн иргэн Ж, Цогц арга хэмжээний дэмжлэгт хамрагдсан.

Кейс 2

“Би хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх цогц арга хэмжээнд хамрагдсан. Маш олон шинэ зүйлийг сурч мэдсэн, үр дүнтэй сургалт болсон. ХБИ-ий хөдөлмөр эрхлэхэд шаардагдах техник, багаж хэрэгслийн асуудал хүндрэлтэй байдаг.”
-ЧД-ийн иргэн О, Цогц арга хэмжээний дэмжлэгт хамрагдсан.

3.3 САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн
дэмжлэг олгох
арга хэмжээ



Зорилтот түвшин

600

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

805 (127%)

3.1 Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилт

Энэ бүлэгт сүүлийн 3 жилийн байдлаар авсан санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан иргэн ААНБ-аас авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, үр дүнг аймаг, дүүргээр тус бүр харуулах болно. Мөн ХХҮГХ-ээс ирүүлсэн санхүүгийн дэмжлэг олгох дэд арга хэмжээний авсан дэмжлэгийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харуулав.

ХХҮГХ-ээс ирүүлсэн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээд оролцож, санхүүжилт авсан ХБИ болон ААНБ-ийн тоог сүүлийн 3 жилээр харвал бүсийн хэмжээнд зөвхөн төвийн бүс өссөн үзүүлэлттэй байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд буурсан үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд харвал 2019 онд 632 иргэн байсан бол 2020 онд 7 хувиар нэмэгдэж 721 иргэн болж, 2021 онд өмнөх оноосоо 3 хувиар буурч 676 иргэнд санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Хүснэгт 10. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд оролцож санхүүжилт авсан иргэдийн тоо¹

Бүсээр	2019 он	2020 он	2021 он
Баруун бүс	105	111	110
Хангайн бүс	115	161	133
Төвийн бүс	85	121	147
Зүүн бүс	45	80	67
Бүсийн хэмжээнд	350	473	457
Баянзүрх	37	36	25
Баянгол	40	36	38
Багануур	14	15	13
Багахангай	6	5	6
Чингэлтэй	35	26	22
Налайх	17	19	14
Сүхбаатар	24	19	21
Сонгинохайрхан	76	67	52
Хан-Уул	33	25	28
Улаанбаатар хотын хэмжээнд	282	248	219
Улсын хэмжээнд	632	721	676

¹ Ногоон өнгөөр бусдаасаа харьцангуй өссөн үзүүлэлтийг тэмдэглэв.

Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 2, Q1, N=30

Зарцуулсан санхүүжилтийн хэмжээ

Зарцуулсан санхүүжилтийн хэмжээг нэгтгэж, сүүлийн 3 жилээр харахад бүсийн хэмжээнд жил бүр өссөн байна. Тодруулбал, бүсийн хэмжээнд 2019 онд 938,500,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож байсан бол 2020 онд 13 хувиар өсч 1,207,700,000 төгрөг болж, 2021 онд өсөлтөө хадгалан 8 хувиар өссөнөөр 1,423,178,900 төгрөг болсон байна. Харин Улаанбаатар хотын хэмжээнд 2019 онд 978,950,000 төгрөг байсан бол 2020 онд 16 хувиар буурч 714,600,000 төгрөг болсон бол 2021 онд 10 хувиар нэмэгдэж 874,500,000 төгрөг хүрсэн. Нийт өсөн дүүргээс тогтмол БНД, СХД тогтмол өсөлттэй байна.

Улсын хэмжээнд 2019 онд 1,917,450,000 төгрөг, 2020 онд 1,922,300,000 төгрөг санхүүгийн дэмжлэг олгосон бол 2021 онд өмнөх оноос 9 хувиар өсч 2,297,678,900 төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Хүснэгт 11. Зарцуулсан санхүүжилтийн хэмжээ² /мянган төгрөг/

Он	2019 он	2020 он	2021 он
Баруун бүс	229,000	304,000	361,000
Хангайн бүс	317,000	406,000	476,000
Төвийн бүс	252,500	312,700	370,178
Зүүн бүс	140,000	185,000	216,000
Бүсийн хэмжээнд	938,500	1,207,700	1,423,178
Баянзүрх	175,000	115,000	129,000
Баянгол	155,000	105,000	136,000
Багануур	45,000	35,000	56,000
Багахангай	30,000	25,000	28,000
Чингэлтэй	113,000	74,600	100,000
Налайх	60,000	60,000	57,500
Сүхбаатар	108,950	80,000	100,000
Сонгинохайрхан	162,000	140,000	168,000
Хан-Уул	130,000	80,000	100,000
Улаанбаатар хотын хэмжээнд	978,950	714,600	874,500
Улсын хэмжээнд	1,917,450	1,922,300	2,297,678

Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 2, Q2, N=30

ХБИ-ийн авсан дэмжлэгийн хэмжээ


Судалгаанд оролцсон нийт 523 хүнээс уг арга хэмжээнд 349 хүн хамрагдаж нийт 2,272,900,000 төгрөгийн дэмжлэг авсан байна. Дэмжлэгийн мөнгөн дүн дээд тал нь 5,000,000 төгрөг, доод тал нь 120,000 төгрөг байна.

Дэмжлэгийн хэмжээ хэт бага байх нь хөтөлбөрийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, иргэнд санхүүгийн дэмжлэг олгох хэмжээ нь ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцээгүй байгаа нь үнэлгээнээс харагдлаа. Үүний шалтгаан нь төсөлд бичигдсэн мөнгөн дүнгээр дэмжлэгийн хэмжээг олгодоггүй, олон хүн хамруулахын тулд бага хэмжээгээр дэмжлэг өгдөг нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд бодитой дэмжлэг болж чадахгүй байгаа нь чанарын судалгаагаар харагдсан.

² Ногоон өнгөөр бусдаасаа харьцангуй өссөн үзүүлэлтийг тэмдэглэв.

Энэхүү дэмжлэгт хамрагдсан оролцогчдын авсан дэмжлэгийн хэмжээг бүс, дүүргээр тус бүрээр харахад хангайн бүс 402,500,000 төгрөгийн дэмжлэг авсан нь хамгийн өндөр байгаа бол Багануур дүүрэг 20,000,000 төгрөгийн дэмжлэг авсан нь бусдаас хамгийн бага байна.

График 9. Эргэн төлөх нөхцөлтэйгээр авсан дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг)




Эх үүсвэр: Иргэдээс авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 2, Q1, N=40

Ажлын байрны тогтвортой байдал (Иргэн)

Ажлын байрны тогтвортой байдлыг тодорхойлох асуулгад нийт (297) хариулсан иргэдийн 82 хувь нь тогтвортой харин үлдсэн 18 хувь нь тогтворгүй гэж хариулсан байна.

График 10. Ажлын байрны тогтвортой байдал иргэдийн хариулсан байдал



Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 2, Q3, N=297

Чанарын судалгаа хийх явцад гэрээрээ бичил бизнес эрхэлдэг иргэд зээлийн хэмжээ бага, эргэн төлөх хугацаа нь богино байна, иймд санхүүжилтийн хэмжээг нэмж, төлөх хугацааг уртасгавал бидэнд илүү бодит дэмжлэг болно гэж дийлэнх хувь нь хариулсан. Мөн тэдэнд хүн сургаад ажиллуулах хүсэл байдагч тогтвортой ажиллах хүн олддоггүй тухай өгүүлсэн.

Кейс 3

“Хонь, сарлагийн ноосоор гэрийн бүслүүр томж хийдэг. Өрхийн бизнес нь тогтвортой болсон. Нөхөр, хүүтэйгээ 3-лаа гэр бүлээрээ хийж байна. Зээл их дэм болж материалаа хангалттай авч чадсан болохоор үйл ажиллагаа тасралтгүй явагдаж

байна. Зээлээ хугацаандаа төлдөг. Орлого нэмэгдсэн болохоор саалийн үнээ худалдаж авсан. Нэмж хүн сургаж авах хэрэгтэй байна.”

-Багануур дүүргийн иргэн Э, 2 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Зураг 12. Судалгаанд хамрагдсан Багануур дүүргийн ХБИ Э-ийн гэрийн бүслүүр томж, борлуулах өрхийн бизнес



Дараагийн кейс болох ХБИ Г-ийн хөдөлмөр эрхлэлтийн сангаас авсан санхүүжилтээр эрхэлж байгаа өрхийн бизнесийн үйл ажиллагаа нь тогтворгүй, зээлээ зөв зарцуулсан эсэх нь эргэлзээтэй байсан. Үүнээс харахад зээл авсан иргэдэд өрхийн бичил бизнес эрхлэхэд санхүүгээ хэрхэн зөв удирдах чадвар эзэмшүүлж, ХХҮГХ-ээс эргэх холбоотой байж, зөвлөгөө мэдээлэл хангалттай өгч байх хэрэгтэй гэж үзэж байна.

Кейс 4

“Гар хатгамал оёдог. Хөдөө сүү цагаа, малаар сольж борлуулдаг. Хөдөөнөөс л захиалга ирдэг, их захиалдаг болсон. Бүтээгдэхүүн борлуулсан ашгаасаа хашааны хаалга авсан. Энэ зээл надад их хэрэг болсон.”

-Багануур дүүргийн иргэн Г, 1 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Зураг 13. Судалгаанд хамрагдсан ХБИ Г-ын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал



Ковид-19 цар тахал, түүхий эд, материалын үнийн өсөлт, хил гаалийн асуудлаас болж санхүүгийн хүндрэлд орсноор үйл ажиллагаагаа түр зогсоосон, мөн эргэн төлөлтөө хийж чадахгүйн улмаас асуудал шүүхийн байгууллага руу шилжсэн тохиолдлууд байсан.

Кейс 5

“Охин 18 настай, цусны өвчтэй. Би өөрөө мөн группд байдаг. Охин сургуульд явдаг, шүрээр юм хийж зардаг. Шүрээр юм хийх гэж дэмжлэг авсан. Одоогоор шүрээр юм хийхгүй байгаа. Эргэн төлөлтөө 2, 3 удаа хийж байтал хол хорионд ороод бизнесгүй болсон.”

-СХД-ийн 8-р хорооны иргэн О, 2 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 6

“Түүхий эдээ авах санхүүгийн боломжгүй. Үнэ өссөн. Юмны үнэ өсөөд бусад түүхий эдээ авч чадаагүй. Уг үйлдвэрлэл маань ажиллаагүй учир орлого олж чадаагүй. Иймээс эргэн төлөлтөө хийж чадаагүй учир одоо шүүхэд шилжээд байна. Одоо зээл төлөх санхүүгийн эх үүсвэр байхгүй, цалингийн зээлтэй, энэ жил тэтгэвэрт гарна. Хүүхдүүд ажилгүй тул тэднээс ямар нэгэн дэмжлэггүй. Зээлийн төлөлтөөс чөлөөлөх, хөнгөлүүлэх хүсэлт тавьмаар байна.”

-Сүхбаатар аймаг Баруун-Урт сумын иргэн Б, 3 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 7

“Аймгийн төвд өрсөлдөгч цехүүд ихэссэн, гол материал болох бууцай хил хаасантай холбогдон олдоц багадсан, үнэтэй болсны улмаас 2021 оны 4 сараас үйл ажиллагаагаа зогсоосон.”

-Завхан аймаг Улиастай сумын иргэн Б, 4.5 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Хамрагдсан иргэдийн ангилал

Судалгааны мэдээллээс улсын хэмжээнд 1,275 нь өрхийн үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч ХБИ-д, 115 нь байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эхчүүдэд санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Бүсийн хэмжээн дэх харьцуулалт:

- ХБИ-тэй нийт 783 иргэнийг 100 хувь гэж үзвэл хангайн бүсээс 307 (39 хувь) нь иргэн хамрагдсан нь бусад бүсээс харьцангуй өндөр байна.
- Харин байнгын асаргаанд байдаг хүүхдээ асардаг нийт 58 эцэг, эхийг 100% гэж үзвэл төвийн бүсээс 29 (50 хувь) нь эцэг, эхэд дэмжлэг олгосон нь бусад бүсээс харьцангуй өндөр байна.

Хамрагдсан иргэдийн ангиллыг дүүрэг тус бүрээр харьцуулахад:

- ХБИ-тэй нийт 492 иргэнийг 100 хувь гэж үзвэл Баянгол дүүрэг 114 (23 хувь) нь иргэн хамрагдсан нь бусад дүүргээс харьцангуй өндөр байна.
- Харин байнгын асаргаанд байдаг хүүхдээ асардаг нийт 57 эцэг, эхийг 100 хувь гэж үзвэл Чингэлтэй дүүргийн 19 (хувь) нь эцэг, эхэд дэмжлэг олгосон нь бусад дүүргээс харьцангуй өндөр байна.

Хүснэгт 12. Хамрагдсан иргэний ангилал

Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох	Өрхийн үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч ХБИ		Байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эх	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хангайн бүс	307	39%	10	17%
Төвийн бүс	190	24%	29	50%
Баруун бүс	181	23%	6	10%
Зүүн бүс	105	13%	13	22%
Бүсийн хэмжээнд	783	100%	58	100%
Баянгол	114	23%	2	4%
Баянзүрх	81	16%	8	14%
Багануур	73	15%	0	0%
Сүхбаатар	57	12%	7	12%
Сонгинохайрхан	52	11%	-	-
Налайх	47	10%	3	5%
Чингэлтэй	41	8%	19	33%
Хан-Уул	15	3%	13	23%
Багахангай	12	2%	5	9%
Улаанбаатар хотын хэмжээнд	492	100%	57	100%
Улсын хэмжээнд	1,275		115	

Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 2, Q2, N=30

Иргэн, ААНБ-аас авсан судалгааны хүрээнд цогц арга хэмжээнд хамрагдсан нийт (237) асуулгад хариулсан оролцогчдийн 76 хувийг өрхийн үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч ХБИ, 24 хувийг байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эхчүүд эзэлж байна.

График 11. Хамрагдсан иргэдийн ангилал



Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 2, Q4, N=237

Чанарын судалгаагаар байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эхчүүдийн ажлын нөхцөл байдалтай танилцсан бөгөөд ярилцлага хийх үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд /цаашид ХБХ гэх/-ийн онцлогоос хамаарч тэдгээр хүүхдүүд төрөл бүрийн зан араншин гаргаж, байнгын асаргаа шаардаж байсан нь ярилцлагыг удаашруулсан.

Энэ үйлдлээс харахад ХБХ болон ХБИ асардаг хүмүүст хөдөлмөр эрхлэхэд хэр хүндрэл үүсдэг болох нь харагдаж байна. Иймд ХБИ болон ХБИ-ийг асардаг хүмүүст хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг нь өсгөхийн тулд ХБХ-ийг асарч, тэдэнд боловсрол болон бие даах чадвар олгох төвүүд бий болгох эсвэл өдөр өнжүүлэх төвүүд сайн дураар ХБХ-ийг авсан тохиолдолд улсаас урамшуулал олгодог болговол хөдөлмөр эрхэлж байгаа эцэг, эхийн бүтээмж сайжирна гэж үзэж байна. Мөн СӨБ, ЕБС-ийн багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогийн талаарх сургалтанд хангалттай хамруулах шаардлагатай.

Кейс 8

“Өрх толгойлсон ээж. Баруун хөлний дунд чөмөгний ургалт гэсэн оноштой, байнгын асаргаатай, 8 настай охинтой. Ажлын байрыг бага хүүтэй зээл маягаар өгөх юм бол том дэмжлэг болно гэж боддог. Дэмжлэгийг оёдол, мах махан бүтээгдэхүүн худалдан боловсруулах, цаашлаад үйлдвэр болох зорилготой авсан. Санхүүжилтийг хөнгөлөлттэй нөхцөлөөр өгөх нь зүйтэй. Өөрсдийн гэсэн юмтай болчихвол хүүхдээ нэг газар аятайхан байлгачихаад юмаа зарвал өөр. Гэрээр юм хийгээд онлайнээр юм зарна, хүргэж өгнө, хүргэж өгөхдөө хүүхдээ дагуулж явна гэх мэт асуудал их байдаг.”

-СБД-ийн 14-р хорооны иргэн О, 5 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 9

“4 мөчний саажилттай, нүд зөвхөн гэрэл мэдрэх чадвартай, 7 хүрэх эмэгтэй хүүхэдтэй. Хүүхэд байнгын асаргаанд байдаг. Байнгын асаргаатай хүүхэдтэй болохоор хүүхдээ үргэлж асарсаар таардаг. Зунаас гайгүй болвол эргээд ажиллаж эхэлнэ. Үндэсний дээл, биеийн тамирын хослол, хүрэм гэх мэт оёдог. Үйл урлал төсөл бичсэн. 4 жил хийж байгаа. Хүүхдээ 168 цэцэрлэгт өгөх гээд очсон чинь танай хүүхэд гадагшаа ямар нэг харилцаа байхгүй учир танай хүүхдийг авахгүй гэсэн. Хүүхэд харах сувилал хэлбэрийн үйлчилгээ хэрэгтэй байна.”

-СБД-ийн 14-р хорооны иргэн М, 4 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 10


“ХБ-тэй хүүхдийн эцэг эхийг төрөөс бүхий л төрлөөр харж үзэж дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. ХБХ-ээс болоод гэр бүлийн асуудал их гардаг. Эдгээр хүүхдүүдийн биеийн байдал нь маш хүнд. Байнга таталт өгнө, цэрэндээ хахана гэх мэт. Гэр бүлийн гишүүд ямар ч ажил хийх боломжгүй, байнгын асаргаа шаарддаг.”

-ХУД-ийн 13-хорооны иргэн У, 3 сая төгрөгийн дэмжлэг авсан.

ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх

ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх асуулгад аймаг, орон нутаг дахь ХХҮГХ-ийн мэргэжилтэнгүүд 93 хувь нь нийцсэн, 7% хувь нь нийцээгүй гэсэн бол Улаанбаатар хотын хувьд 100 хувь нийцсэн гэж хариулсан байна. Харин аймаг, орон нутаг, Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан иргэд, ААНБ-үүд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг эрэлт хэрэгцээнд нийцсэн гэж үзсэн. Барьцаагүй, хүүгүй, 50 хувийн эргэн төлөх нөхцөлтэй, 36 сарын хугацаатай, 3.0-5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг ХБИ-дийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа нь харагдаж байна.

График 12. ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх



Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 2, Q5, N=292

Дэмжлэг авсан иргэдтэй ярилцахад тогтвортой ажлын байртай болсноор үйл ажиллагаагаа өргөжүүлж, ХБИ-ийг ажлын байраар хангаж, өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг бий болгож байгаа боловч бараа бүтээгдэхүүний үнэ өсч нийгэм, эдийн засгийн байдал хүндэрч байгаа энэ үед дэмжлэгийн хэмжээг нэмэхгүй бол олсон орлого нь эргэлтийн хөрөнгө болж чаддаггүй байна гэсэн.

Кейс 11

“Эсгий эдлэлээр бүх төрлийн гар урлал, бэлэг дурсгалын зүйлийг хийж худалдаанд гаргадаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсанаар өөрийн сонирхолтой хоббигоо хөгжүүлэн ажиллаж байгаадаа баяртай байдаг.”

-Дорнод аймгийн иргэн Н, 3 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 12

“Ам бүл 5. Эхнэр ажилгүй. 3 хүүхэд ойролцоо насных, амьдрал тааруухан байна. Би багаасаа бор амьдралд өссөн болохоор энэ хөтөлбөрт хамрагдсанаар ажилгүй, орлогогүй, амьжиргааны түвшин доогуур айл өрхийн 5 залууг авч ажиллуулж ажлын байртай болгон амьдралыг нь дээшлүүлсэн. Хүн ажлыг голохгүй хийх нь зөв гэдгийг ойлгуулсан.”

-Дундговь аймгийн Сайнцагаан сумын иргэн Д, 5 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 13

“2 удаа сургалтанд хамрагдсаны дараа дэмжлэгээ авсан, маш их үр дүн гарсан. Цаашид олгож буй мөнгөн дүнгийн хэмжээг 10 саяас багагүй байвал илүү их нэмэртэй байна.”

-Налайх дүүргийн иргэн Б, ХБХ-тэй ээж, 3 сая төгрөгийн дэмжлэг авсан, Монгол гэрийн шал хийж, Нарантуул зах дээр борлуулдаг.

Кейс 14

“Одоогоор ажлын байргүй болсон тул хотод өөрийн тоног төхөөрөмжүүдээ зөөж гагнуур хийж байгаа.”

-Налайх дүүргийн иргэн М, 3 сая төгрөгийн дэмжлэг авсан, Гагнуур хийдэг.

Кейс 15

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 5 сая төгрөгийн төсөл бичиж оролцоод 1,500,000 төгрөгийн санхүүжилт авсан. Төсөлд бичсэнээр санхүүжилтийг олгож байвал хэрэгтэй байна. Ингээд хасаад олгохоор юм хийхэд хаанаа ч хүрэлцэхгүй нийцэхгүй байна.”

-Булган аймгийн Булган сумын иргэн Э, Амьтны эврэн гар урлал

Кейс 16


“2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан, нэг саяыг нь буцаагаад төлнө. Юм үнэтэй болохоор энэ мөнгөөр материал авсан. Жижиг санхүүдээ баригдаад жижиг зүйл хийж байна. 5 сая төгрөгийн төсөл бичсэн. 5 сая төгрөгөө авсан бол байрандаа канзан машин авч, засвар хийгээд, манекан гэх мэт авах байсан”.

-СХД, 26-р хорооны иргэн Л, 2 сая төгрөгийн дэмжлэг авсан.

3.3.2 ТББ-д санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилт

ТББ-уудад олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээг харвал 2019 онд 665,000,000 төгрөг байсан бол 2020 онд 10 хувиар өсч 805,000,000 төгрөг болсон. Харин 2021 онд 18 хувиар буурч 560,000,000 төгрөг болсон байна.

График 13. ТББ-уудад олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг)




Эх сурвалж: ХБХХЕГ, Санхүүгийн дэмжлэгийн тушаал, 2019-2021 он

ТББ-д эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгож байгаа нь зөв эсэх

Судалгаанд оролцсон 110 ТББ-ын 77 хувь нь санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгож байгаа нь зөв гэсэн бол 21 хувь нь хэлж мэдэхгүй байна, 2 хувь нь буруу гэж хариулсан байна.

График 14. ТББ-д эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгож байгаа нь зөв эсэх



Эх үүсвэр: ТББ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 2, Q6, N=109

ТББ-ын захирлуудтай ярилцахад эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгогдож байгаа дэмжлэг нь ХБИ-ийг дэмжсэн үр өгөөжтэй арга хэмжээ мөн бөгөөд авсан дэмжлэгээрээ

ажлын байр, тоног төхөөрөмжөө шинэчилж, ажлын байрны тоогоо нэмэгдүүлэн тогтвортой үйл ажиллагааг явуулж байна гэж үзсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ТББ-ын захирлууд ажилчдаа ойлгож, тэднийг хөгжүүлж, хувь хүний хөгжилд нь анхаарч ажилладаг нь харагдаж байсан. Түүнчлэн ТББ-уудын удирдлагууд ХБИ-ийг цагийн менежмент сайн, ажил голдоггүй, цалин голдоггүй, ажлыг сэтгэлээсээ хийдэг, мөн ХБИ нь ажил хийх чинь хүсэлтэй, нийгмээс гадуурхагдахгүй хамт олонтой байх хүсэл, тэмүүлэл их байдаг хэмээн ярьж байсан юм. Иймд тэднийг чадваржуулах сургалтанд хамруулж, тогтвортой ажлын байраар хангаж энэхүү арга хэмжээг үргэлжлүүлэн, сайжруулах хэрэгцээ зайлшгүй байна.

Кейс 17

“ТББ–д эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр олгож байгаа нь зөв гэж үзэж байна. Түрээсийн төлбөр зэргээс эхлээд бүх зүйлээ өөрсдөө төлдөг учраас буцаан төлөхгүй байх нь байгууллагын дэмжлэг юм. Энэ нь төртэй түншлэгч ТББ-уудад нэг гарц, маш сайн дэмжлэг болж байгаа. ХБИ-ийг ажилд авахад давуу талууд байдаг. Цалин голдоггүй, ажил голдоггүй, цаг баримталдаг. Тэр тусмаа оюуны бэрхшээлтэй хүмүүс цаг сайн барьдаг, ажлыг сэтгэлээсээ хийдэг деталь ажлуудыг сайн хийдэг.”

-ХУД-ийн 2-р хороо, “Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо” ТББ, 20 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 18

“Буцалтгүй эргэн төлөлтгүй зээл нь бидэнд маш их дэмжлэг болсон бөгөөд би цэцэрлэгийн өргөтгөлөө бариад дуусаж байгаа. Дуусаад дахин шинээр 6 ажлын байр нэмэгдэнэ. 2 ХБИ авах хүсэлтэй байгаа.”

-ХУД-ийн 9-р хороо, “Эрдэнэсийн авдар” ТББ, 20 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 19


“Би өөрөө ХБИ. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэхээрээ л дандаа туслах, хар бор ажил хийх ёстой юм шиг хандлага их байдаг. Яагаад ХБХ сурч хөгжөөд, өөрийн хүссэн ажил хөдөлмөрөө хийж болохгүй гэж, боломжийг нь бүрдүүлж өгөх хэрэгтэй байна. Манай байгууллага спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. ХБИ-ийн эрүүл мэндэд анхаарсан дасгал хөдөлгөөн зэргийг зааж, сургадаг.”

-ЧД-ийн 11-хороо, “Аххилис Монгол” ТББ, 20 сая төгрөгийн дэмжлэг авсан.

3.3.3 Аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилт

ААН-үүдэд олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 2019 оны байдлаар 245,000,000 байсан бол 2020 онд 36 хувиар буурч 115,000,000 болсон бол 2021 онд 69 хувиар нэмэгдэж 620,000,000 төгрөгт хүрсэн. Уг арга хэмжээний хүрээнд сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 980,000,000 төгрөгийн дэмжлэгийг аж ахуйн нэгжүүдэд олгоод байна. Эргэн төлөх нөхцөлтэйгээр санхүүгийн дэмжлэгт 2019 онд 18 байгууллага, 2020 онд 11 байгууллага хамрагдсан бол 2021 онд 32 байгууллага, өнгөрсөн 3 жилийн хугацаанд нийт 61 байгууллага санхүүгийн дэмжлэг авсан байна.

График 15. ААН-үүдэд олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг)



Эх сурвалж: ХБХХЕГ, Санхүүгийн дэмжлэгийн тушаал, 2019-2021 он

Эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдсан 30 аж ахуйн нэгж үнэлгээнд хамрагдсан. ААН-ын үйл ажиллагааны чиглэлийн хувьд гар урлал (оёдол эсгүүр, мужаан, модон эдлэл, арьс ширэн эдлэл), компьютерийн бүх төрлийн үйлчилгээ болон гэрэл зураг, газар тариалангийн (хүнсний ногоо) чиглэлээр түлхүү үйл ажиллагаа явуулж байгаа нь доорх графикаас харагдаж байна.

График 16. Үйл ажиллагааны чиглэл (ААН)




Эх үүсвэр: ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 2, Q7, N=194

Зээлийн эргэн төлөлт

100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгээр 36 сарын хугацаатай олгосон 20 хүртэлх сая төгрөгийн (ХБИХЭДХ-ийн 5.3 заалт) санхүүгийн дэмжлэгт 2019 онд хамрагдсан 18 байгууллагын эргэн төлөлт (нийт үлдэгдэл 137 сая сая төгрөг) 40 хувьтай байна. Харин 2020 онд санхүүгийн дэмжлэг авсан 11 байгууллагын эргэн төлөлт (нийт үлдэгдэл 99 сая төгрөг) 13.5 хувьтай байна. Энэ нь Монгол улсад дэгдсэн Ковид-19 цар тахлын улмаар хөл хорио тогтоосон болон зах зээл хумигдсантай холбоотой юм. 2021 онд санхүүгийн дэмжлэг авсан 32 байгууллагын эргэн төлөлт (нийт үлдэгдэл 569 сая төгрөг) 7.2 хувьтай байна.

График 17. Зээлийн эргэн төлөлтийн хувь



Эх сурвалж: ХБХХЕГ, Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн мэдээ, 2019-2021 он

НДШ төлдөг эсэх болон төслийн тогтвортой байдал

Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд оролцсон ААН-ын НДШ төлдөг эсэх асуулгад 67 хувь нь төлдөг, 33 хувь нь төлдөггүй гэсэн байна. Харин График 18-д ААН-үүдийн 92 хувь нь төсөл тогтвортой, 8 хувь нь тогтворгүй гэж хариулсан байна.

График 18. НДШ төлдөг байдал





График 19. Төслийн тогтвортой байдал



Эх үүсвэр: ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 2, Q8-N110, Q9-97

Кейс 20

“Цаашид дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй. Ковидын нөхцөл байдалд эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах гэх мэт дэмжлэг үзүүлж байвал сайн байна.”
-ЧД-ийн 5-р хороо, “МЕТАХИКО” ХХК, 10 сая төгрөгийн дэмжлэг авсан, фото зургийн студийн үйлчилгээ үзүүлдэг.

3.4 АЖИЛ ОЛГОГЧИД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ХБИ-нд ажлын
байр бий
болгосон ажил
олгогчийн
дэмжлэг



Зорилтот түвшин

80

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

44 (55%)

Аймаг, дүүргийн ХХҮГХ-ээс авсан мэдээллийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх асуулгыг аймаг болон дүүргээр тоон үзүүлэлтүүдийг харуулсан. Асуулгын хүрээнд нийт 15 аймаг, 7 дүүргийн мэдээллийг нэгтгэв.

Орон нутгийн хэмжээнд ХБИ-ийг дэмжих тус арга хэмжээнд хамрагдсан ажил олгогчийн тоо 2020 онд өмнөх оноос нэгээр буурч 22 болсон бол 2021 онд шинээр 17 нь ажил олгогч нэмэгдэж 39 болсон байна. Харин Улаанбаатар хотын хэмжээнд 2020 онд шинээр 13 ажил олгогч нэмэгдэж 35 болсон бол 2021 онд 3 ажил олгогч тус арга хэмжээнээс татгалзаж 32 болж буурсан байна. Улсын хэмжээнд сүүлийн 3 жилийн байдлаар энэхүү арга хэмжээнд хамрагдах ажил олгогчийн тоо өсөж байгаа нь сайн үзүүлэлт билээ.

Хүснэгт 13. Хамрагдсан ажил олгогчдын тоо

Аймаг, дүүргүүд	2019 он	2020 он	2021 он
Архангай	3	-	5
Булган	3	1	-
Дорнод	2	4	3
Орхон	3	1	1
Сэлэнгэ	2	3	2
Төв	1	-	-
Ховд	2	5	7
Хөвсгөл	1	3	3
Хэнтий	2	4	3
Өвөрхангай	2	-	-
Говьсүмбэр	2	-	-
Дундговь	-	1	3
Говь-Алтай	-	-	2
Дархан-Уул	-	-	9
Дорноговь	-	-	1
Аймгийн хэмжээнд нийт	23	22	39
Баянзүрх	2	1	2
Налайх	17	19	14
Сүхбаатар	1	3	2
Хан-Уул	2	3	3
Чингэлтэй	-	1	3
Баянгол	-	8	5
Сонгинохайрхан	-	-	3

Улаанбаатар хотын хэмжээнд нийт	22	35	32
Улсын хэмжээнд	45	57	71

Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 3, Q1, N=22

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид сүүлийн 3 жилийн байдлаар зарцуулсан хөрөнгийн хэмжээг харьцуулан харвал:

- Аймгийн хэмжээнд 2020 оны зарцуулсан хөрөнгийн хэмжээ өмнөх оныхоос 12 хувиар буурч 91,480,000 төгрөг зарцуулсан бол 2021 онд 26 хувиар нэмэгдэж 156,080,000 төгрөг зарцуулсан байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд 2020 оны зарцуулсан хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 10 хувиар нэмэгдэж 94,800,000 төгрөг зарцуулж байсан бол 2021 онд дахин 18 хувиар нэмэгдэж 137,820,000 төгрөг зарцуулав.
- Улсын хэмжээнд 2019 онд 193,868,000 төгрөг заруулж 2020 онд 2 хувиар буурч 186,280,000 төгрөг, 2020 онд 22 хувиар нэмэгдэж 293,900,000 төгрөг зарцуулаад байна.

Хүснэгт 14. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (мянган төгрөг)

Аймаг, дүүргүүд	2019 он	2020 он	2021 он
Булган	35,040	5,040	-
Говьсүмбэр	15,120	-	-
Орхон	10,800	-	5,040
Ховд	10,368	23,200	35,280
Архангай	10,000	-	25,200
Өвөрхангай	7,980	-	-
Төв	6,640	4,440	-
Дорнод	5,760	17,180	14,950
Сэлэнгэ	5,760	12,020	10,080
Хэнтий	5,760	17,180	14,950
Хөвсгөл	2,880	12,420	24,900
Говь-Алтай	-	-	7,680
Дорноговь	-	-	10,080
Өмнөговь	-	-	2,880
Сүхбаатар	-	-	5,040
Аймгийн хэмжээнд нийт	116,108	91,480	156,080
Налайх	60,000	60,000	57,500
Хан-Уул	7,440	13,220	5,040
Баянзүрх	7,280	4,040	10,080
Сүхбаатар	3,040	12,320	10,080
Чингэлтэй	-	4,440	15,120
Баянгол	-	780	24,880
Сонгинохайрхан	-	-	15,120
Улаанбаатар хотын хэмжээнд	77,760	94,800	137,820
Улсын хэмжээнд	193,868	186,280	293,900


Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 3, Q2, N=22

Харин иргэн, ААНБ-аас авсан судалгаанд ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдаж, дэмжлэг авсан иргэн, ААНБ-аас 63 хүн судалгаанд хамрагдсан байна.

Нийт (350,604,000 төгрөг) авсан дэмжлэгийн мөнгөн дүнг бүс болон дүүргээр харьцуулан бусдаасаа хамгийн өндөр хэмжээний дэмжлэг авсан бүс, дүүргийг харвал:

- Бүсүүдээс хангайн бүс 75,540,000 төгрөгийн дэмжлэг авсан нь хамгийн өндөр байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд Сонгинохайрхан дүүрэг 30,120,000 төгрөгийн дэмжлэг авсан нь мөн адил хамгийн өндөр дэмжлэг байна.

График 20. ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчийн авсан дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг)



Эх үүсвэр: ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 3, Q1, N=63

Бий болгосон ажлын байрны тоо болон хадгалсан ажлын байрны тоо

Сүүлийн 3 жилд аймгийн болон Улаанбаатар хотын хэмжээнд бий болгосон ажлын байрны тоо болон хадгалсан ажлын байрны тоо тогтвортой өссөн. Харин Улаанбаатар хотын хэмжээнд 2019 онд 45 байсан бол 2020 онд бий болгосон ажлын байрны тоо 14-өөр буурч 31 болсон бол 2021 онд 12 ажлын байраар нэмэгдэж 43 хүрчээ.

Хүснэгт 15. Дэмжлэг авсан ААН-ын ажлын байр бий болгосон болон хадгалсан ажлын байрны тоо

Аймаг/дүүрэг	2019 он		2020 он		2021 он	
	Бий болгосон ажлын байрны тоо	Хадгалсан ажлын байрны тоо	Бий болгосон ажлын байрны тоо	Хадгалсан ажлын байрны тоо	Бий болгосон ажлын байрны тоо	Хадгалсан ажлын байрны тоо
Орхон	4	2	1	1	-	-
Дорнод	3	3	2	2	1	1
Говьсүмбэр	2	2	4	4	3	3
Сэлэнгэ	2	2	3	3	2	2
Төв	2	2	-	-	-	-
Ховд	2	2	5	5	7	7
Өвөрхангай	2	2	4	4	3	3

Хөвсгөл	2	2	-	-	-	-
Хэнтий	1	1	3	3	5	5
Булган	-	-	-	-	-	-
Говь-Алтай	-	-	-	-	2	-
Дорноговь	-	-	-	-	2	2
Өмнөговь	-	-	-	-	1	1
Сүхбаатар	-	-	-	-	1	1
Аймгийн хэмжээнд нийт	20	18	22	22	27	25
Баянзүрх	26	26	27	27	20	20
Баянгол	11	15	2	-	5	12
Налайх	2	2	1	1	3	3
Сүхбаатар	2	2	3	3	3	3
Хан-Уул	1	-	3	-	2	2
Чингэлтэй	-	-	1	-	3	-
Сонгинохайрхан	-	-	-	-	3	3
Улаанбаатар хотын хэмжээнд	42	45	37	31	39	43

Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 3, Q3, Q4, N=21

ХХҮГХ-ээс мэдээлэл авах үед Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр төсөл хариуцсан мэргэжилтнүүдтэй ярилцахад ХБИ-ийг чанартай сургалтаар хангаж байж ажлын байранд тогтвортой ажиллах боломж нь нэмэгдэх учир сургалтын чанарыг сайжруулах хэрэгтэй тухай хэлж байсан. Түүнчлэн хөтөлбөрт хамрагдаж, ажилд орж байгаа ХБИ-ийн ихэнх нь хөнгөн бэрхшээлтэй иргэд байдаг. Ковид-19 цар тахлын улмаас жижиг ААН-үүдийн үйл ажиллагаа зогссон гэсэн.

ХБИ-ийг хувийн хэвшлийнхэн дэмжиж ажилладаг, харин төрийн байгууллагууд энэ тал дээр хариуцлагагүй хандсаар ирсэн бөгөөд ХБИ-ийг ажилд авдаггүй гэсэн байна.

Кейс 21


- ХБИ-г ажилд зуучлахаасаа өмнө сургалтанд хамруулж байж ажилд оруулах нь зөв.
- Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрөөр ажилд орж байгаа хүмүүс нь дандаа хөнгөн бэрхшээлтэй хүмүүс ажилд ороод, хүнд бэрхшээлтэй хүмүүс ажилд орж чадахгүй байна.
- Цар тахлын улмаас жижиг ААН-д зогсонги байдалд орсон.
- Төрийн байгууллагууд ХБИ-ийг ажилд авч ажиллуулах тал дээр хувийн хэвслээсээ дор хариуцлагагүй ханддаг.

-ХУД-ийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр" төсөл хариуцсан мэргэжилтэн

Хамрагдсан иргэдийн бэрхшээлийн төрөл

Дэмжлэгт хамрагдсан ХБИ-ийн бэрхшээлийн төрлийг харвал хөдөлгөөний, харах эрхтний бэрхшээлтэй хүмүүс бусад бэрхшээлийн төрлөөс их байна.

График 21. Хамрагдсан иргэдийн бэрхшээлийн төрөл, хувиар



Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 3, Q5, N=15

Хамрагдсан иргэний бэрхшээлийн төрөл

ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдаж ажилд орсон иргэдийн бэрхшээлийн төрлөөс хамгийн их хувийг эзэлсэн 3 бэрхшээлийг харвал, 23 хувь нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 20 хувь нь харах эрхтэний бэрхшээл, 18 хувь нь бусад хэлбэрийн бэрхшээлтэй байна.

График 22. Хамрагдсан иргэний бэрхшээлийн төрөл



Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 3, Q4, N=65

Чанарын судалгаагаар ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдаж, ажилд орсон иргэдийн бэрхшээлийн төрлөөс үл хамааран тогтвортой сайн ажиллаж байгаа хүмүүс олон байна.

Харин зарим ажил олгогчид ажлын гүйцэтгэл муутай, ачаалал даадаггүй ХБИ-ийг ч нийгэмшүүлэх зорилгоор тогтвортой ажлын байраар хангаж, НДШ-ийг тасралтгүй төлж байгаа жишээнүүд цөөнгүй байна.

Кейс 22

“Манай компани хорих ангиас ял эдлээд гарсан ХБИ-ийг хоёр жил ажиллуулж байна. Тус иргэний нийгмийн даатгалыг төлж байгаа.”

-Хэнтий аймгийн Хэрлэн сум, “Дэвжих тамир” ХХК, 6 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 23

“Хоёр сонсголын бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Ажлын байраа хадгалж байгаа. Нийгмийн даатгалыг нь төлж 2 жил ажиллуулж байна.”

-Дорнод аймгийн Хэрлэн сумын иргэн А, 3,840,000 төгрөгийн дэмжлэг авсан.


Кейс 24

“ХБ-тэй хоёр хүн ажиллуулдаг. Маш хэцүү байдаг. Байнгын ядардаг, унтдаг, татдаг. Зааж өгсөн юмыг удаан ойлгодог. Нэг нь COVID туссан тул биеэр уулзаж чадсангүй.”

-БГД-ийн иргэн, 2 сая төгрөгийн дэмжлэг авсан.

ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээллээс дэмжлэгт хамрагдсан ХБИ-ийг насны бүлгээр харвал, 35-44 насныхан тус дэмжлэгт харьцангуй ихээр хамрагдсан байна.


График 23. Хамрагдсан иргэдийн нас, хувиар



Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 3, Q6, N=21

Харин иргэн, ААНБ-аас авсан судалгаанд оролцсон иргэдийг насны бүлгээр харвал 40-49 насныхан 35 хувийг, 30-39 насныхан 33 хувийг эзэлсэн нь тус насны хүмүүс илүү ихээр дэмжлэгт хамрагдаж байна.

График 24. Хамрагдсан иргэдийн нас




■ 40-49 нас ■ 30-39 нас ■ 50-59 нас ■ 20-29 нас ■ 60-аас дээш нас

Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 3, Q5, N=66

ХХҮГХ-ийн ирүүлсэн мэдээллээс хүйсийн харьцааг он тус бүрээр харвал, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү тус дэмжлэгт хамрагдсан байна.


График 25. Хамрагдсан иргэдийн хүйс, хувиар



Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 3, Q6, N=20

авсан судалгаагаар арга хэмжээнд хамрагдсан иргэдийн хүйсийг харьцааг харвал 52 хувь нь эрэгтэй, 48 хувь нь эмэгтэй байна.


График 26. Хамрагдсан иргэдийн хүйс



Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 3, Q6, N=61

Иргэн, ААНБ-аас авсан судалгаагаар ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх асуулгаас харахад аймаг, орон нутагт 89 хувьтай байсан бол Улаанбаатар хотын хувьд 81 хувь нь нийцсэн гэж хариулсан байна.

График 27. Энэ арга хэмжээ нь ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх



Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 3, Q7, N=63

Ганцаарчилсан ярилцлагад оролцсон ААНБ-ууд дэмжлэгийн хэмжээ нэмэгдэж, дэмжлэгт хамрагдахад шаардлагатай бичиг баримт болон үйл ажиллагааг ойлгомжтой, түргэн шуурхай, чирэгдэлгүй болговол ХБИ-ийг авч ажиллуулах сонирхол нь их байгаа талаар ярьсан.

Кейс 25

“Тухайн хүний хувьд асуудал байхгүй, төрөөс явуулж байгаа дэмжлэгийг авахад хүндрэлтэй байсан. Хариуцсан ажилтан нь хаана байгаа, хэнтэй холбогдох нь тодорхойгүй байсан. Хувийн хөдөлмөрийн биржээр дамжуулж авсан. Гэтэл заавал дүүргийн хөдөлмөрийн хэлтсээс хүнийг нь авч ажиллуулах ёстой гэсэн. Гомдол гаргана гэж сүрдүүлж байж дэмжлэгтэй орсон. Ажил олгогчдыг залхаан цээрлүүлж байгаа юм шиг хэрэгцээгүй шаардлага тавьсан.”

-БГД-ийн 10-р хороо, “Жоб көүчинг” ХХК, 5,030,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 26

“Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллахад хэцүү юм билээ. 1 жил манайд ажлаад ажлаасаа гарсан. Манайх худалдааны байгууллага. IT инжинер. Манайд зургийн загвар гаргах ажил хийдэг байсан. Ер нь хамт ажиллахад хэцүү байсан, яаж сайжруулах талаар санал хэлж мэдэхгүй байна.”

-СБД-ийн 10-р хорооны иргэн Ө, 5,040,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 27

“Ажилтан Б.Энх-Од маань манай компанид 11 жил тогтвор суурьшилтай ажиллаж байна. Жижиг ААН-дэд тогтмол өгч байвал хэрэгтэй байх. Тулгуур эрхтэний болон бусад төрлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж буй туршлагыг судлаж нэвтрүүлэх, түгээх хэрэгтэй байна.”

-Сүхбаатар аймгийн Баруун-урт сум, “Мөнх сайн-Үүд” ХХК, 1 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Ажил олгогчид нарт түрээсийн байрны зардал өндөр тул санхүүгийн хүндрэл үүсдэг үүнийг шийдэхийн тулд төрөөс эргэн төлөгдөх түрээсийн дэмжлэг үзүүлбэл ажил олгогчид үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, ХБИ-ийн тоог нэмэх боломжтой гэсэн саналуудыг хэлсэн.

Кейс 28

“Төрөөс өгч байгаа дэмжлэг нь өндөр бол зээлээ аваад байртай болмоор байна. Түрээсийн байранд сард 1,0 сая төгрөгөөс 3,0 сая төгрөг өгч байна. Үүнийгээ төрдөө төлөөд ажлын байртай болмоор байна.”

-БГД-ийн Нарны хороолол, “Увидаст 3 баатар” ХХК, 5,040,000 төгрөгийн дэмжлэг авсан

Кейс 29

“МонИнжБар ХХК-д Мэргэн гэдэг дауны синдромтой эрэгтэй талбай дээр туслах хийдэг. Энэ ХХК нь шугам сүлжээний ажил хийдэг ба улирлын чанартай ажилладаг. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулаад дээрээс нь бага хэмжээний урамшуулал өгч байсан. Одоо сул зогсолттой байгаа. Бидэнд илүү их санхүүгийн дэмжлэг үзүүлбэл илүү сургаад, цалинг нь нэмээд, мэргэжил эзэмшүүлбэл зүгээр гэж бодож байна.”

-ХУД-ийн 18-р хорооны иргэн Б, 5,040,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 30

“Нэг удаа л авсан бол одоо болсон гэж үзээд байна. Нэг л удаа олгодог гэдэг зүйл баримталж байгаа. Хүн авах тоолондоо хүнийхээ тоогоор дэмжлэгээ авчихаад байвал зүгээр байна. ХБИ-ийг авч ажилуулах сонирхолтой. ХБИ-ийг авч ажиллуулж байгаа ажил олгогч нараа дэмжиж байвал бид ажилуулах хүсэлтэй байдаг.”

-ЧД-ийн 14-р хорооны иргэн О, 5,040,000 төгрөгийн дэмжлэг авсан.

3.5 ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Ажлын байрны
түрээсийн төлбөрийн
дэмжлэг



Зорилтот түвшин

300

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

242 (81%)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 7 дугаар бүлэгт “Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлын үед ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны түрээсийн төлбөрт дараах байдлаар дэмжлэг үзүүлнэ” гэж заасан байдаг.

Дээрх хөтөлбөрийн 7.1 дүгээр заалтад үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны 1-6 дугаар сарыг дуустал хугацааны ажлын байрны түрээсийн төлбөрт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ”-гээр тооцож, нэг удаагийн мөнгөн дэмжлэгийг нөхөн олгоно гэж заасан байна.

Хамрагдсан иргэдийн тоо

Тус арга хэмжээний хүрээнд аймаг, дүүргээс ирсэн мэдээллийг нэгтгэж, сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулан харахад:

- Улсын хэмжээнд 2019 онд 75 хүн түрээсийн дэмжлэгт хамрагдсан бол 2020 онд 30 иргэн, ААНБ хасагдаж 45 болсон бол 2021 онд шинээр 143 иргэн, ААНБ нэмэгдэж 188 нь иргэн, ААНБ болсон байна.
- Аймгийн хэмжээнд 2019 онд 65 байсан бол 2020 онд иргэн, ААНБ-ын тоо 28-аар буурч 37 болсон бол 2021 онд 66 иргэн, ААНБ-аар нэмэгдэж 103 болсон байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд 2019 онд 10 хүн хамрагдаж байсан бол 2020 онд 2 хүн хасагдаж 8 болсон байна. Харин 2021 онд шинээр 77 иргэн, ААНБ нэмэгдэж 85 болов.

Хүснэгт 16. Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэгт хамрагдсан иргэдийн тоо

Аймаг, дүүргүүд	2019 он	2020 он	2021 он
Архангай	2	17	-
Баянхонгор	43	3	9
Булган	-	-	6
Говь-Алтай	-	-	2
Дархан-Уул	-	-	17
Дорнод	-	-	13
Дорноговь	-	-	2
Орхон	2	1	-

Өвөрхангай	-	-	9
Өмнөговь	-	-	6
Сүхбаатар	-	1	1
Сэлэнгэ	1	1	5
Төв	-	-	2
Ховд	-	1	9
Хөвсгөл	-	9	15
Хэнтий	13	-	-
Баянзүрх	4	4	7
Аймгийн хэмжээнд нийт	65	37	103
Баянгол	4	5	21
Багануур	1	-	-
Багахангай	-	-	14
Чингэлтэй	2	-	1
Налайх	-	-	6
Сүхбаатар	3	3	15
Сонгинохайрхан	-	-	16
Хан-Уул	-	-	12.
Улаанбаатар хотын хэмжээнд	10	8	85
Улсын хэмжээнд	75	45	188

Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 4, Q1, N=25

ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээллээс ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан ААНБ-ын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хадгалсан ажлын байрны тоог харахад хамрагдсан ААНБ-ын тоо зарцуулсан хөрөнгийн өсөлтөөр сүүлийн 3 жилээр жил тутам өссөн байна. Харин хадгалсан ажлын байрны тоо 2020 онд өмнөх оноос буурсан гэхдээ 2021 онд 70 хувиар өсч 119 болсон.

Хүснэгт 17. Хамрагдсан ААНБ-ын тоо, Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, Хадгалсан ажлын байрны тоо


Хамрагдсан ААНБ-ын тоо			Зарцуулсан хөрөнгийн хэмжээ			Хадгалсан ажлын байрны тоо		
2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
18	45	118	39,372,900	41,998,900	219,883,010	62	21	119

Эх үүсвэр: ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээлэл, Шалгуур үзүүлэлт 4, Q2, Q3, Q4, N=22

Авсан дэмжлэгийн хэмжээ

Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан 76 ХБИ, ААНБ үнэлгээнд хамрагдсан. Дүүрэг бүсүүдэд өгсөн дэмжлэгийн хэмжээнээс харахад СХД 21,000,000 төгрөгийн, хангайн бүс 19,495,650 төгрөг дэмжлэг тус тус авсан нь хамгийн өндөр дэмжлэг байна. Нийт 77 иргэн, ААНБ 83,461,430 төгрөгийн дэмжлэг авсан байна.

График 28. Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдаж авсан дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөг)




Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 4, Q1, N=77

Олгож буй түрээсийн төлбөрийн хэмжээ нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх

Олгож буй түрээсийн төлбөрийн хэмжээ нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх асуулгад аймаг, орон нутаг болон Улаанбаатар хотоос оролцосон иргэн, ААНБ-ын 82 хувьд нь нийцсэн, 18 хувьд нь нийцээгүй байна.

График 29. Түрээсийн дэмжлэг эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх



Эх үүсвэр: Иргэн, ААНБ-аас авсан судалгаа, Шалгуур үзүүлэлт 4, Q3, N=78

Ганцаарчилсан ярилцлагын хүрээнд ажлын байрыг хадгалах хүрээнд хийгдсэн ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсанаар үүссэн эерэг болон сөрөг асуудлуудын талаар ярилцсан.

Тодруулбал, тус дэмжлэгт хамрагдсан ХБИ, ААН-үүдийн хөдөлмөрийн үйл ажиллагаа Ковид-19 цар тахлын үед тогтвортой, ажлын байранд шаардлагатай тоног төхөөрөмжөө шинэчилж, шинээр ажлын байр бий болгох зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан гээд дэмжлэг үзүүлсэн ХБХХЕГ-т талархал илэрхийлсэн.

Кейс 31

“Дэмжлэг болсон. Түрээсийн байранд суудаг байсан, амьдрал ахуй дээшилж байна. Оёдлын машинаа шинэчилсэн. Гэрээр үйл ажиллагаа явуулдаг. Түрээсийн хөнгөлөлт маш их дэмжлэг болсон.”

-Архангай аймгийн Эрдэнэбулган сумын иргэн М, 1,200,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 32

"Хувиараа дугуй засвар ажиллуулдаг. Үйл ажиллагаанд маань маш сайн дэмжлэг болсон. Ялангуяа хөл хорионы үед ажлын байргүй болох эрсдэлээс хамгаалж чадсан. Одоогоор түрээсийн байраасаа гараад өөрийн гэсэн байртай болсон."

-Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын иргэн А, 720,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 33

"Дүүргээс санхүүгийн дэмжлэгт хамруулж байгаад талархаж байна. Үйл ажиллагаа нь тодорхой хугацаанд тогтвортой явагдаж байна. Ажлын байраа нэмэх зорилготой."

-Багануур дүүргийн иргэн М, 360,000 төгрөгийн дэмжлэг авсан.



Кейс 34

"Сонголын бэрхшээлтэй, нэг талын чихэндээ аппараттай. Нөхөр мөн хөгжлийн бэрхшээлтэй. Сарын түрээс 300,000 өгдөг, 6 сарын хугацаанд сар бүр 250,000 төгрөгийн дэмжлэг авсан болохоор 6 сар түрээс гэж санаа зовохгүй л болсон. Орлого муутай, группийн мөнгө хүрэлцдэггүй."

-СХД-ийн иргэн Б, 1,500,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Харин сөрөг асуудлын тухайд: Нийт (78) судалгаанд оролцогчдын 18 хувь нь иргэдэд олгож буй түрээсийн төлбөрийн хэмжээ нь зах зээлийн дүнгээс доогуур байна гэсэн. Мөн ХХҮГХ болон төрийн байгууллагуудад ХБИ-д үйлчилдэг ажилтан байхгүйгээс үзэл бодлоо илэрхийлэх эрх зөрчигдөж байна гэсэн. Тодруулбал:

- Ковид-19 цар тахал болон бараа материалын үнийн өсөлтөөс болж түрээсээ төлж чадахгүй өрөнд орсон тохиолдол байна.
- Түрээсийн дэмжлэгт хамрагдах гэсэн иргэдэд ХХҮТ хүнд суртал гаргадаг гэсэн.
- Түрээсийн дэмжлэгт хамрагдаж, үйл ажиллагаа тогтворжиж эхлээгүй байхад тухайн сард НДШ, түрээсийн төлбөр төлөх нь ААНБ болон ХБИ-нд хүндрэл үүсгэж байна.

Кейс 35

"Ажлын байраа сарын 1.500.000 төгрөгөөр түрээсэлдэг. Түрээсийн мөнгө гээд 1.500.000 төгрөг орж ирэхээр нэг сарынх гэж ойлгосон. Түрээсийн дэмжлэгийн тусламж их бага санагдсан."

-БЗД, "Мөнх далайн суварга" ХХК, 1,500,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 36

“Түрээсийн дэмжлэгийг халамж дээр хэд хэдэн удаа очиж хэрүүл хийн байж авч байна. Хүнд сурталтай, олон бичиг баримт шаарддаг. Манай ХХК олон салбартай, бусад салбарууд дэмжлэгт маш хурдан, төвөг чирэгдэлгүй авдаг бол манайх үнэхээр удаан, хүнд сурталтай.”

-СХД-ийн 17-р хороо, “Асунароо” ХХК, 1,500,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 37

““Премьер консалтинг” ХХК нь ажлын байр түрээсэлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд түрээсийн өрөнд энэ компанид орсон. Одоо эдгээр иргэдээс хэн нь ч түрээслэхгүй гарчихсан байгаа. Бид нийгмийн хариуцлагын хүрээнд бүтэн жил энэ иргэдээс түрээс аваагүй. Тэд 7,8 сая төгрөгийн өртэй байсан, 4,5 саяыг түрээсийн дэмжлэг улсаас аваад л орхисон.”

-СХД, “Премьер консалтинг” ХХК, 4,500,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 38

“Манайх төсөл батлагдаад 06 сард гэрээ хийж, санхүүжилт 10 сард орж ирсэн. Гэтэл ажлаа гэрээ хийнгүүт эхлээд НДШ болон түрээсээ төлөөд яваад байсан. Энэ нь жаахан хүндрэл үүсгэж байсан. Цалин, групп хоёроо авч байхад өөрийн болоод өрхийн хэрэгцээгээ хангаад байна. Гэтэл тэтгэвэрт гарахад энэ мөнгө хасагдана шүү дээ.”

-БЗД, “Хөгжлийн туслалцаа” ТББ, 1,500,000 төгрөгийн дэмжлэг авсан.

Кейс 39

“Сонсголын бэрхшээлтэй нэг иргэнийг авч сарын 700 мянгаар цалинжуулан нийгмийн даатгал төлж ажиллуулж байгаа. Ажил олгогчиддоо өгөх 2880000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан.”

-Хөвсгөл аймгийн Мөрөн сум, “Эх зөгийн аз” НҮТББ, ШҮ-3-аас 5,040,000 төгрөг, ШҮ4-өөс 750,000 төгрөгийн дэмжлэг авсан.

3.6 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хөдөлмөр
эрхлэлтийн сургалт
зохион байгуулах



Зорилтот түвшин

350

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

165 (67.3%)

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 3.1.6-д заасан Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд нийт 600 ХБИ-ийг сургалтанд хамруулахаас ХБХХЕГ Улаанбаатар хотод 305 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжлийн үр чадварын тусгайлсан сургалтыг мэргэжлийн сургалт зохион байгуулах дадлага, туршлага бүхий сургалтын байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх квоттой. Квотын дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ХБХХЕГ-т 88,450,000.00 төгрөг хуваарилагдсан байна. Харин ХХҮЕГ-аас ирүүлсэн мэдээллээр 2019 онд 726 ХБИ-ийг хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамруулж 148,621,200 төгрөг зарцуулсан байна.

2020 онд хөдөлмөр эрхлэлтийн сургалтын шаардлага хангасан 13 байгууллагатай “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах гэрээ” байгуулсан ба нийт 12 мэргэшсэн сургалтын байгууллага сургалтаа зохион байгуулж, 205 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд оёдолчин, мужаан, тогооч, талх, нарийн боовчин, гар утас, телефон аппаратын засварчин, гар урлаач зэрэг мэргэжлүүдээр тусгайлсан үр чадвар олгосон байна. Үүнд нийт 31,710,000 төгрөг зарцуулсан байна.

Харин 2021 онд хөдөлмөр эрхлэлтийн сургалтын 11 байгууллага шалгарч 165 ХБИ-нд чадамжийн гэрчилгээ олгосон байна.

Хүснэгт 18. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн сургалтын байгууллагууд (2021 он)

№	Байгууллагын нэр	Байгууллагын регистр	Санхүүжилтийн хэмжээ
1	“Мөнх алтан хүлэг” ХХК	5741009	3,510,000
2	Чингэлтэй дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо ТББ	8051976	3,120,000
3	“Уран гар урлал” ТББ	8008736	3,120,000
4	“Футур” сургалтын төв	2293862	3,328,000
5	“Дарь овооны эзэд” ТББ	8288216	3,510,000
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалт мэдээллийн төв	8142084	3,120,000
7	Монголын экспорт, импортыг дэмжих үндэсний төв	8240558	2,938,000
8	Мэргэшсэн мэргэжил сургалтын төв	8209715	5,460,000

9	“Тойнь амгалан хайрхан” ХХК	5718619	3,120,000
10	Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв	9129073	3,380,000
11	“Арвин шамдах” сургалтын төв	5598591	3,510,000
Нийт			38,116,000

Эх үүсвэр: ХБХХЕГ, Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын арга хэмжээний дэмжлэг үзүүлэх тушаал, 2021 он

Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх судалгаанд 13 иргэн оролцсон бөгөөд мэдээллийг дүгнэвэл:

- Нэг хүнд ногдох сургалтын зардлын хэмжээ 30,000 төгрөг байна.
- Сургалтын дадлага хийлгэдэг гэж 54 хувь (7) нь, хийлгэдэггүй гэж 46 хувь (6) хариулсан.
- Хамрагдсан иргэний насны хувьд 30-40 насны иргэд 77 хувь (10)-ийг эзэлж байна.
- Хамрагдсан иргэдийн 69 хувь (9) нь эмэгтэй, үлдсэн 31 хувь (4) нь эрэгтэй байна.
- Сургалтыг үсчин, оёдолчин, урлаач, эсгий урлал, гар урлал болон бизнесийн хөгжүүлэлт зэрэг хөдөлмөр эрхлэх үр чадвар олгох богино хугацааны сургалтууд явуулдаг.
- Мэргэжлийн хувьд програмист, үсчин, оёдол, эсгүүр болон эсгий урлал гэж хариулсан байна.
- Сургалтын хугацаа, мэргэжлийн төрөл, эзэмшүүлж буй үр чадвар нь иргэний хэрэгцээ шаардлагад 92 хувь нь нийцдэг гэсэн.
- Сургалтын хугацаа, мэргэжлийн төрөл, эзэмшүүлж буй үр чадвар нь ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад 82 хувь (9) нь нийцэж байгаа гэсэн бол үлдсэн 18 хувь (2) нь нийцдэггүй гэсэн байна.
- Нэг хүнд ногдох зардлын хэмжээ нь зах зээлийн хэрэгцээ шаардлагад 89 хувиар нийцэж байна гэсэн.
- Суралцагчийн сэтгэл ханамжийн хувьд оролцогчид 70 хувьтай гэж хариулсан байна.

Сургалтанд хамрагдсан иргэдийн эерэг сэтгэгдлийг харвал, сургалтанд хамрагдсандаа талархаж байгаагаа илэрхийлээд сургалт орсон багшаас их зүйл сурч, сурсан зүйлээ ашиглан тогтвортой ажлын байртай болсноо ярьсан байна.

Кейс 40

“Багшаараа оёдлын талаар олон сайхан зүйл заалгасан. Одоо бүлгээр ажиллаж байгаадаа их баяртай байгаа. Цаашид өөрийгөө улам илүү хөгжүүлэн мэргэшин суралцах хүсэлтэй.”

-Ховд аймгийн Рашаант багийн иргэн О, Политехник коллежоос хийсэн оёдлын суралтанд суусан.

Кейс 41

“Сургалтанд суусны дараа хумс маникурын бүх төрлийн багаж хэрэгсэл худалдаж аваад “Сондор” салонд ажиллаж байна. Хажуугаар нь асаргааны хүүхэдтэй учир богиносгосон цагаар ажиллаж байна.”

-БГД-ийн иргэн Н, Политехник коллежийн суралтанд суусан.

Сургалтанд хамрагдсан иргэдийн сөрөг сэтгэгдлийг харвал, сургалтын төвүүд ХБИ-д тохируулсан сургалтын байранд сургалт ороогүйгээс сургалтанд хамрагдах хүсэлтэй хүмүүс оролцох боломжгүй болох тохиолдлууд байна. Иймээс сургалтын орчинг сайжруулах хэрэгтэй байна.

Кейс 42

“Орж гарахад хэцүү юм билээ. Дээшээ доошоо саад бартаа ихтэй. Хонгилтой, шатаар дээш доош гардаг. Олон оёдлын машин тавьчхаар наашаа цаашаа тэргэнцэртэй хүн явахад хэцүү, давчуу байсан. Сургалтын төвд сурахад тухайн сургалтын төвийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд саад бартаа байхгүй байх хэрэгтэй”.

-СХД-ийн 10-р хорооны иргэн З, Оёдолчны сургалтанд суусан.

3.7 “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР” ЗААЛТ БҮРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг. Түүнчлэн тус конвенцид мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагийг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөсөн. Конвенцийн дагуу Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг эдлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар дараах хууль тогтоомжид тусгасан.

Тухайлбал: - Хөдөлмөрийн тухай хуульд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль төлбөр ногдуулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нэмэгдүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бодлого, түүний төлөвлөлт, удирдлагын тухай хуульд заасны дагуу хөтөлбөр нь нэгдмэл харилцан уялдаатай, тогтвортой, тэнцвэртэй, ил тод судалгаа шинжилгээнд үндэслэсэн, зорилго зорилт хэмжигдэхүйц, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх, бүх талын оролцоог хангасан, мөн төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангасан, үр дүнд чиглэсэн оролцогчдын хариуцлагын зарчим, нэгтгэн тайлагнах зарчмыг баримталсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн нэгдүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нь таван цогц арга хэмжээний хүрээнд 21 аймаг, есөн дүүргийн хэмжээнд 2019, 2020, 2021 онуудад хэрэгжсэн.

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, шинжилгээ судалгаа хийхэд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нь хөтөлбөрт байх бодлого, зарчимд нийцсэн, цогц арга хэмжээнүүдийн хэрэгжилт нь шалгуур үзүүлэлт үр дүнгийн тоон хэмжээнд хүрсэн байна. ХБХЭЭ холбооны 8 дүүрэг, 16 аймагт хийсэн судалгаа, үнэлгээ болон “Эрх зүйн соёл” ТББ-ын 1 дүүрэг, 5 аймагт хийсэн судалгаагаар хөтөлбөрт хамрагдсан ХБИ, ТББ, ААНБ-ын санал, тулгамдаж буй асуудлуудыг тусгасан байна.

Нэг. Зорилго

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллах, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох, ажил олгогчийг дэмжих болон тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар тэднийг байнгын ажлын байраар хангахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1 Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хүчин төгөлдөр шийдвэртэй, "Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүн;

2.2 Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх;

2.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч;

2.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж байгаа төрийн бус байгууллага;

2.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж байгаа ажил өлгөгч.

/2.2 дахь заалттай утга агуулга нэг./

Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах

Хөтөлбөрийн хүрээнд дараах үндсэн арга хэмжээг зохион байгуулж, холбогдох мэдээллийн санг бүрдүүлж ажиллана. Үүнд:

3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад үзүүлэх дэмжлэг

Анхаарах зүйлс: Энэхүү арга хэмжээ нь 2021 онд 4 дэд арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийг хангаж чадаагүй байна. Учир нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ нь зарим аймаг дээр нэг дэд бүтэц нь хэрэгжсэн, огт хэрэгжээгүй байсан нь судалгаагаар харагдсан. Жишээ нь: Говьсүмбэр аймгийн хувьд тус арга хэмжээний санхүүжилт 2021 оны 12 сард орж ирсэн гэх шалтгаантай байна.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэхдээ аймаг, дүүргийн ХХҮГ болон энэ чиглэлээр мэргэшсэн ТББ, ААН-тэй нягт хамтран ажиллах нь чухал. Мэргэжлийн байгууллага, хувь хүн ажиллаж байж илүү үр дүнтэй хэрэгжих болно.

3.1.1 Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах;

Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг зохион байгуулахдаа хамрагдах ХБИ-ийн хөгжлийн бэрхшээлийн төрлийг судалж арга хэмжээг илүү үр дүнтэй байлгахын тулд судалгаа, үнэлгээний, тухайн хөдөлмөрт бэлтгэж байгаа ажлын байрны аргыг ашиглан мэргэжлийн байгууллагаар хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах нь үр дүнтэй байна.

3.1.2. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээг үзүүлэх;

Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээг үзүүлэхдээ ХБИ-ний сэтгэл зүй болон ажлын байран дээрх дэмжлэгийг судлан төлөвлөж бие даан ажиллахад дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Тухайн ажлын байран дээр ХБИ-ний хөдөлмөр эрхлэхэд тохирох хэрэглэгдэхүүнээр хангах нь чухал юм.

3.1.3. Ажлын байранд нь дадлагажуулах;

Дадлагажуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй нээлттэй тулж харилцах, сонгосон ажлын байран дээр очиж ажиллан мэдээлэл цуглуулан ажил олгогчтой орчин нөхцөл, ХБИ хөдөлмөр эрхлэхэд тулгарах бэрхшээлийг судлан дадлагажуулах нь үр дүнтэй байна.

3.1.4. Ажлын байрны орчинд хөгжлийн бэрхшээлтэй ажилтны онцлогт нийцүүлэн хэрэгцээт тохируулгыг хийх.

Тухайн ажлын байран дээр ХБИ-ний хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнээр хангах нь чухал юм.

3.2. Санхүүгийн дэмжлэг олгох

Хэрэгжилт: Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ нь улсын хэмжээнд бусад цогц арга хэмжээ болон иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ нь бусад дэд арга хэмжээнээсээ илүү хэрэгжсэн. Аймаг дүүргүүдийн хэмжээнд иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ нь 1 сая төгрөгөөс 5 сая төгрөгийг хооронд дэмжлэг үзүүлсэн байна.

Анхаарах зүйлс: Судалгаагаар санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан ХБИ, ХБ гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа эцэг эхчүүдээс ирсэн нийтлэг асуудал нь санхүүгийн дэмжлэгээр авсан мөнгөний хэмжээ бага, хүрэлцэхгүй нэмүүлэх санал гаргасан.

Мөн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд төсөл ирүүлж, төсөл нь шалгараад дэмжлэг авсан ХБИ, ТББ, ААН-үүдийн ажлын байраа хадгалж үлдсэн, дэмжлэгээр олгогдсон мөнгөний хэмжээ, төсөл нь хэрэгжиж байгаа эсэх талаар мэдээлэл нь дутмаг байна. Энэ тал дээр хөтөлбөрт хамрагдсан ХБИ, ААНБ, ТББ-уудтай харьяалах ХХҮГ болон ХБХХЕГ хамтран нягт холбоотой байх, хяналт тавих шаардлагатай.

ТББ, ААН-д санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилтийн үр дүндээ хангалттай хүрч чадаагүй муу байсан. Учир нь шалгарсан төслийн дагуу олгогдсон санхүүгийн дэмжлэгийг төсөлөө хэрэгжүүлэхэд зарцуулах ёстой. Судалгаагаар төслөө хэрэгжүүлж эхэлсэн ХБи байсан ч санхүүгийн дэмжлэг аваад төслийн дагуу үйл ажиллагаагаа эхлээгүй иргэдл ч байсан. Энэхүү арга хэмжээг үр дүнтэй, оролцоог нэмэгдүүлэхийн тулд мэдээлэл, сургалт, сурталчилгааг дэлгэрүүлэх, ТББ, ААН-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байрыг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Ажлын байр хадгалах дэмжлэг үзүүлэх, аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтэд харьяалах ХХҮГ болон ХБХХЕГ-ын хяналт, эргэх холбоог сайжруулах хэрэгтэй байна.

3.2.1. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох;

3.2.2. Төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох;

3.2.3. Аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох;

3.2.4. Ажлын байр хадгалах дэмжлэг үзүүлэх;

3.2.5. Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх

Хэрэгжилт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ нь аймаг, дүүргүүд дээр харилцан адилгүй хэрэгжсэн байна. энэхүү арга хэмжээнд 80 орчим ажил олгогчийг хамруулж, 90 орчим ажлын байр бий болгосон байхаар үр дүндээ тусгасан байна. Энэхүү арга хэмжээний хэрэгжилтэнд 80 орчим ажил олгогчийг хамруулсан ч зарим аймаг, дүүргүүд дээр энэхүү арга хэмжээнд хамрагдсан ажил олгогч байхгүй харилцан адилгүй хэрэгжсэн байна.

Анхаарах зүйлс: ХХҮГ болон ХБХХЕГ хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид урамшуулал олгох гэрээгээр ажиллаж буй ХБИ-ний ажлын байрандаа тогтвортой ажиллах талаар нарийвчлан тусгах шаардлагатай.

Тухайн ажлын байран дээр ажиллахад ажлын нөхцөл, техник, багаж хэрэгсэл буюу тохирох хэрэглэгдэхүүн хангалттай биш байгаагийн улмаас ажил хөдөлмөр эрхлэхэд хүндрэлтэй асуудлуудын улмаас ажил хийх сонирхолгүй, өөртөө итгэлгүй болох зэрэг асуудлууд үүсдэг.

3.4. Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх

Хэрэгжилт: Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт 300 орчим иргэн, ААН, байгууллагыг хамруулж, ажлын байр хадгалсан байхаар тусгажээ. Судалгаагаар 306 иргэн, ААН-д түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлсэн харагдаж байна.

Анхаарах зүйлс: Ажлын байрны төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ нь бизнес эрхлэгч ХБИ, ХБИ ажилладаг аж ахуй нэгж, ТББ-д хүсэлтэд үндэслэн түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэхдээ тэгш, шударгаар шаардлагад нийцсэн ХБИ, ААН, ТББ-д хүртээмжтэй олгох, Мөн шаардлагад нийцсэн объектод хүрч ажиллах, хамруулахын тулд мэдээлэл ойлголтыг хүргэх нь чухал юм.

3.5. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

Хэрэгжилт: Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээ нь шалгуур үзүүлэлтэндээ хүрч чадсан ч үр дүн нь хангалттай биш байна. Учир нь мэргэшлийн чадамж олж авч чадахааргүй хугацаанд сургалт зохион байгуулагдаж хангалттай үр дүнд хүрч чадахгүй гэсэн үг юм. Энэ асуудал нь харьяалах ХХҮГ болон ХБХХЕГ-ын хариуцлагын асуудал юм. ухайлбал сургалт орох байгууллагыг тендер зарлаж мэргэжлийн сургалтын байгууллагуудаар оруулдаг. Сургалт зохион байгуулж буй мэргэжлийн сургалтын байгууллага нь ХБИ-дэд хөдөлмөр эрхлэлт, аж ахуй эрхлэлтийн талаарх мэдлэг, үр дүнтэй чадамжийг олгохын тулд урт хугацаанд хамруулах хэрэгтэй.

Анхаарах зүйлс: 5-14 хоногийн хугацаанд ХБИ хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамрагдаад мэргэшиж, хөдөлмөр эрхлэлтийн талаар ойлголтыг бүрэн дүүрэн авч чадахгүй. Тэгэхээр сургалтын хугацааг уртасгах, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр, ХБИ-тэй ажиллаж сурсан мэргэшсэн тохируулгатай сургалтын арга барилтай мэргэжлийн байгууллагаар хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг гэрээлэн гүйцэтгүүлэх нь үр дүнтэй байна. ХБИ-нд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг үйлдвэрийн, ажлын байрны орчинд дасгаж

дадлага туршлагатай болгож хөдөлмөр эрхлэлтийн чадамжтай болгоход илүү урт хугацааны сургалтыг зохион байгуулах.

Хөтөлбөрийг дараах байгууллага, албан тушаалтан удирдлага, арга зүй, зохицуулалт, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг арга зүй, зохицуулалт, зохион байгуулалтаар хангаж ажиллах нь хөтөлбөр хэрэгжилтийн, үр дүнд чухал ач холбогдолтой. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шинжилгээ, судалгаа хийхэд хөтөлбөр хэрэгжилтийн хяналт, хөтөлбөрт хамрагдсан ХБИ, ААН, ТББ-ын мэдээллийн санг сайжруулах хэрэгтэй.

Анхаарах зүйлс: Жишээ нь: Зарим аймаг дүүргүүд дээр мэдээлэл нь хангалтгүй, зөрүүтэй байсан тохиолдол түгээмэл гарсан. Хөтөлбөрт хамрагдсан ХБИ, ААН, ТББ-д ХХҮГ, ХБХХЕГ холбогдох байгууллага нь холбоо хамааралтай байж хяналт тавих, мэдээллийг цуглуулж нэгдсэн мэдээллийн санг үнэн зөвөөр бүрдүүлэх.

Аймаг дүүргийн Хөгжлийн брхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь байнга солигддог, ажлаа сайн мэдэхгүй байх, зан аашны хувьд доголдолтой гэх мэт асуудлууд судалгааны явцад их ажиглагдсан. Тиймээс ХБИ хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар мэргэшсэн мэргэжилтэнг тогтвортой ажиллуулах, энэ тал дээр анхаарч ажиллах нь ХБХХЕГ, ХХҮЕГ-ын нэн тэргүүний анхаарах зүйл юм. Хөтөлбөрийн 5 цогц арга хэмжээ, дэд арга хэмжээний талаар мэдээлэл, ойлголтыг хангалттай сайн олон нийтэд сурталчлан таниулах түгээх нь чухал байна.

3.6. Хөтөлбөрийг удирдлага, арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, зохион байгуулалтаар хөтөлбөрт нэр дурдсан харьяа байгууллагууд хангаж ажиллана.

Хэрэгжилт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг удирдлага, арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ханган, нэгдсэн зохицуулалтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хангаж, хөтөлбөрт нэр дурдсан харьяа байгууллагууд аймаг дүүргийн ХХҮГ болон гэрээ байгуулан ажиллаж буй ААН, байгууллага зохион байгуулалтаар хангаж ажилласан.

3.7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж болон холбогдох үйл ажиллагааны зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтыг тусгасан байна

Хэрэгжилт: Хөтөлбөрийн удирдамжид энэхүү зүйлд заасан хөтөлбөрийн нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хөтөлбөрт хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хөтөлбөрийн арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тусгаж өгсөн байна. үүний дагуу хөтөлбөр нь 2021 онд Монгол улсын хэмжээнд хэрэгжсэн.

3.8. Хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүдийн жишиг загварыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга тус тус батална. Тайлангийн маягтад хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрт хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд маягтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэж батална.

Хэрэгжилт: Энэхүү заалтын хүрээнд аймаг, дүүргүүдийн хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлан, арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүд болон маягтын хүрээнд Хөтөлбөрийн арга хэмжээнүүд хэрэгжсэн байна.

Дөрөв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг дараах цогц арга хэмжээний хүрээнд зохион байгуулна. Үүнд:

Санал: Дараах цогц арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхдээ арга хэмжээ тус бүр дээр биелэгдэх боломжтой эсэх, хэрэгжүүлэхэд гарах хүндрэл, тулгамдах асуудлыг нарийн судалж үнэлсний үндсэн дээр зохион байгуулвал үр дүнтэй. Ингэхийн тулд чанартай, үр өгөөжтэй дэмжлэг үзүүлж удирдлага арга зүйгээр сайтар хангаж ХХҮГ ХБХХЕГ болон гэрээ байгуулан сургалт орж байгаа ААН, ТББ-ууд нь үр дүнтэй ажиллах шаардлагатай.

4.1. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг ганцаарчилсан болон бүлгийн зохион байгуулалттайгаар дараах байдлаар зохион байгуулна:

4.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэхтэй холбоотой чадвар болон хэрэгцээт үнэлэх;

Санал: ХБИ-ийг хөгжлийн бэрхшээлийн төрөл, ажилд тохиромжтой байдал, чадварыг нь үнэлж, хөдөлмөр эрхлэхэд тулгамдах асуудал саад бэрхшээлийг дүгнэх нь чухал ач холбогдолтой.

4.1.2. Үнэлгээнд үндэслэн хөдөлмөрийн харилцаанд бие даан оролцоход учирч буй саадыг арилгах, багасгахад чиглэсэн орон зайн чиг баримжаа олгох, тухайн ажлын байранд ашиглах багаж, тоног төхөөрөмж, технологи ашиглаж сургахад чиглэсэн сургалт, зөвлөгөө, дэмжлэгт хамруулах;

Санал: ХБИ-ийн хөдөлмөр эрхлэхэд тулгарах саад бэрхшээлийг арилгахад чухал юм. Тиймээс харьяалах ХХҮГ, болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд хамтарч хэрэгцээ шаардлага нөхцөлөөсөө хамааран урт богино хугацаанд үр дүнтэйгээр зохион байгуулах хэрэгтэй.

4.1.3. Хэрэгцээнд нь үндэслэн хөдөлмөрийн нөхөн сэргээх сургалт үйлчилгээнд хамруулах;

Санал: Сургалтыг ХБИ-д бэрхшээлийн төрлөөр нь ангилж урт хугацаанд хамруулах

4.1.4. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах;

Санал: ХБИ-ийг хөдөлмөр эрхлэлтийн, аж ахуйн үйл ажиллагаа, ажлын байрны талаарх тодорхой ойлголт, ажил, мэргэжлийн ойлголтыг сургалт, үйлчилгээгээр дамжуулан олгох.

Ингэхдээ сургалтыг мэргэжлийн дохионы орчуулагч болон хувийн туслахын тусламжтайгаар явуулах.

4.1.5. Ижил бэрхшээлтэй хүмүүс бие биенээсээ харилцан суралцах, дэмжих бүлгийн зөвлөлдөх уулзалтад хамруулах;

4.1.6. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

Санал: Сэтгэл зүйн зөвлөгөөг ганцаарчилсан болон ижил бэрхшээлтэй хүмүүстэй цуг харилцан ярилцах замаар сэтгэл засал хийх илүү үр дүнтэй юм.

4.1.7. Нийгэм, хамт олны дунд биеэ авч явах, харилцааны мэдлэг, үр чадвар эзэмшүүлэх;

Санал: ХБИ-ийг харилцааны чадвар эзэмшүүлэхээс гадна хамт олны цаашлаад нийгмийн бүхэл хүмүүсийн ХБИ харилцах арга барил, чадварыг сайжруулах, 4.1.7-4.1.8 дахь арга хэмжээнүүдэд бэрхшээлийн төрлөөр нь хуваан хувийн туслахын тусламжтайгаар зохион байгуулах нь зүйтэй.

4.1.8. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн дотоод журам, аюулгүй ажиллагааны мэдлэг олгох;

Санал: Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн дотоод журам, аюулгүй ажиллагааны мэдлэгийг олгохдоо ойлгоход хялбар аргаар зөвлөж хүргэх,

Жишээ нь: ХБИ төрлийн онцлогт тохируулан ажлын байранд дадлагажуулж байгаа дадлагажуулагч дээрх мэдлэгийг олгох

4.1.9. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний үргэлжлэх хугацаа 14-21 хоног хүртэл байна.

Санал: Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хугацааг 21-30 хоног хүртэлх хугацааг сунгах, хугацаанаас илүү үр дүн, дадлагажсан байдал чухал.

Санал: Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний үргэлжлэх хугацаанд ХБИ-дэд илүү үр өгөөжтэй, чадамжийг нэмэгдүүлж удаан хугацаагаар тохируулгатай орчинд сургах нь чухал. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд өөр өөр ХБ хүмүүс хамрагдаж суралцах чадварын хувьд ч өөр өөр. Тиймээс хугацааг уртасгах нь зүйтэй.

4.1.10. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн жилд нэг удаа хамрагдана.

4.1.11. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс болон Хөгжлийн Бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулсны дараа ажилд зуучлах үйлчилгээ үзүүлнэ.

4.2. Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх.

Хэрэгжилт: Хөдөлмөрийн цогц арга хэмжээ бүр нь хоорондоо харилцан уялдаатай. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэшлийн чадамжийн гэрчилгээтэй болсноор дэмжлэгтэйгээр ажлын байранд зуучлагддаг. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг хэрэгцээт тохируулгатай орчинд сургалтад хамруулж, ажлын байранд дадлагажуулан ХБИ иргэнийг байнгын ажлын байртай болгох замаар хэрэгжилтийг хангасан байна.

Санал: ХХҮХ нь хөдөлмөр эрхлэх хүсэлтэй сургалтанд хамрагдсан ХБИ-ийг ажлын байранд зуучлахад дэмжлэг үзүүлж ажил олгогч ААН, байгууллагад зуучлан, хөдөлмөр эрхлэхэд тулгарах саад бэрхшээлийг тооцоолон мэдээллийг судалж, судалгаа хийх гэх мэт дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх тусгай мэргэшсэн мэргэжилтэн /дохионы хэлний мэдлэгтэй/-г тусдаа ажиллуулдаг байх хэрэгтэй. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийг эргээд ажилд зуучлах үйлчилгээг хангаж ажиллах харьяалах ХХҮх болон холбогдох байгууллага энэ тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй.

4.2.1. Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохирох ажлын байрны талаар мэдээллийг цуглуулж, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, жагсаалт гаргах;

Санал: Эхлээд ХБИ-ний хөдөлмөр эрхлэх боломжтой ажлын байрны мэдээлэл, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, жагсаалт гаргаад үүнд үндэслэн ХБИ-ийг хөдөлмөрт бэлтгэх нь илүү үр дүнтэй байна.

4.2.2. Шаардлагатай тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байранд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх;

Санал: Ажил олгогчид буруу ойлгож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг энгийн хүмүүсээс илүү бүтээлч биш гэж үзэж, ажил хөдөлмөр эрхлэхэд нь зориулж ажлын байрыг тохируулж өгөхгүйгээс болж тэдний хөдөлмөр эрхлэх боломж нь хязгаарлагддаг. Тиймээс ажил олгогчид ХБИ хөдөлмөр эрхлэх байдлыг харилцан тохируулга хийх байдлаар зохион байгуулах шаардлагатай.

4.2.3. Хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч болон орон зайн чиг баримжааны сургагч багшийг бэлтгэх сургалтыг нийслэлд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, орон нутагт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж зардлын жишиг хэмжээнд нийцүүлэн зохион байгуулах;

4.2.4. Аж ахуй нэгж, байгууллагуудтай уулзалт хийж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, онцлог, холбогдох хууль, тогтоомжийн талаарх мэдээллийг өгөх;

4.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байртай танилцуулах дадлага хийлгэх;

Санал: Ажлын байртай танилцуулах дадлагыг энэ чиглэлээр мэргэшсэн ТББ-аар дамжуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.2.6. Зохион байгуулагдаж буй ажил, мэргэжлийн зуучлалын (карьер экспо) өдөрлөгт оролцож, үйл ажиллагааг танилцуулах.

Анхаарах зүйлс: Энэхүү дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд ХХҮХ болгон хөтөлбөр хариуцсан тусгай мэргэшлийн мэргэжилтэн бэлтгэж ажиллуулах нь илүү үр дүнтэй.

4.3. Ажлын байранд дадлагажуулах үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд зуучилсны дараа дараах байдлаар зохион байгуулна:

Хэрэгжилт: ХБИ-ийг иргэнийг дэмжлэгтэйгээр ажилд зуучилсны дараа доорх арга хэмжээг авч ажиллахгүй, ажилд зуучлах үйлчилгээг хангаж ажиллахгүй байгаа нь судалгаагаар харагдсан.

Анхаарах зүйлс: ХБИ-ийг дэмжлэгтэйгээр ажилд зуучлаад орхих биш ажлын байрны орчин болон ажил олгогчидтой уулзаж хэрхэн ажиллаж байгаа тулгамдсан асуудлыг нь хэлэлцдэг байх хэрэгтэй.

Санал: Ажлын байрны дадлагажуулагч нь ХБИ-ий дадлагын үр дүнд үндэслэн ажил үүрэг, орчны талаар ажил олгогчтой тохируулга хийх тал дээр анхаарч энэ талаар хөтөлбөрт тусгах хэрэгтэй.

4.3.1. Хамт олны хандлага өөрчлөх сургалт зохион байгуулах ;

4.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтныг хамт олонтойгоо танилцаж, ажлын үйл ажиллагаанд дасахад нь туслах;

Санал: Хамт олон болон ажил олгогчид тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх мэдээллийг урьдчилан хэлэлцээд дараа нь ХБИ-ийг хамт олонтойгоо танилцах, ажлын үйл ажиллагаанд нь дасахад туслах нь чухал юм.

4.3.3. Ажиллах явцад учирч болзошгүй бэрхшээлийг даван туулах талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах;

Санал: ХБИ хөдөлмөр эрхлэхэд тулгарч болзошгүй бэрхшээлийг ажлын байран дээр судалгаа үнэлгээ хийн тооцоолон мэдээлэл өгөхдөө иргэнийг ажлын байран дээр очиж зөвлөх хэрэгтэй.

4.3.4. Ажлын байранд гүйцэтгэх ажил үүрэгт нь дадлагажуулан сургах, ажлын байрны дүрэм журмыг ойлгоход туслах;

Анхаарах зүйлс: ХБИ ажлын байран дээр дадлагажуулж байх явцдаа ХБИ-ийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, онцлогт нь тохируулж ажлын байрны дүрэм журмыг зааварлах нь ойлгоход хялбар юм.

4.3.5. Хэрэгцээг нь үндэслэн ажлын байрны орчинд бие даан зорчих орон зай, чиг баримжааны сургалт явуулах.

Анхаарах зүйлс: хувийн туслах, хөтөч нохойны тусламжтайгаар сургалт явуулах

4.4. Ажлын байрны орчинд хөгжлийн бэрхшээлтэй ажилтны онцлогт нийцүүлэн хэрэгцээт тохируулгыг хийх,

Санал: Ажил олгогчид хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт нийцүүлж хэрэгцээт тохируулга, багаж, хэрэгслийг бэлдэж ажиллах таатай нөхцөлөөр хангах нь чухал. ХБИ ажиллуулж буй ажил олгогчид олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг нэмж, ХБИ онцлогт нийцүүлсэн хэрэгцээт тохируулгыг хийх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

4.4.1. Ажлын байрны зураглал гаргах, байгууллагын гадаад, дотоод орчин мэдээлэл, харилцааны болон үйлчилгээний хүртээмжийн байдалд үнэлгээ хийх;

Санал: ХБИ-д ажил хөдөлмөр эрхлэхэд ажиллах орчны саад бэрхшээл их тулгардаг. Ажлын байр нь ХБИ-нд хүртээмжтэй орчинтой эсэхийг урьдчилан судалж, үнэлгээ гаргасны үндсэн дээр ажилд зуучлах нь чухал юм.

4.4.2. Үнэлгээнд үндэслэн ажлын байрны тохируулгыг хийх, хүртээмжтэй орчин бүрдүүлэх зөвлөмж, төлөвлөгөө боловсруулан ажил олгогчид танилцуулах;

Санал: Дээрх судалгаа, үнэлгээнд үндэслэн ажил олгогчид тохируулга, хүртээмжийн талаар зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.

4.4.3. Ажлын байран дахь ажиллах орчин, нөхцөл, ажлын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн хэрэгцээт тохируулгыг хийж, шаардлагатай бол хувийн туслах, ажлын байран дахь дадлагажуулагчийн дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлэх.

4.5. Цогц арга хэмжээг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар удирдлага, арга зүй, зохицуулалтаар хангаж, Улаанбаатар хотод тус газар, аймгуудад аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар зохион байгуулалтыг хангаж ажиллана.

Хэрэгжилт: заалтанд тусгагдсаны дагуу Цогц арга хэмжээний удирдлага, арга зүй, зохицуулалтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хангаж, зохион байгуулалтыг биелэлтийг аймгуудад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хангаж ажилласан.

4.6. Цогц арга хэмжээний зардлын хэмжээ нэг ажлын байранд 10.0 сая хүртэл төгрөг байх бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөтөч, дохионы хэлний орчуулагч болон хувийн туслахын үйлчилгээг энэ зардалд багтаан хэрэгжүүлнэ.

Хэрэгжилт: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрийн нээлттэй зах зээлд ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд ХБИ-н нэг ажлын байранд 10.0 сая төгрөгийг заалтад дурдсаны дагуу зардлыг багтаан хэрэгжүүлсэн.

Санал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байранд шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнийг зардалд багтаан ХБИ онцлог ажлын байранд шаардагдах зардлаас хамаарч мөнгөн дүнг нэмэх боломжтой байхаар тусгах.

Тав. Санхүүгийн дэмжлэг олгох

Ажлын байр шинээр бий болгох, хадгалахад чиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төсөл, санал, санаачлагыг дэмжих зорилгоор дараах барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг олгож, аж ахуй эрхлэлтийн сургалт, борлуулалтын дэмжлэгт хамруулна. Үүнд:

5.1. Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох зорилготой хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эхийн боловсруулсан төслийг шалгаруулж, барьцаагүй, хүүгүй, 50 хувийг нь эргэн төлөх нөхцөлтэй, 3.0-5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэл сарын хугацаатай олгоно.

Анхаарах зүйлс: Төсөл шалгаруулалтад тавигдах шаардлагыг нэмэгдүүлж биелэгдэх боломжтой төслийг шалгаруулж санхүүгийн дэмжлэгийн хэмжээг ихэсгэх хэрэгтэй. Төсөл нь шалгарч дэмжлэг авсан ХБИ болон байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эхийн боловсруулсан төслийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, тулгамдсан асуудлын талаар арга хэмжээ авах нь зүйтэй. Санхүүгийн дэмжлэг авсан ХБИ-ийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд бүрэн хамруулж аж ахуй эрхлэлттэй холбоотой ойлголтыг өгөх хэрэгтэй. Төслийг шалгаруулахдаа хэрэгжилтийн байдлыг сайтар судалж дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

5.1.1. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг удирдлага, арга зүй, зохицуулалтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, зохион байгуулалтаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хангаж ажиллана.

Хэрэгжилт: Заалтад заасны дагуу удирдлага, арга зүй, зохицуулалтаар ХБХХЕГ, зохион байгуулалтыг ХХҮГ хариуцан хэрэгжсэн байна.

5.1.2. Шалгаруулалтаас 3-аас доошгүй долоо хоногийн өмнө тухайн нутаг дэвсгэрийн иргэд, олон нийтэд энэ тухай зар мэдээлэл, сурталчилгаа хийнэ.

Санал: Шалгаруулалтын зарын тухай мэдээлэл, хамрах хүрээний тухай мэдээллийг илүү сайн сурталчилж энэ талаар сургалт, зөвлөгөө өгч ажиллавал илүү үр дүнтэй.

5.1.3. Сонгон шалгаруулалтыг жил бүрийн эхний болон гуравдугаар улиралд зохион байгуулах бөгөөд төслийн сонгон шалгаруулалтын дүн, шийдвэрийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, маргаан гарвал хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэмшүүлэх зорилгоор онцлогт нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгож, тогтвортой ажиллуулах тухай хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах, чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын боловсруулсан төслийг шалгаруулж ажлын байрыг 5.0 сая төгрөгөөр тооцон барьцаагүй, хүүгүй, 20.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх нөхцөлгүйгээр олгоно.

Хэрэгжилт: Судалгаагаар ТББ-д үзүүлэх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилтэд ТББ-ын хамрагдалт бага байсан.

Анхаарах зүйлс: Дэмжлэгийн хамрах хүрээний талаарх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх тал дээр ажиллах хэрэгтэй. Мөн энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ыг нэмэгдүүлэх тал дээр ажиллах нь зүйтэй байна.

5.2.1. Сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар зохион байгуулна.

Хэрэгжилт: Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний сонгон шалгаруулалтыг ХБХХЕГ-аас 3-аас доошгүй долоо хоногийн өмнө нийтэд мэдээллэн, зар сурталчилгаа хийж, ХБИ, ААН, ТББ-уудын ирүүлсэн төсөлтэй танилцан шаардлагад нийцсэн төслийг сонгон шалгаруулж зохион байгуулж хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

5.2.2. Сонгон шалгаруулалтаас 3-аас доошгүй долоо хоногийн өмнө нийтэд мэдээлж, энэ тухай зар сурталчилгаа хийнэ.

Санал: Сонгон шалгаруулалтын зар сурталчилгааны хамрах хүрээг идэвхтэй аргаар нийтэд танилцуулдаг болох нь зүйтэй.

5.2.3. Арга хэмжээг жил бүрийн эхний улиралд зохион байгуулах бөгөөд төслийн сонгон шалгаруулалтын үр дүн, шийдвэрийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, сонгон шалгаруулалттай холбоотой гарсан маргааныг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

5.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн болон нийт ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг аж ахуйн нэгжийн бизнесээ өргөжүүлэх, шинээр тохируулгатай ажлын байр бий болгох тухай, мөн аж ахуйн нэгжийн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тохируулгатай ажлын байранд тогтвортой ажиллуулах тухай боловсруулсан төслийг шалгаруулж, 1 ажлын байрыг 5.0 сая төгрөгөөр

тооцон барьцаагүй, хүүгүй, 20.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгөөр 36 сарын хугацаатай олгоно.

Санал: Хөтөлбөрийн арга хэмжээ тус бүр хоорондоо харилцан уялдаатай нэг арга хэмжээний хэрэгжилтэд дээр нөгөө арга хэмжээ нь хэрэгжих суурь нь тавигдаж байх тул ХБИ-ийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд үр дүнтэй хамруулах, санхүүгийн дэмжлэгийн шалгаруулалтын тавигдах шаардлагыг нэмэгдүүлж дэмжлэгийн хэмжээг нэмж ажлын байрыг нэмэгдүүлэх саналыг дэвшүүлж байна. Мөн нийт ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.

5.3.1. Арга хэмжээний сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар зохион байгуулж ажиллана.

5.3.2. Арга хэмжээний сонгон шалгаруулалтыг хийхээс 3-аас доошгүй долоо хоногийн өмнөөс нийтэд мэдээлж, энэ тухай зар сурталчилгаа хийнэ.

Санал: Сонгон шалгаруулалтын зар сурталчилгааны хамрах хүрээг идэвхтэй аргаар нийтэд танилцуулах ажлыг идэвхтэй зохион байгуулах, хүрэх үр дүнг сурталчлах хэрэгтэй.

5.3.3. Сонгон шалгаруулалтыг жил бүрийн эхний улиралд зохион байгуулах бөгөөд төслийн сонгон шалгаруулалтын дүн, шийдвэрийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, сонгон шалгаруулалттай холбоотой гарсан маргааныг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж болон нийт ажилладаг аж ахуйн нэгжийн хөгжлийн бэрхшээлтэй хүний ажилладаг ажлын байрыг цар тахлын үед хадгалж, хамгаалахад зориулж, Улсын онцгой комиссийн шийдвэрээр үйл ажиллагааг нь хязгаарласан хоног бүрээр тооцож, ажлын байр хадгалах дэмжлэгийг олгоно.

5.4.1. Арга хэмжээг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Хэрэгжилт: Хөтөлбөрийн арга хэмжээг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж байгаа төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

Санал: Мэргэшсэн төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, ТББ-ыг ХБИ-ийн тулгардаг асуудал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаанд хэрхэн оролцдог зэрэг ойлголтыг нэмэгдүүлж чадварыг дээшлүүлэх шаардлагатай.

5.4.2. Ажлын байр хадгалах дэмжлэгийг тухайн байгууллагад ажиллаж байгаа нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний тооноос хамааруулж өдрийн дундаж орлоготой харьцуулан тооцож олгоно.

Хэрэгжилт: ХБИ иргэн ажиллуулж буй байгууллагын ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тооноос хамаарч өдрийн дундаж орлогтой харьцуулан тооцож дэмжлэгийг олгож хэрэгжилтийг хангаж ажилласан.

5.4.3. Ажлын байр хадгалах дэмжлэг авсан аж ахуйн нэгж, байгууллага тухайн иргэдийн ажлын байрыг хадгалах үүрэг хүлээх бөгөөд энэ тухайг холбогдох гэрээнд тусгаж, зохион байгуулагч талтай байгуулна.

Хэрэгжилт: Хөтөлбөрт хамрагдсан ААН-үүд ХБИ-ий ажлын байрыг хадгалах үүрэг хүлээх бөгөөд 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

Санал: Энэхүү ажил олгогчтой хийх гэрээнд ХБИ-ийг оролцуулж гурвалсан гэрээ хийх шаардлагатай. Учир нь ажилд зуучлагдан орсон ХБИ 12 сар хүрэхгүй өөрсдөө ажлаасаа гардаг тохиолдлууд байсан. Иймд шалтгаан нөхцөлийг судалж гэрээ байгуулах нь чухал юм.

5.5. Энэ хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 1 дүгээр тогтоолоор баталсан "Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр"-ийн 3.1.4-т заасан аж ахуй эрхлэлтийн сургалтыг явуулна.

Санал: Энэ хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг аж ахуй эрхлэлтийн сургалтанд үр дүнтэй хамруулж эргэх холбоог бий болгох

5.5.1. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж хийхэд гарах нэмэлт зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд тогтооно.

Аж ахуй эрхлэлтийн сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж хийхэд гарах нэмэлт зардлын жишиг хэмжээг эрэлт хэрэгцээнд нь тулгуурлан баталдаг гэж ойлгож байна. тиймээс нэмэлт зардлын жишиг хэмжээ эрэлт хэрэгцээнд нийцсэн.

5.6. Энэ хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 1 дүгээр тогтоолоор баталсан "Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр"-ийн 3.3-т заасан борлуулалтын дэмжлэгийг үзүүлнэ.

Хэрэгжилт: Судалгаагаар энэхүү заалтад дурдагдсан борлуултын дэмжлэгт хамрагдсан ХБИ, ААН, байгууллага байхгүй байсан.

Зургаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дараах урамшуулал, дэмжлэгийг олгоно.

Анхаарах зүйлс: ХХҮГ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогч нарын хооронд байгуулдаг гэрээнд ажиллаж буй ХБИ-ний ажлын байрандаа тогтвортой ажиллах, тохирох хэрэглэгдэхүүнээр ханган урт хугацааны ажлын байрыг бий болгох талаар нарийвчлан тусгах хэрэгтэй. Ажлын байранд тохируулга хийн ажлын байран дээр дэмжлэгийг үзүүлэх тал дээр анхаарч ажиллах, энэхүү дэмжлэгийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ХБИ, ажил олгогч нарт хөтөлбөрийн талаарх ойлголтыг сургалтаар дамжуулж олгох нь зүйтэй.

6.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй

хүний тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно.

Хэрэгжилт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгож хэрэгжсэн.

6.2. 25 болон түүнээс дээш тооны ажилтантай ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тогтоосон хувиас давсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас давсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор тус тус урамшууллыг нэг удаа олгоно.

Хэрэгжилт: Энэхүү заалт нь хэрэгжсэн.

Долоо. Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны түрээсийн төлбөрт дараах байдлаар дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжилт: 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо цөөхөн байгаагаас энэхүү арга хэмжээний хэрэгжилт аймаг, дүүргүүд дээр харилцан адилгүй хэрэгжсэн харагдаж байна.

Анхаарах зүйлс: Цар тахлын үед ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ 3 жилийн дотор цөөн ХБИ, ААНБ-д олгогдсон нь ХБИ иргэн бүрэн чадваржиж ажлын байртай болдоггүй, зөвхөн өрхийн хэмжээнд үйл ажиллагаа нь явагддаг нь харагдаж байна. Иймд аж ахуй эрхлэлтийн сургалтыг үр дүнтэй болгох нь чухал.

7.1. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны 1-6 дугаар сарыг дуустал хугацааны ажлын байрны түрээсийн төлбөрт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын дээд хэмжээ"-гээр тооцож, нэг удаагийн мөнгөн дэмжлэгийг нөхөн олгоно.

Хэрэгжилт: Заалтад дурдагдсаны дагуу түрээсийн байрны дэмжлэгийн хүрээнд түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг удаагийн дэмжлэгт хамрагдсан ХБИ, ААН, байгууллага судалгаагаар байсан.

Найм. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг богино хугацаанд мэргэжлийн үр чадвар эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг дараах байдлаар зохион байгуулна.

Санал: Эрх бүхий мэргэшсэн, боломжит тохируулгатай, сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн байгууллагаар тусгайлсан, ажил үүргийн үнэлгээг хийж, сургалтын төлөвлөгөө, төлөвлөлтөд суурилсан байгууллагаар хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь ангилж сургалтыг зохион байгуулвал үр дүнтэй байна.

Анхаарах зүйлс: Судалгаанд хамрагдсан ХБИ мэдээллийг үндэслэхэд богино хугацаанд сургалтанд хамрагдаж мэргэшлийн чадамжийн гэрчилгээтэй болсон байсан. Сургалтанд

хамрагдсан иргэд хангалттай чадваржиж чадаагүй, үүнээс хөдөлмөр эрхлэхэд хүндрэл учрах, хувиараа эхлүүлсэн бизнес нь зогсоход хүрч байна. Иймд сургалт зохион байгуулах ААН, ТББ-ыг сонгох шалгуурыг нэмэгдүүлж хяналт тавьж ажиллах нь чухал.

8.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн үр чадвар, чадамжийг 1-10 сарын хугацаанд багтаан эрх бүхий мэргэшсэн боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн байгууллага иргэнтэй гэрээлэн гүйцэтгүүлэх бөгөөд уг сургалт нь модуль хэлбэртэй тусгайлсан хөтөлбөрт суурилсан байна.

Хэрэгжилт: Хөтөлбөрийн хүрээнд ХБИ-дэд хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн үр чадвар, чадамжийг дээрх заалтад заасан хугацаанд, шаардлагад нийцсэн мэргэжлийн байгууллага иргэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж, модуль хэлбэртэй тусгайлсан хөтөлбөрт суурилсан хэлбэрээр УБ хот, аймгуудын хэмжээнд зохион байгуулж хэрэгжилтийг хангасан байна.

8.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн чадамж эзэмшүүлэх, үйлдвэрлэл дээрх ажлын байрны зэрэг тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон төрөл хэлбэрийг сонгон зохион байгуулна. Энэхүү арга хэмжээний хүрээнд хөтөч дохионы хэлмэрчийг бэлтгэх хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримжаа олгох сургалт болон хөгжлийн бэрхшээлийн бусад төрөл хэлбэрийн онцлогт тохирсон нэмэлт сургалтыг хийж болно.

Хэрэгжилт: ХБИ зориулсан хөдөлмөр эрхлэлтийн сургалтаар мэргэжлийн чадамж эзэмшүүлэх, ХБИ иргэний онцлогт тохирсон арга хэлбэрээр ажлын байранд дадлагажуулж зохион байгуулсан. Ингэхдээ нэмэлмээр хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэрийн онцлогт тохируулан хөтөч дохионы хэлмэрчийг бэлтгэх, хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримаа олгох сургалтыг хийж гүйцэтгэсэн байна.

8.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлэн мэргэжлийн үр чадварын тусгайлсан сургалтыг Улаанбаатар хотод Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, аймаг болон алслагдсан 3 дүүрэгт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн сургалт зохион байгуулах дадлага, туршлага бүхий сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

Хэрэгжилт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлэн мэргэжлийн үр чадварын тусгайлсан сургалтыг сургалтыг зохион байгуулах боломжит тохируулга бүхий орчинтой дадлага туршлага бүхий сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулсан.

8.4. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд “Мэргэжлийн сургалтаар чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэдийн мэргэшлийн түвшинг үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу үр чадварын шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв зохион байгуулж, чадамжийн үнэлгээ олгох ба иргэн өөрөө хүсвэл мэргэжлийн зэрэг олгох шалгалтад хамрагдаж болно.

Хэрэгжилт: 1-10 сарын хугацаанд багтаан Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан ХБИ-ийн заалтад дурдсан журмын дагуу үр чадварын шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв зохион байгуулж мэргэжлийн чадамжийн үнэлгээ олгодог. Судалгаагаар хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан ХБИ-д мэргэшлийн чадамжийн гэрчилгээтэй болсон байна.

8.5. Мэргэжлийн сургалт зохион байгуулах байгууллагын сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах танхим хэрэглэгдэхүүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хянаж хөдөлмөр эрхлэлтийн сургалтын мэргэшсэн байгууллагуудын жагсаалтыг гаргана.

Хэрэгжилт: УБ хот /дүүргүүд/, аймгуудын хэмжээнд сургалт зохион байгуулах байгууллагын сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах танхим хэрэглэгдэхүүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хянаж хөдөлмөр эрхлэлтийн сургалтын мэргэшсэн байгууллагуудын жагсаалтыг гаргаж хэрэгжүүлсэн.

Ес. Бусад үйл ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллана.

9.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйл болон хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх,

Хэрэгжилт: хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрийн бэрхшээл адилгүй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдний хэрэгцээ, чадавхид үндэслэн тусгай ажлын байр бий болгох, ажлын байранд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх, боловсрол мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” батлагдан хэрэгжиж байна. Хөдөлмөрийн хуулийн 144 дүгээр зүйл “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт” тусгайлан заасан. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2.“Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна” гэж тусгайлан заасан. Энэхүү заалтын хэрэгжилтийг хангаж ажилладаг ААНБ-ууд нь 144.3-т заасан төлбөрөөс чөлөөлөгддөг. Уг хуулийн заалтыг хэрэгжүүлдэггүй ААНБ-ын шалтгаан нь ХБИ ажилд орохоор хандаж байгаагүй, үр чадвар шаардлагад нийцдэггүй, ажлын байрны тохируулга хийхэд хүндрэлтэй мөн ХБИ ажиллуулах сонирхолгүй байдаг байна.

9.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгаа хийх, эрх зүйн орчныг сайжруулах,

Хэрэгжилт: Тусгайлсан мэргэжлийн байгууллагаар Монгол Улсын эдийн засаг, ажил эрхлэлтийн байдал зэргийг харгалзан, хууль эрх зүйн орчныг гадны улсуудын жишиг баримтыг судалж ажиллах

9.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн жишээг түгээн дэлгэрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажил хийх,

Хэрэгжилт: ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн жишээг түгээн дэлгэрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажлыг ХХҮЕГ,ХБХХЕГ зэрэг сайтууд дээр байршуулах бус олон нийтэд түгээн дэлгэрүүлж мэдээлэх, сургалт, өдөрлөг зохион байгуулж нийгэмд сурталчлах

9.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийн санг боловсронгуй болгох,

Хэрэгжилт: Энэ заалтын хэрэгжилт хангалттай сайн үнэлгээтэй байгаагүй. Учир нь ХХҮХ дээр хөтөлбөрт хамрагдсан ХБИ, ААН, ТББ-ын мэдээлэл зөрүүтэй, мэдээлэл дутагдалтай байсан. Иймд мэдээллийн санг боловсронгуй болгох нь чухал байна.

9.5. Бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэхтэй холбоотой үйл ажиллагаа.

Арав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

10.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

10.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо дэд арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болгосон ажлын байрны тоо,

Хэрэгжилт: Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 30 хүнийг хамруулж, ажлын байртай болгосон байна гэж хөтөлбөрийн үр дүнд тусгасан байна. Монгол улсын хэмжээнд нийт энэхүү цогц арга хэмжээнд нийт 63 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан байна.

Хөтөлбөрт хамрагдсан ХБИ, ААН, ТББ-ын сэтгэл ханамжийг шалгуур үзүүлэлтэд оруулах

10.1.2. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан иргэн, ААНБ дэд арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болгосон ажлын байрны тоо,

Хэрэгжилт: Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 600 орчим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж ажлын байр бий болгосон байна гэж хөтөлбөрийн үр дүнг дүгнэхээр заасан байна. 9 дүүрэг, 21 аймгийн хүрээнд энэхүү арга хэмжээнд нийт 1897 ХБИ/1857/, ААН/17/, ТББ/23/ хамрагдсан байна.

10.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан ажил олгогчийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болгосон болон хадгалсан ажлын байрны тоо,

Хэрэгжилт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 80 орчим ажил олгогчийг хамруулж, 90 орчим ажлын байр бий болгосон байна гэж үр дүнг дүгнэхээр заасан байна. 9 дүүрэг, 21 аймгийн хэмжээнд нийт 161 ажил олгогч хамрагджээ. Арга хэмжээнд хамрагдсан ажил олгогчийн тоо үзүүлэлтэд хүрсэн.

10.1.4. Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хадгалсан ажлын байрны тоо,

Хэрэгжилт: Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт 300 орчим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, ажлын байр хадгалсан байна дүгнэхээр заажээ. Монгол улсын хэмжээнд 9 дүүрэг, 21 аймгийн хэмжээнд нийт 399 ХБИ/332/, ААН/67/, байгууллага хамрагдсан байна. хэрэгжилт сайн, зарим аймаг дээр хэрэгжээгүй.

10.1.5. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамрагдсан хүний тоо, хүйсээр, сургалтын төрлөөр, мэргэжлээр,

Хэрэгжилт: Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд 350 орчим хүнийг хамруулах ба хамрагдсан иргэдийн 70-аас доошгүй хувь нь мэргэшлийн чадамжийн гэрчилгээтэй болсон байхаар үр

дүнг дүгнэхээр заажээ. Монгол улсын хэмжээнд 9 дүүрэг, 21 аймгийн хүрээнд нийт 211 ХБИ хамрагдаж мэргэшлийн чадамжийн гэрчилгээтэй болсон байна.

10.2. Хөтөлбөрийн үр дүн.

10.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 30 хүнийг хамруулж, ажлын байртай болгосон байна.

10.2.2. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 600 орчим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж ажлын байр бий болгосон байна.

10.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 80 орчим ажил олгогчийг хамруулж, 90 орчим ажлын байр бий болгосон байна.

10.2.4. Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт 300 орчим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, ажлын байр хадгалсан байна.

10.2.5. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд 350 орчим хүнийг хамруулах ба хамрагдсан иргэдийн 70-аас доошгүй хувь нь мэргэшлийн чадамжийн гэрчилгээтэй болсон байна.

ДҮГНЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 2 саорын 9-ний өдрийн 1 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нь Монгол улсын 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд хэрэгжсэн. Тус хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ, судалгаа хийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн заалт бүрт дүн шинжилгээ хийсэн.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх, ХБ хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж болон нийт ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг аж ахуйн нэгжид хөтөлбөрт тусгагдсан таван цогц арга хэмжээ, дэд арга хэмжээний дагуу дэмжлэг үзүүлж үр дүнтэй хэрэгжих нь хөтөлбөрийн зорилго, биелэлт юм.

2019, 2020, 2021 онуудын улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэгт хөтөлбөрийн хэрэгжилтийн хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэхэд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 10.2 дахь хэсэгт заасан хөтөлбөрийн үр дүндээ хүрч эрэгжсэн байна.

Хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээгээр хөтөлбөр хэрэгжилтэд тулгамдсан дараах асуудлууд гарсан байна. Үүнд:

1. Аймаг, дүүргийн ХХҮХ-т хөтөлбөрт хамрагдсан иргэд, ААНБ, ТББ-ын дэлгэрэнгүй мэдээлэл нь зөрүүтэй, дутмаг, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн солигддог, тавигдах хяналт муу байна.
2. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд дэмжлэг авсан ХБИ-ийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд бүрэн хамруулдаггүй улмаас хувиараа эрхэлж байгаа бизнес нь зөвхөн өрхийн үйлдвэрлэлийн хүрээнд байна.

3. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний сонгон шалгаруулалтыг судалгаа, шинжилгээ хийж хэрэгжилтийн байдлыг харгалзан дэмжлэгийн хэмжээг нэмэх хэрэгтэй байна. Зарим дэмжлэг авсан иргэд зориулалтын дагуу зарцуулдаггүй нь харагдаж байсан. Иймд хөтөлбөрийн хяналтыг сайжруулах, эргэх холбоог бий болгох нь зайлшгүй шаардлагатай.
4. Хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн сургалт, аж ахуй эрхлэлтийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, ХБИ-ний ажлын байрны тогтвортой байдал ажилд зуучлалыг нэмэгдүүлэх
5. Хөтөлбөр хариуцсан аймаг, дүүргийн ХХҮХ-ийн мэргэжилтэнг чадваржуулах
6. Хөтөлбөрийн талаарх мэдээлэл болон түүний цогц арга хэмжээ хамрах хүрээ, хэрэгжилт, үр ашигтай талыг ХБ иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх, ХБХ-ий үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж болон нийт ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг аж ахуйн нэгжид мэдээлэх тэдний оролцоог нэмэгдүүлэхийн тулд хөтөлбөрийг сурталчилсан өдөрлөг, сургалтыг жилд нэг удаа зохион байгуулж байх

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийн нэгдсэн системийн хяналтыг сайжруулж, ХБХ-ий хэрэгцээнд нийцсэн, оролцоог нь хангаж тэгш шударга байх, хөтөлбөрийн үр дүнд хүрч ажиллах, ажлын байр бий болгох нь чухал юм.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг тусгайлан бүлэг болгон оруулах

Тайлбар: Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавигдах хяналт муу байгаа учраас ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт болон хэрэгжүүлэх байгууллага, ТББ, ААН-үүдэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болон зүйл заалтыг хэрэгжүүлж байна уу гэдгийг хэрэгжилтэд тавих хяналт бүлгээр тусгайлан оруулах хэрэгтэй.

1. 4.1.7-4.1.8 дахь арга хэмжээнүүдэд бэрхшээлийн төрлөөр нь хуваан хувийн туслахын тусламжтайгаар зохион байгуулах.

Тайлбар: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн амьдралд хэвийн оролцоход орчны болон харилцааны байдал ихээхэн саад болж нөлөөлдөг. Жишээ нь: автобус болон тэргэнцэртэй хүний зорчих шат манай оронд стандартын дагуу байдаггүй. Энгийн харилцаанд ийм бэрхшээлтэй тулгарч байхад ажил хөдөлмөр эрхлэхэд орчин хамт олон болон дотоод журам, аюулгүй ажиллагааны дүрмийг бие даан сурах, дасан зохицоход хэцүү. Тиймээс ХБ төрлөөр хуваан хувийн туслахын тусламжтай зохион байгуулах нь чухал юм.

2. 4.3.1-4.1.5 хүртэлх заалтууд нь үр дүнтэй хэрэгжвэл ач холбогдолтой заалтууд

Тайлбар: ХБИ-дэд ажилд орсны дараа хамт олны хандлага чухал. Үүнийг дагаад ХБИ-ийн хөдөлмөр эрхлэх чадвар ажлын бүтээмж өснө. Ажлын хамт олонд сургалтаар ХБИ хүний хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч онцлог, хөдөлмөр эрхлэх чадвар, ялгаварлан гадуурхаггүй байх зэрэг мэдлэгийг олгох.

Хөтөлбөрт хамрагдсан ХБИ, ААН, ТББ-ын сэтгэл ханамжийг шалгуур үзүүлэлтэд оруулах

Тайлбар: Хөтөлбөрийн цогц арга хэмжээнд хамрагдсан ХБИ, ААН, ТББ-уудаас сэтгэл ханамж болон хөтөлбөрт хамрагдсанаар үр дүнтэй байсан эсэх, хөдөлмөр эрхлээд ажлын байран дээр дадлагажуулсан байдал, хүндрэлтэй асуудал, нийцсэн байдал, санхүүгийн

дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдаад ажлын байр бий болгоход тулгарсан асуудал, хувиараа хөдөлмөр эрхлэхэд энэхүү арга хэмжээ нийцсэн эсэх, түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээний талаарх сэтгэл ханамж, сургалтанд хамрагдсан иргэдийн санал хүсэлт зэргийг харгалзан сэтгэл ханамжийн байдлыг шалгуур үзүүлэлт болгох хэрэгтэй. Ингэснээр хөтөлбөрийн дутагдалтай тал, хэрэгжилт зэргийг зэрэг харж хөтөлбөрийг илүү үр дүнтэй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1 ДҮГНЭЛТ

Тоон болон чанарын судалгааны хүрээнд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн таван арга хэмжээнд хамрагдсан 21 аймаг, 9 дүүргийн зорилтот бүлэг буюу ХБИ, ажил олгогч, ААНБ, ТББ-уудаас 523 оролцогчоос (респондент) нүүр тулсан ярилцлагын аргаар тоон асуулга авсан бол зарим оролцогчтой гүнзгийрүүлсэн чанарын ярилцлага хийсэн. Хөндлөнгийн үнэлгээнд нийтдээ 523 иргэн, ААНБ-уудаас амжилттай судалгаа авснаас 56 хувь (295) нь орон нутгаас, 44 хувь (229) нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна.

Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс ирүүлсэн мэдээллийн хүрээнд хөтөлбөрийн арга хэмжээнд хамрагдсан иргэн, байгууллага, зарцуулсан хөрөнгө болон бий болгосон ажлын байрны тоог сүүлийн 3 жилийн байдлаар тоймлон харуулвал:

- Хөтөлбөрт 2019 онд нийт 5,437 хүн хамрагдаж, 2020 онд энэ тоо 34 хувиар буурч 2,658 болсон бол 2021 онд дахин 0.5 хувиар буурч 2,629 болсон байна.
- Харин 2019 онд 2,641,869,628 төгрөг зарцуулсан бол 2020 онд 0.03%-иар буурч 2,502,599,500 төгрөг, 2021 онд долоон хувиар нэмэгдэж 2,871,317,590 төгрөг болсон байна.
- Бий болгосон ажлын байрны тоо 2019 онд 1,004 байсан бол 2020 онд 7 хувиар буурч 874, 2021 онд 3 хувиар нэмэгдэж 932 болсон байна.
- Сүүлийн 3 жилийн байдлаар хөтөлбөрт 3,575 хүн, 64 байгууллага хамрагдаж, 937 ажлын байр бий болж, нийтдээ 5,376,558,959 төгрөг зарцуулагдсан байна.

ХБИХЭДХ-ын хэрэгжилтийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2 дугаар хавсралт хүснэгтийн дагуу тоон үзүүлэлтээр тооцож үзвэл дунджаар 119 хувийн биелэлттэй байна. Хамгийн өндөр үзүүлэлттэй хэрэгжсэн арга хэмжээ нь цогц арга хэмжээ 263 хувьтай, хамгийн бага үзүүлэлттэй хэрэгжсэн арга хэмжээ нь ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ 55 хувьтай байна.

Хүснэгт 19. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэх хүснэгт

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь
				Он	Түвшин		
Бодлогын баримт бичгийн зорилго:							
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллах, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох, ажил олгогчийг дэмжих болон тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар тэднийг байнгын ажлын байраар хангахад оршино.							
1.	ХБИ-ийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах -мөнгөн дүнг (мянган төгрөг)						
1.1.	ХБИ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах	790,000	ХБХ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад	2021	-	30 хүнийг хамруулж, ажлын	79 (263%)

	зээл ажиллахад үзүүлэх дэмжлэг		дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо дэд арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болсон ажлын байрны тоо			байртай болгосон байна.	
1.2.	Санхүүгийн дэмжлэг олгох	2,470,678	Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан иргэн, аж ахуй нэгж байгууллага дэд арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болсон ажлын байрны тоо	2021	-	600 орчим иргэн, ААНБ-ыг хамруулж ажлын байр бий болгосон байна.	805 (127%)
1.3.	ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх	275,390	ХБИ-нд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан ажил олгогчийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болгосон болон хадгалсан ажлын байрны тоо	2021	-	80 орчим ажил олгогчийг хамруулж, 90 орчим ажлын байр бий болгосон байна.	44 (55%)
1.4.	Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх	248,887	Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хадгалсан ажлын байрны тоо	2021	-	300 орчим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, ажлын байр хадгалсан байна.	242 (81%)
1.5.	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах	83,085	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамрагдсан хүний тоо, хүйсээр, сургалтын төрлөөр, мэргэжлээр	2021	-	350 орчим хүнийг хамруулах ба хамрагдсан иргэдийн 70-аас доошгүй хувь нь мэргэшлийн чадамжийн гэрчилгээтэй болсон байна.	165 (67.3%)
ДУНДАЖ		3,868,040					119%

Эх сурвалж: "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 2 дугаар хавсралт

Хөдөлмөр
эрхлэлтийн сургалт
зохион байгуулах



Зорилтот түвшин

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

350

165 (67.3%)

Цогц арга хэмжээ



Зорилтот түвшин

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

30

79 (263%)

Санхүүгийн
дэмжлэг олгох
арга хэмжээ



Зорилтот түвшин

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

600

805 (127%)

Ажлын байрны
түрээсийн төлбөрийн
дэмжлэг



Зорилтот түвшин

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

300

242 (81%)

ХБИ-нд ажлын
байр бий
болгосон ажил
олгогчийн
дэмжлэг



Зорилтот түвшин

Хүрсэн түвшин
(гүйцэтгэлийн
хувь)

80

44 (55%)

2019 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 5622 хүн, 237 ААНБ, ТББ-ыг хамруулж, нийт 1161 ажлын байр бий болгоход 3.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Гүйцэтгэлийн хувиар тооцвол 88.1 хувьтай хэрэгжсэн байна.

Харин 2020 онд тус хөтөлбөрийн хүрээнд 2844 хүн, 274 ААНБ, ТББ-ыг хамруулж, нийт 1089 ажлын байр бий болгоход 3.3 тэрбум төгрөг зарцуулжээ. Гүйцэтгэлийн хувиар тооцвол 80.4 хувьтай хэрэгжсэн байна. 2021 онд нийт 3440 хүн, 325 ААНБ, ТББ-ыг хамруулж, нийт 1265 ажлын байр бий болгоход 6.4 тэрбум төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлыг байрыг дэмжих хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл

№	Он	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Хувь
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	
1.	2019 он*	4992	4,020,080.00	5622	3,542,869.68	88.1%
2.	2020 он**	4989	4,197,840.0	2844	3,376,910.9	80.4%
3.	2021 он***	2848	8,377,308.5	3440	6,432,839.54	76.7%
ДУНДАЖ		4276	5,531,742.83	3969	4,450,873.37	81.7%

* Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

** ХХҮЕГ-аас ирүүлсэн мэдээлэл, 2020 оны нэгтгэл

*** ХХҮЕГ-аас ирүүлсэн мэдээлэл, 2021 оны нэгтгэл

ХӨТӨЛБӨРИЙН САЙН ТАЛ

Санхүүгийн дэмжлэг

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд
 - a. Цаг хугацааг үр бүтээлтэй өнгөрөөдөг.
 - b. Хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг.
 - c. Өрхийн орлогоо нэмэгдүүлдэг.
 - d. Эргэн төлөлт нь 50 хувийн хөнгөлөлттэй, хүүгүй нөхцөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боломж болдог.
2. Улсад
 - a. Ажлын байрыг нэмэгдүүлдэг

Хөдөлмөр эрхлэлтийн сургалт

1. Эрх бүхий мэргэшсэн байгууллагаар тусгайлсан хөтөлбөр төлөвлөгөөгөөр мэргэжлийн үр чадвар олгодог.
2. ХБИ-ийг хөгжүүлж, чадваржуулж, хөдөлмөрт бэлтгэдэг.
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин төсөл хөтөлбөрт холбодог.
4. ХБИ ажил хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг багасгадаг.

Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

1. Тухайн байгууллагад ХБИ-ийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бий болгодог.

Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

2. Цар тахлын үед нүдээ олсон арга хэмжээ болсон байна. Дэмжлэг авсан ХБИ-ийн сэтгэл ханамж, сэтгэгдэл өндөр байна.

ХӨТӨЛБӨРИЙН СУЛ ТАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бичиг үсгийн чадвар сул болохоор зарим зүйлийг сайн ойлгодоггүй. Өөрөөр хэлбэл бичиг үсэггүй бол хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр тухайн ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийг хэрхэн дэмжиж ажиллах хувилбар байхгүй байна.

Хөтөлбөр хэрэгжилт сул байна. Зарим аймагт зөвхөн иргэдэд дэмжлэг үзүүлээд ААН, ТББ-уудад зориулсан дэмжлэг байхгүй байна. ААНБ, ТББ, түрээсийн байрны төлбөрт дэмжлэг үзүүлэх, нээлттэй зах зээлд дэмжлэг үзүүлэх гэх хөтөлбөрүүд Баян-Өлгий аймагт хэрэгжээгүй байна. Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагчид, ХБИ-дэд дэмжлэг үзүүлж байна.

Дэмжлэг эзэндээ очихгүй, нэрээр нь өөр хүн авсан кейс цөөн тоогоор гарсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр дээр төрийн албан хаагчид, бусад хүмүүс хөтөлбөрийн дэмжлэгээс хүртдэг байж болзошгүй байна.

Хүссэн санхүүжилтийг хасч олгодог. Судалгаагаар Булган аймаг нь олон сумтай учраас сум бүрийг хөтөлбөрт хамруулахын тулд санхүүжилтийг хасаж олгодог гэдгийг мэргэжилтэн болон төсөл хөтөлбөр хариуцсан дарга нь хэлж байв. Санхүүгийн дэмжлэг авсан хүмүүсийн сэтгэл ханамж эерэг байсан хэдий ч санхүүгийн дэмжлэгийн хэмжээ бага авахыг хүссэн хэмжээгээр олгодоггүй байна. Жишээ нь 5.000.000 төгрөгний дэмжлэг хүсэхэд 2.5 сая л олддог. Энэ байдлаас харахад өгч байгаа дэмжлэгийг олон хүнд бага хэмжээтэй өгч байгаа нь үр дүнгүй тогтвортой үйл ажиллагаа явуулахад хангалттай дэмжлэг болж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Улирлын чанартай хийгдэх төслийн санхүүжилт хийх улирал нь дууссан хойно ирдэг гэдгийг онцолж хэлсэн. Хөдөө орон нутагт төсөл хөтөлбөрийг олгохдоо ажлын байр, иргэнээ сайн судлахгүй өгдөг болох нь харагдаж байв.

Судалгаанд хамрагдсан нийт иргэд, аж ахуй нэгж, ТББ-ууд хөтөлбөрийн талаархи мэдээлэл дутмаг, олон нийтэд нээлттэй бус, зарлагдаж буй хугацаа богино байдаг гэсэн саналуудыг хэлсэн. Төрийн албанд ажил хүлээлцэхдээ мэдээллээ бүрэн хүлээн авдаггүй байдал нь төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг үнэлэхэд хүндрэл учруулж, цаг хугацаа алдахад хүргэж байлаа.

4.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт

Цогц дэмжлэгийн хувьд шинээр ХБХХЕГ-аас зохион байгуулж байгаа арга хэмжээ бөгөөд ХБИ-дээ ажлын дадлагажуулагчийн заавар дэмжлэгтэйгээр /Job coach/ хөдөлмөр эрхлэх боломжийг олгож байгаагаараа, ялангуяа оюуны бэрхшээлтэй болон сэтгэцийн өвчтэй хүмүүст хамгийн чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээны биелэлт 263 хувь буюу 163 хувь давуулан хэрэгжсэн байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 40 иргэн, ААНБ-аас судалгаа авсан. Уг цогц арга хэмжээнд төвийн бүс, хангайн бүс болон нийслэлийн 8 дүүрэг хамрагдаж, нийтдээ 757,172,000 төгрөгийн дэмжлэг авсан байна. Нийт дэмжлэгийн 94.2 хувь буюу 713,442,000 төгрөгийг нийслэлийн 8 дүүрэг авч үүнээс СБД 200,000,000 төгрөгийн дэмжлэг авсан нь

хамгийн өндөр дүнтэй байна. Харин төвийн бүс 35,740,000 төгрөг, хангайн бүс 7,990,000 төгрөгийн дэмжлэг авсан.

ХБИ-ийн боловсролын түвшиний 85 хувь нь бүрэн дунд, бакалавр, бүрэн бус дунд боловсролыг эзэмшсэн байгаа нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөө үзүүлж байна. Нийт оролцогчдын 86 хувь нь ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа гэж хариулсан бол 14 хувь нь цогц арга хэмжээ эрэлт хэрэгцээнд нийцээгүй гэж үзсэн. ХБИ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ нь ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байгаа шалтгааны талаар ХБИ-тэй ярилцахад үйлдвэрлэлийн түүхий эд, материалын үнэ нэмэгдсэн нь хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа ХБИ-дэд хүндээр тусч үйл ажиллагаагаа зогсооход хүрсэн тохиолдлууд их байна. Мөн ААНБ-уудад ХБИ-ийг ажиллуулахын тулд ажлын байрны тохируулга хийхэд санхүүгийн болон тэдэнд зориулсан техник, багаж хэрэгсэл байхгүй зэрэг асуудлууд үүсдэг байна.

4.1.2 Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт

Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэдийн хувьд биечлэн уулзахад бүгд санхүүжилтээр авсан тоног төхөөрөмж, бараа материал болон хийсэн бүтээгдэхүүнээ нүүр бардам үзүүлж байлаа. Халамж, тэтгэврээс өөр санхүүжилтийн эх үүсвэргүй иргэдэд энэхүү хөтөлбөрийн санхүүжилт нь ихээхэн түлхэц болж, эрхэлж буй үйл ажиллагааг нь түүштай явуулахад томоохон дэмжлэг болж чадсан байна. Иргэдийн дийлэнх саналын хувьд цаашдаа тогтвортойгоор үйл ажиллагаа явуулаад үр дүнтэй байгаа, буцаан төлж чадаж байгаа иргэдээ ахин энэхүү төсөлд хамрагдах боломж өгөх болоод санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлвэл илүү сайн байна гэж үзсэн. Судалгааны явцад ХБИ илүү их хөдөлмөрлөх чин хүсэл эрмэлзэлтэй байгаа, энэхүү дэмжлэг хөтөлбөрт маш их сэтгэл ханамжтай байгаа нь харагдаж байв. Санхүүжилтийн дэмжлэг олгох арга хэмжээний биелэлт 127 хувь байна. 100 хувь биелэхээс 27 хувиар давуулан хэрэгжсэн байна.

ИРГЭНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

ХХҮГХ-ээс ирүүлсэн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд оролцож, санхүүжилт авсан ХБИ болон ААНБ-ийн тоо сүүлийн 3 жилд улсын хэмжээнд 2019 онд 632 иргэн байсан бол 2020 онд 7 хувиар нэмэгдэж 721 иргэн болж, 2021 онд өмнөх оноосоо 3 хувиар буурч 676 иргэнд санхүүгийн дэмжлэг олгосон байна. Зарцуулсан санхүүжилтийн хэмжээ сүүлийн 3 жилд улсын хэмжээнд 2019 онд 1,917,450,000 төгрөг, 2020 онд 1,922,300,000 төгрөг санхүүгийн дэмжлэг олгосон бол 2021 онд өмнөх оноос 9 хувиар өсч 2,297,678,900 төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Иргэн, ААНБ-ын судалгаанд оролцсон нийт 523 хүнээс уг арга хэмжээнд 349 хүн хамрагдаж нийт 2,272,900,000 төгрөгийн дэмжлэг авсан байна. Дэмжлэгийн мөнгөн дүн дээд тал нь 30,000,000 төгрөг, доод тал нь 120,000 төгрөг байна. Дэмжлэгийн хэмжээ хэт бага байх нь хөтөлбөрийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, иргэнд санхүүгийн дэмжлэг олгох хэмжээ нь ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцээгүй байгаа нь үнэлгээнээс харагдлаа. Үүний шалтгаан нь төсөлд бичигдсэн мөнгөн дүнгээр дэмжлэгийн хэмжээг олгодоггүй, олон хүн хамруулахын тулд бага хэмжээгээр дэмжлэг өгдөг нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд бодитой дэмжлэг болж чадахгүй байгаа нь чанарын судалгаагаар харагдсан.

Ажлын байрны тогтвортой байдал харьцангуй сайн байна. ХХҮХГ-аас авсан судалгааны мэдээллээс улсын хэмжээнд 1,275 нь өрхийн үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч ХБИ-д, 115 нь байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эхчүүдэд санхүүгийн дэмжлэг олгосон байна. ХБИ-ийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх асуултад 90 хувь нь нийцсэн, 10 хувь нь нийцээгүй гэж хариулсан. Дэмжлэг авсан иргэдтэй ярилцахад тогтвортой ажлын байртай болсноор үйл ажиллагаагаа өргөжүүлж, ХБИ-ийг ажлын байраар хангаж, өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг бий болгож байгаа боловч бараа бүтээгдэхүүний үнэ өсч нийгэм, эдийн засгийн байдал хүндэрч байгаа энэ үед дэмжлэгийн хэмжээг нэмэхгүй бол олсон орлого нь эргэлтийн хөрөнгө болж чаддаггүй байна гэсэн.

Сүхбаатар аймгийн хувьд сүүлийн 3 жилд үзүүлсэн дэмжлэгүүд нь очвол зохих эзэддээ хүрсэн байна. ХБИ-дэд үзүүлсэн санхүүгийн болоод түрээсийн хөнгөлөлтийн дэмжлэгүүд нь тэдний амьдрал ахуйд нь эергээр нөлөөлж ялангуяа цар тахлын үед амьдрал ахуйд нь хэрэг болсныг дурьдаж байв. Тухайн дэмжлэгийг үр дүнтэй ашигласан хүн олонхи нь байсан бөгөөд 1 хүн үр шимийг нь хүртэж чадаагүй төдийгүй эргэн төлөлтөө ч хийгээгүй шүүхэд шилжсэн байна.

Сэлэнгэ аймгийн хувьд орон нутагт дэмжлэг авах иргэний тоог нэмэгдүүлэхийн тулд төслийн квотыг нэмэгдүүлэх шаардлагатай байна гэсэн санал дэвшүүлсэн. ХБИ-ээс маш олон төсөл ирдэг ч цөөн тоотой байдаг учир хүртээмжтэй биш байдаг нь харагдаж байна. ХБХүүхдээ асран халамжилж байгаа эцэг эхийг дэмжих, хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн саналыг гаргасан.

Орхон аймгийн хувьд төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалт явуулж байгаа боловч эргээд иргэндээ хир хүртээмжтэй байгаа байдлыг олж харахгүй, зээлийн эргэн төлөлтөнд нь хэт их анхаарч байгаа нь буруу гэж үзсэн. Хөтөлбөрт богино хугацаанд хамруулж байх, жишээ нь сарын 70 мянган төгрөгний эргэн төлөлттэй иргэн 3 жил зээлээ төлөөд дараа нь хамрагдах эсэх нь шийдэгдэнэ гэдэг нь буруу гэж үзсэн. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүжилт нь 50 хувийн эргэн төлөлттэй байдаг. Харин ХБХ-ээ асарч буй эцэг эхэд төслийн санхүүжилт нь 100 хувь эргэн төлөлттэй байгаа нь ялгавартай байна гэсэн. ХБИ-ийн хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа нь сайшаалтай боловч төсөлд бичсэн санхүүжилтийг олгодоггүй, хасч олгодог нь дэмжлэг болж чадахгүй, хүссэн хэмжээндээ хүрч ажиллах боломжгүй, 3-4 жилд ахиад хөтөлбөрт хамрагдаж чадахгүй дэмий зээлийн эргэн төлөлттэй байгаа нь түгээмэл харагдсан.

Төв аймгийн хувьд яг хөдөлмөр эрхэлж буй хүмүүсдээ зээлийн хэмжээ бага байна гэсэн санал олон байсан. Ажлын байраа нэмэгдүүлэх, хийж байгаа бүтээгдэхүүний нэр төрлөө олшруулах зэрэгт хүрэлцээ муу байдаг учраас зээлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хийдэг хүнийг зөв судалж, таньж өгөх хэрэгтэй байна. Харин юм хийгээгүй хүмүүсийн хувьд хүнд үзүүлэх юм ч байхгүй байна. Сайн судалгаа хийж зээлээ олговол хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэлтэй хүмүүс нь үлдээд байх магадлалтай байна.

СХД-ийн хувьд санхүүгийн дэмжлэгийг дүүргийн олон иргэн байдаг учир хүртээмжтэй болгох үүднээс нэг хүнд олгох 5 сая төгрөгийг хувааж 1 сая, 2 сая, 3 сая гэх мэтээр иргэдэд олгосон тохиолдол байна. Иргэдээс судалгаа авахад анх төсөл бичихдээ тоног төхөөрөмж авах, эсвэл тоног төхөөрөмжөө сайжруулах гэж 5 сая төгрөг хүсдэг ч иргэдэд дэмжлэгийг хувааж өгсөнөөр тоног төхөөрөмж авч хүрэлгүй бараа материал, аар саархан зүйлст мөнгөө

зарцуулдаг байна. ХБХүүхдэдтэй өрх толгойлсон эх, байнга хэвтэрт байдаг нөхрөө асардаг бага насны хүүхдүүдтэй ээж гэх мэт хажуудаа туслах хүнгүй ганцаараа ажиллаж байгаа хүмүүсийн байдал нэн хүнд байна.

ЧД-ийн хувьд ХБИ-ийн хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа нь сайшаалтай боловч хүссэн санхүүжилтийг олгодоггүй хасч олгодог нь тухайн хүмүүсийн хувьд бүрэн дүүрэн дэмжлэг болж чадахгүй байгаа нь харагдсан.

ТББ-Д САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

ТББ-уудад олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээг харвал 2019 онд 665,000,000 төгрөг байсан бол 2020 онд 10 хувиар өсч 805,000,000 төгрөг болсон. Харин 2021 онд 18 хувиар буурч 560,000,000 төгрөг болсон байна.

Судалгаанд оролцсон ТББ-уудын 77 хувь нь санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгож байгаа нь зөв гэж үзсэн. ТББ-ын захирлуудтай ярилцахад эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгогдож байгаа дэмжлэг нь ХБИ-ийг дэмжсэн үр өгөөжтэй арга хэмжээ мөн бөгөөд авсан дэмжлэгээрээ ажлын байр, тоног төхөөрөмжөө шинэчилж, ажлын байрны тоогоо нэмэгдүүлэн тогтвортой үйл ажиллагааг явуулж байна гэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй ТББ-ын захирлууд ажилчдаа ойлгож, тэднийг хөгжүүлж, хувь хүний хөгжилд нь анхаарч ажилладаг нь харагдаж байсан. Түүнчлэн ТББ-уудын удирдлагууд ХБИ-ийг цагийн менежмент сайн, ажил голдоггүй, цалин голдоггүй, ажлыг сэтгэлээсээ хийдэг, мөн ХБИ нь ажил хийх чинь хүсэлтэй, нийгмээс гадуурхагдахгүй хамт олонтой байх хүсэл, тэмүүлэл их байдаг хэмээн ярьж байсан. Иймд тэднийг чадваржуулах сургалтанд хамруулж, тогтвортой ажлын байраар хангаж энэхүү арга хэмжээг үргэлжлүүлэн, сайжруулах хэрэгцээ зайлшгүй байна.

ААН-Д САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

ААН-үүдэд олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 2019 оны байдлаар 245,000,000 байсан бол 2020 онд 36 хувиар буурч 115,000,000 болсон бол 2021 онд 69 хувиар нэмэгдэж 620,000,000 төгрөгт хүрсэн. Уг арга хэмжээний хүрээнд сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 980,000,000 төгрөгийн дэмжлэгийг аж ахуйн нэгжүүдэд олгоод байна.

- ААН-ын үйл ажиллагааны чиглэлийн хувьд гар урлал (оёдол эсгүүр, мужаан, модон эдлэл, арьс ширэн эдлэл), компьютерийн бүх төрлийн үйлчилгээ болон гэрэл зураг, газар тариалангийн (хүнсний ногоо) чиглэлээр түлхүү үйл ажиллагаа явуулж байна.
- Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд оролцсон ААН-ын 67 хувь нь НДШ төлдөг байна.
- ААН-үүдийн үйл ажиллагааны тогтвортой байдал сайн байна.

4.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилд авсан ААН, ТББ-тай ярилцлага хийхэд хөгжлийн бэрхшээлтэй ажилчид ихэвчлэн ажлын байрандаа байхгүй, асуухад ковидын үед гэрээр ажиллаж байгаа, эмнэлэгт хэвтсэн, хүүхэд гаргасан, эмнэлгээр үзүүлж яваа гэх мэт олон шалтгаануудыг тоочиж байв. Ихэнх байгууллагууд хөнгөн бэрхшээлтэй хөдөлмөрийн нээлттэй зах зээлд ажиллаж болох хүмүүс (харшил, үе мөч, дотор эрхтэн, хараа гэх мэт 50,

60 хувийн хөдөлмөрийн чадвар алдалттай) авч ажиллуулсан байгаа нь ажлын байранд тохируулга хийх шаардлагагүй байгаа нь "тохирсон ажлын байраар хангах" гэдэг хөтөлбөрийн зорилгод нийцсэн эсэх нь эргэлзээтэй байлаа.

ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ 55 хувийн хэрэгжилттэй байна. Улсын хэмжээнд сүүлийн 3 жилийн байдлаар энэхүү арга хэмжээнд хамрагдах ажил олгогчийн тоо өссөн байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар Улсын хэмжээнд 2019 онд 193,868,000 төгрөгийг ХБИ-нд ажил олгогч нарт зарцуулсан бол 2020 онд 2 хувиар буурч 186,280,000 төгрөг, 2021 онд 22 хувиар нэмэгдэж 293,900,000 төгрөг зарцуулаад байна. Харин иргэн, ААНБ-аас авсан судалгаанд ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдаж, дэмжлэг авсан иргэн, ААНБ-аас 63 оролцогч судалгаанд хамрагдсан.

Сүүлийн 3 жилд аймгийн болон Улаанбаатар хотын хэмжээнд бий болгосон ажлын байрны тоо болон хадгалсан ажлын байрны тоо тогтвортой өссөн. Харин Улаанбаатар хотын хэмжээнд 2019 онд 45 байсан бол 2020 онд бий болгосон ажлын байрны тоо 14-өөр буурч 31 болсон бол 2021 онд 12 ажлын байраар нэмэгдэж 43 хүрчээ. Энэхүү арга хэмжээ нь ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцэж байна.

4.1.4 Цар тахлын үед ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт

Цар тахлын үед ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд цөөн иргэд хамрагдсан байна. ХБИ бүрэн чадваржиж ажлын байртай болдоггүй, зөвхөн өрхийн хэмжээнд үйл ажиллагаа явагддаг учраас дэмжлэг авах нь бага байна. ХБИ-ийг өрхийн үйлдвэрлэлээс хөдөлмөрийн нээлттэй зах зээл рүү шилжүүлэх оролдлого байхгүй байна. Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ 81 хувийн хэрэгжилттэй байна.

Тус арга хэмжээний хүрээнд аймаг, дүүргээс ирсэн мэдээллийг нэгтгэж, сүүлийн 3 жилийн байдлаар Улсын хэмжээнд 2019 онд 75 хүн түрээсийн дэмжлэгт хамрагдсан бол 2020 онд 30 иргэн, ААНБ хасагдаж 45 болсон бол 2021 онд шинээр 143 иргэн, ААНБ нэмэгдэж 188 нь иргэн, ААНБ болсон байна. ХХҮГХ-ээс ирүүлсэн мэдээллээс ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан ААНБ-ын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хадгалсан ажлын байрны тоог харахад хамрагдсан ААНБ-ын тоо зарцуулсан хөрөнгийн өсөлтөөр сүүлийн 3 жилээр жил тутам өссөн байна. Харин хадгалсан ажлын байрны тоо 2020 онд өмнөх оноос буурсан гэхдээ 2021 онд 70 хувиар өсч 119 болсон.

Олгож буй түрээсийн төлбөрийн хэмжээ нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх асуулгад 82 хувь нь нийцсэн, 18 хувь нь нийцээгүй гэж хариулсан байна. Ковид-19 цар тахал болон бараа материалын үнийн өсөлтөөс болж түрээсээ төлж чадахгүй өрөнд орсон тохиолдол байна. Түрээсийн дэмжлэгт хамрагдах гэсэн иргэдэд ХХҮТ хүнд суртал гаргадаг гэсэн кейс цөөнгүй байна. Түрээсийн дэмжлэгт хамрагдаж, үйл ажиллагаа тогтворжиж эхлээгүй байхад тухайн сард НДШ, түрээсийн төлбөр төлөх нь ААНБ болон ХБИ-нд хүндрэл үүсгэж байна.

4.1.5 Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийн дүгнэлт

Хөдөлмөрт бэлтгэх үр чадвар олгох сургалтанд залуу ХБИ-ийн хамрагдалт муу байна. Мөн сургалтын хугацаа богино, сургалтад хамрагдсан ч ажлын байранд зуучлагдаагүй тохиолдол түгээмэл байна. Энэ нь дүүрэгт тохиргоотой ажлын байр бий болгох төрийн байгууллага, ААН-үүд байхгүй байгааг харуулж байгаа юм. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээ 67.3 хувийн хэрэгжилттэй байна.

2021 онд хөдөлмөр эрхлэлтийн сургалтын 11 байгууллага шалгарч 165 ХБИ-нд чадамжийн гэрчилгээ олгосон байна. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх судалгаанд 13 иргэн оролцсон бөгөөд нэг хүнд ногдох сургалтын зардлын хэмжээ 30,000 төгрөг байна. Нэг хүнд ногдох зардлын хэмжээ нь зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцдэг гэж 89 хувь нь үзсэн.

Сургалтын дадлага хийлгэдэг гэж 54 хувь нь, хийлгэдэггүй гэж 46 хувь хариулсан бол сургалтын хугацаа, мэргэжлийн төрөл, эзэмшүүлж буй үр чадвар нь иргэний хэрэгцээ шаардлагад 92 хувь нь нийцдэг гэсэн. Сургалтын хугацаа, мэргэжлийн төрөл, эзэмшүүлж буй үр чадвар нь ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад 82 хувь нь нийцэж байгаа гэсэн бол үлдсэн 18 хувь нь нийцдэггүй гэсэн байна.

Суралцагчийн сэтгэл ханамжийн хувьд оролцогчид 70 хувьтай гэж хариулсан байна. Сургалтанд хамрагдсан иргэдийн эерэг сэтгэгдлийг харвал, сургалтанд хамрагдсандаа талархаж байгаагаа илэрхийлээд сургалт орсон багшаас их зүйл сурч, сурсан зүйлээ ашиглан тогтвортой ажлын байртай болсноо ярьсан байна. Сургалтанд хамрагдсан иргэдийн сөрөг сэтгэгдлийг харвал, сургалтын төвүүд ХБИ-д тохируулсан сургалтын байранд сургалт ороогүйгээс сургалтанд хамрагдах хүсэлтэй хүмүүс оролцох боломжгүй болох тохиолдлууд байна. Иймээс сургалтын орчинг сайжруулах хэрэгтэй байна.

4.2 ЗӨВЛӨМЖ

Цаашид ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн мэдээллийн нэгдсэн сантай болох (Data base) шаардлагатай байна. Хөтөлбөрт хамрагдсан иргэд, ААНБ-уудын мэдээлэл, хэзээ дахиж хамрагдах боломжтой болох, эргэн төлөлтийн мэдээлэл зэргийг агуулсан цогц мэдээллийн сантай болох саналыг дэвшүүлж байна.

Санхүүгийн дэмжлэгээс гадна мэргэжил олгох болон нийгмийн харилцаанд хэрхэн оролцох талын сургалт хийх, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг орон нутагт болон улсын хэмжээнд цаашилбал олон улсын хэмжээнд зохион байгуулах шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдлаа.

ХБИ-ийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгдсэн төвтэй байхыг илүүд үзэж байна. Үүний давуу тал нь тусгай хэрэгцээ хангагдах нөхцөл бүрдэж, хамт олон болж нийгэмшихүйд нь эерэг нөлөө үзүүлэх юм. Мөн борлуулалтанд сайн нөлөө үзүүлж нэг цэгийн үйлчилгээнд төвлөрч хэрэглэгчдэд ойртохоос гадна хамтран ажилладаг байгууллагын хамтын ажиллагаа, хяналт сайжрах боломжтой.

ХБИ-нд олгох санхүүгийн дэмжлэгийг хувааж өгөх биш бүтэн дүнгээр дэмжлэг олгох нь зөв гэсэн саналыг дэмжлэгт хамрагдсан ХБИ илэрхийлж байсан. Мөн дэмжлэг хүссэн иргэд 4, 5-аараа баг болж хамтаар нь зээл олгох нөхцөл бүрдүүлэх саналыг дэвшүүлж байна.

ААН, ТББ-ууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж байгаа боловч ХБИ нэг ажлын байранд удаан тогтдоггүй, өөртөө итгэлгүй, ажлаа хийхгүй алга болдог гэж судалгаанд оролцогчид хэлж байлаа. Тиймээс ХБИ-г нийгэмшүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээгээр дэмжих, ажлын цагийг тогтоож өгөх гэх мэт ажлуудыг нэмэлтээр хийж өгөх шаардлагатай байна.

Судалгаанд оролцсон нийт ААН, ТББ-д сэтгэц, оюун ухааны бэрхшээлтэй маш цөөн хүн ажилд орсон байгаа нь ХБХХЕГ, ХХҮЕГ анхааралдаа авч хөтөлбөртөө энэ төрлийн бэрхшээлтэй хүнийг ажил хөдөлмөр эрхлүүлэхэд тусгайлан анхаарах хэрэгтэй байна. Судалгаанд хамрагдсан нийт иргэд, ААН, ТББ-ууд хөтөлбөрийн талаархи мэдээлэл дутмаг, олон нийтэд нээлттэй бус, зарлагдаж буй хугацаа богино байдаг гэсэн саналуудыг хэлсэн учраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн мэдээллийг нөлөөллийн аян байдлаар явуулах, мэдээлэл, харилцаа холбооны үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл хэрэгтэй байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙГ ХӨДӨЛМӨРИЙН НЭЭЛТТЭЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АЖИЛЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Хөтөлбөрт хамруулахын өмнө иргэдэд сургалт мэдээлэл хийх

Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт хамрагдах хүмүүсийг төсөл бичих сургалтанд хамруулах, хаанаас ямар чиглэлийн төсөл хөтөлбөр хэрэгждэг талаар мэдээллийг өгөх хэрэгцээ их байна.

Бизнесээ хэрхэн зөв удирдаж амжилтанд хүрэх талаарх сургалт, зөвлөгөөг тогтмол өгөх шаардлагатай байна.

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

Олгож буй санхүүгийн дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлэх

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн бага хувь нь сэтгал хангалуун байсан бол ихэнх нь зээлийн хэмжээ нь хүрэлцээгүй гэдгийг онцолсон. Иргэн, асран хамгаалагчид нь дэмжлэг болж байгаа ч гэсэн хангалттай биш байна гэж дүгнэж байна. Учир нь санхүүгийн дэмжлэгийн хамгийн дээд хэмжээ нь 4 сая. Бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн энэ цаг үед ажлын байр бий болгоход шаардлагатай тоног төхөөрөмж авах, түрээсийн, цахилгааны төлбөр болон бусад зардлуудад 1,500,000-4,000,000 төгрөг хангалтгүй байна. Тиймээс цаашдаа хөтөлбөрт хамрагдах иргэдээс судалгаа авч, төсөл төсөвтэй нь сайн танилцаж шаардлага хангасан тохиолдолд хангалттай хэмжээний зээл өгөх хэрэгтэй байна.

Цаашид хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийнхээ дуу хоолой, санал хүсэлтийг нь сонсон харилцан ойлголцож илүү үр дүнтэй хамтран ажиллах нь зүйтэй байна гэж үзэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй маш олон иргэд ажлын байргүй байгааг харгалзан бүх хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар тэгш хангах боломж нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Иймд цаашид хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан албан байгууллага, хувийн хэвшил, иргэдийн ажлын байрны онцлог нөхцөл байдалд бодитой дүн шинжилгээ, тооцоо судалгаа хийж бизнест нь хангалттай хэмжээгээр зээлийг олгох зайлшгүй шаардлага тулгарч байна.

Санхүүгийн дэмжлэгийг зорилго, хэрэгцээг харгалзахгүй олон хүнд хүртээж өгснөөс болж амьжиргааны болон өрхийн үйлдвэрлэлийг цааш нь үргэлжлүүлэх боломжгүйд хүргэж байна. Цар тахалтай холбоотойгоор бараа материалын үнэ өссөн, хүмүүсийн худалдан авах чадвар буурсан, санхүүгийн дэмжлэгийн хэмжээ хэт бага зэрэг шалтгаанаас хамаарч хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтэд эерэг ахиц өөрчлөлт гарахгүй байгаа нь үнэлгээний явцад харагдлаа.

Мөн хөтөлбөрийн тогтвортой байдалд анхаарах нь зүйтэй. Зээл аваад хугацаанаас нь өмнө болон хугацаандаа төлж дууссан найдвартай иргэн, ААН-үүдийг дараа дахин хамрагдах хугацааг нь харах, санхүүгийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалт хэрэгтэй байна. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллага болон иргэд ААН-үүдтэй уялдаа холбоотой байх, бүртгэл шинэчлэх ажлуудыг тогтмол хийх шаардлагатай байна.

1. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний дэмжлэгийн хэмжээ хэт бага байх нь хөтөлбөрийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Иймд бичил бизнес эрхэлдэг иргэдийн зээлийн хэмжээг нэмж, эргэн төлөх хугацааг уртасгавал илүү бодит дэмжлэг болно.
2. Зээл авсан иргэдэд өрхийн бичил бизнес эрхлэхэд санхүүгээ хэрхэн зөв удирдах чадвар эзэмшүүлж, ХХҮГХ-ээс эргэх холбоотой байж, зөвлөгөө мэдээлэл хангалттай өгч байх хэрэгтэй гэж үзэж байна.
3. ХБИ болон ХБИ-ийг асардаг хүмүүст хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг нь өсгөхийн тулд ХБХ-ийг асарч, тэдэнд боловсрол болон бие даах чадвар олгох төвүүд бий болгох эсвэл өдөр өнжүүлэх төвүүд сайн дураар ХБХ-ийг авсан тохиолдолд улсаас урамшуулал олгодог болговол хөдөлмөр эрхэлж байгаа эцэг, эхийн бүтээмж сайжирна гэж үзэж байна. Мөн СӨБ, ЕБС-ийн багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогийн талаарх сургалтанд хангалттай хамруулах шаардлагатай.

4. ААНБ-уудын удирдлага, хамт олонд ХБИ-ийг хэрхэн дэмжиж ажиллах, тэдэнд ХБИ-ийн сэтгэлзүйн талаар болон хамтарч ажиллах арга зүйн талаар сургалт ордог байх. Мөн ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг олон нийтэд сурталчилсан компани т ажлыг төрөөс дэмжиж ажилснаар ХБИ-дэд учирдаг нийгмийн сөрөг хандлага багасаж, тэднийг дэмжсэн эерэг хандлага бий болно.
5. Дэмжлэгийн хэмжээг төсөлд тусгагдсан тоон дүнгээр санхүүжилт олгож, эргэн төлөгдөх хугацаатай дэмжлэгийн хугацааг уртасгах хэрэгтэй. Ингэснээр дэмжлэгт хамрагдсан иргэн, ААНБ шаардлагатай тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн түүхий эд, материал бусад шаардлагатай хэрэгслийг цогцоор худалдан авч төслөө 100 хувь хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.
6. Мөн ХБИ-д зориулсан хөрөнгө оруулалтын зээлийн шинэ үйлчилгээг судалж, хэрэгжүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, ААН-үүдийг өсөх, томрох боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОСОН АЖИЛ ОЛГОГЧИД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

ХБИ-ний ажиллах орчинг бүрдүүлсэн торхируулгатай аж ахуй нэгжийг шагнах урамшуулах, торгуулиас чөлөөлөх арга хэмжээг авдаг байх.

1. Арга хэмжээнд хүнд хэлбэрийн бэрхшээлтэй боловч хөдөлмөр эрхлэх боломжтой ХБИ-ийг хамруулах боломжийг нэмэгдүүлэх хэрэгтэй.
2. ХБИ-ийг хувийн хэвшлийнхэн дэмжиж ажилладаг харин төрийн байгууллагууд харин энэ тал дээр хариуцлагагүй хандаж байгаа хандлагыг өөрчлөхөд анхаарах.

ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖЛЫН БАЙРЫГ ХАДГАЛАХ ХҮРЭЭНД АЖЛЫН БАЙРНЫ ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. Иргэдэд олгож буй түрээсийн төлбөрийн хэмжээг зах зээлийн үнэлгээгээр өгөх хэрэгтэй байна. Ингэснээр ажлын байрны тогтвортой байдал хадгалагдаж, үйл ажиллагаа өргөжих боломжтой юм.
2. ХХҮГХ болон төрийн байгууллагуудад ХБИ-д үйлчилдэг ажилтан байхгүйгээс үзэл бодлоо илэрхийлэх эрх зөрчигдөж байгаа тул ХБИ-дэд үйлчилдэг ажилтан бий болгож, ХХҮГХ-ийн ажилчдыг тогтмол сургалтаар хангах шаардлагатай.
3. ХХҮГХ-ийн мэргэжилтэн ХБИ-дэд хэрэгцээтэй хууль болон мэдээ, мэдээллийн талаар сургалт ордог байх.
4. Түрээсийн дэмжлэгт хамрагдсанаас хойш үйл ажиллагаа тогтворжих хүртэл буюу 3 сарын дараа НДШ, түрээсийн төлбөр төлөх арга хэмжээг хэрэгжүүлвэл тус арга хэмжээний үр дүн сайжирна гэж харж байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Зохион байгуулж буй сургалтыг чанаржуулах

Хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалтанд сууж төгссөн иргэдийн хувьд 14-21 хоногийн сургалтад хамрагдаад хангалтай сайн мэдлэгтэй болж чадахгүй байна. Бас сургалтанд суусны дараа ажлын байранд зуучлахгүй байгаа учраас сургалтын чанарыг

сайжруулах, хугацааг нэмэгдүүлэх, ажлын байрны зуучлалыг заавал хийх шаардлагатай байна.

Хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалтад сууж төгссөн иргэдийн хувьд төгсөөд баталгаатай ажлын байраар хангагдах, хувиараа ажиллах шийдвэр гаргасан тохиолдолд үргэлжлүүлэн урт хугацааны хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах хэрэгцээтэй байна.

1. ХБИХЭДХ-ийн хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг арга хэмжээний чиглүүлгийг сайжруулж, дагаж мөрдөх хэрэгтэй.
2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг ХБИ-нд тохируулгатай сургалтын газар зохион байгуулах буюу гадаад, дотоод орчинд ХБИ-нд саадгүй байх.
3. Сургалтын нэр төрлийг нэмэгдүүлэх. Үүнд компьютер, гадаад хэл, сэтгэл зүйн, хувь хүний хөгжлийн сургалт зэргээр нэмэгдүүлж, тэдний онцлогт тохируулан, мэргэжлийн багш нартай хамтарч ажиллах.
4. ХБИ-нд хувийн туслахын үйлчилгээг бий болгох хэрэгтэй
5. ХБИ-ийг чанартай сургалтаар хангаж байж ажлын байранд тогтвортой ажиллах боломж нь нэмэгдэх учир сургалтын чанарыг сайжруулах хэрэгтэй.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хяналт үнэлгээ хийж, мэдээлэл цуглуулсан судлаачдийн дүгнэлтүүдийг хавсаргав. Нийт 23 судлаачийн дүгнэлт ирсэн. 21 аймгаас 5 аймаг / Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг, Өмнөговь аймаг, Өвөрхангай аймаг, Говь-Алтай аймаг/-ийн судалгаа ирээгүй харин 9 дүүргээс Налайх дүүрэг, Багахангай дүүргийн судалгааны мэдээлэл ирээгүй тул хавсралтад ороогүй.

Судлаачийн тайлан-1

Судлаачийн нэр

Ч. Тунгалагтамир, Т. Чимидлхам /ХБХЭЭХ/

Байршил

Архангай аймаг

Судалгаанд оролцогчдыг төсөл хөтөлбөр бичих сургалтанд хамруулах хэрэгтэй байна. Хаанаас ямар чиглэлийн төсөл хөтөлбөр хэрэгждэг талаар мэдээлэлийг өгөхгүй байгаа нь харагдаж байна.

“Бизнэсээ хэрхэн зөв удирдаж амжилтанд хүрэх вэ” сургалт зохион байгуулвал үр дүнтэй. Зөвлөгөө өгөх ТББ, бизнес эрхлэгчдийг нэгтгэсэн нэгдсэн мэдээллийн сан шаардлагатай байна.

Иргэд банкны 3 хувийн зээлд хамрагдаж өргөжүүлэх мөн авсан санхүүжилтээ хугацаанаас нь өмнө төлөөд дахин санхүүжилт авдаг нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. Мөн Японы Хүүхдийн ивээх сан, Дэлхийн зөн ОУБ-ын бизнесийн чиглэлтэй болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах хэрэгцээ өндөр байна.

Судлаачийн тайлан-2

Судлаачийн нэр

Т. Ерлан, А. Айжан /ХБХЭЭХ-зохицуулагч/

Байршил

Баян-Өлгий аймаг

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Мэргэжлийн социологичдын холбооноос явуулж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн судалгаанд судлаачаар ажиллаж, 2019, 2020, 2021 оны хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийлээ. Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, сургалтанд хамрагдсан иргэдийн судалгааг авсан.

Үүнээс харахад Баян-Өлгий аймагт ААНБ, ТББ, түрээсийн байрны төлбөрт дэмжлэг үзүүлэх, нээлттэй зах зээлд дэмжлэг үзүүлэх гэх хөтөлбөрүүд Баян-Өлгий аймагт хэрэгждэггүй байна. Зөвхөн ХБХ-тэй асран хамгаалагчид, ХБИ-д өгдөг юм байна. Бас энэхүү хөтөлбөрт хамрагдаж байгаа хүмүүс ч бага цөөхөн байна. Бусад хөтөлбөрүүд нь Баян-Өлгий аймагт хэрэгжихгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан -6, Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд оролцсон- 2 гээд нийт 8 хүнээс судалгаа авлаа. Нийт судалгаанд оролцсон иргэдийн санал хүсэлт, сэтгэгдлийг судалгааны маягтын дор хавсралтаар оруулсан.

Судалгаа авах үед судлаач хүн бидний хувьд энэхүү хөтөлбөр хэрэгжиж хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асран хамгаалагчид нь дэмжлэг болж байгаач гэсэн хангалттай биш байна гэж дүгнэж байна. Учир нь санхүүгийн дэмжлэгийн хамгийн дээд хэмжээ нь 4 сая.

Бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн энэ цаг үед ажлын байр бий болгоход шаардлагатай тоног төхөөрөмж авах, түрээсийн, цахилгааны төлбөр болон бусад зардлуудад 1,500,000-4,000,000 төгрөг хангалтгүй байна.

Хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалтанд сууж төгссөн иргэдийн хувьд 14-21 хоногт сургалтанд хамрагдаад сайн мэдлэгтэй болчихдог гэж бодохгүй байна. Бас сургалтанд суусны дараа ажлын байраар зуучлахгүй байна.

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн цөөн тооны хувь нь сэтгэл хангалуун байсан бол ихэнх нь зээлийн хэмжээ нь хүрэлцээгүй гэдгийг онцолсон. Тиймээс цаашдаа хөтөлбөрт хамрагдах иргэдээс судалгаа авч, төсөл төсөвтэй нь сайн танилцаж шаардлага хангасан тохиолдолд хангалттай хэмжээний зээл өгөх хэрэгтэй байна.

Судлаачийн тайлан-3

Судлаачийн нэр

-

Байршил

Баянхонгор аймаг

Баянхонгор аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулсан сүүлийн 3 жил мэдээнээс түүврийн аргаар асуумж судалгааг хийсэн. *Санхүүгийн дэмжлэг хөтөлбөрт хамрагдсан ХБИ-ээс асуумж судалгаа авч, уулзаж ярилцлагыг дүгнэхэд:*

Сайн тал:

- Санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлж байна гэж үзэж байна.
- Хувиараа болон өрхийн үйлдвэрлэл эрхэлж, цаг хугацааг үр бүтээлтэй өнгөрөөж, өрхийн орлогоо нэмэгдүүлж байна.
- Эргэн төлөлт нь 50 хувийн хөнгөлөлттэй, хүүгүй байгаа нөхцөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нэг боломж болдог байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа үр өгөөжтэй гэж судалгаанаас харагдаж байна.
- Санхүүгийн дэмжлэг дахин хамрагдах санал хүсэлт их байна.

Дутагдалтай тал:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нь бага. Хэрэгцээтэй тоног төхөөрөмж авч чаддаггүй.
- Шаардлага хангасан ажлын байртай болох боломжгүй зэрэг

1. *Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ:*

Тус арга хэмжээнд Баянхонгор аймгийн хувьд 2019 онд 3 хүнд 10 000 000 /арван сая/ төгрөг, 2021 онд 5 хүнд 25 200 000 /хорин таван сая хоёр зуун мянга/ төгрөг олгосон гэх тоон мэдээ судалгааг гаргаж өгсөн ч яг хэн гэх, ямар ажил олгогчид олгосон гэдэг нэртэй судалгаа байхгүй. Түр орлон хариуцаж байгаа мэргэжилтэн Г.Сайханжаргалд дэлгэрэнгүй бүртгэл, судалгаа гарт нь байхгүй тул гаргаж өгөх боломжгүй гэдэг тайлбарыг өгсөн. /Ажил олгогчийн судалгаа мэдээллийг хавсаргав/

2. *Ажлын байрны түрээсийн дэмжлэг хөтөлбөрт:*

Тус хөтөлбөрт 2019 онд ХБ-43 иргэн, 2020 онд 3 иргэн, 2021 онд 9 иргэн тус тус хамрагдсан тоон мэдээллийг ХХҮГ-аас авсан. Уг арга хэмжээг хариуцсан мэргэжилтэн жирэмсний амралттай байгаа ба одоо түр орлон ажиллаж байгаа мэргэжилтэн Г.Сайханжаргалд дэлгэрэнгүй судалгаа нь байхгүй тул түрээсийн дэмжлэг авсан иргэдийн нэрсийг гаргаж өгөх

боломжгүй гэдэг тайлбарыг өгсөн. 2021 онд ажлын байрны түрэсийн дэмжлэгт хамрагдсан 7 хүний нэрийг гаргаж өгсөн.

3. *Хөдөлмөр эрхлэлтийн сургалт:*

Сургалтын хөтөлбөрт 2020 онд 38 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 2021 онд 40 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамрагдсан хүмүүсээс санамсаргүй түүврийн аргаар авсан асуумж, ярилцлагыг дүгнэлт хийхэд.

Сайн тал нь:

1. Эрх бүхий мэргэшсэн байгууллагаар тусгайлсан хөтөлбөр төлөвлөгөөгөөр мэргэжлийн үр чадвар олгодог.
2. ХБИ-ийг хөгжүүлж, чадваржуулж, хөдөлмөрт бэлтгэдэг
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин төсөл хөтөлбөрт холбодог
4. ХБИ ажил хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг багасгадаг

Сул тал нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бичиг үсгийн чадвар сул болохоор зарим зүйлийг сайн ойлгодоггүй.
5. *Хөдөлмөрийн нээлттэй зах зээлд ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ*

Судлаачийн тайлан-4

Судлаачийн нэр

Д. Одгэрэл ХБХЭЭХолбооны Орхон салбарын
Зохицуулагч

Г. Оюунбилэг – Зөвлөгч ээж

Байршил

Булган аймаг

Булган аймаг нь 16 сум, 1 тосгонтой.

Бид Булган аймгаас 60 км-ын зайтай Хялганат тосгон, 45 км-ын зайтай Хангал сумын иргэдтэй уулзаж, судалгаагаа авлаа.

Судалгаагаар Булган аймаг нь олон сумтай учраас сум бүрийг хөтөлбөрт хамруулахын тулд санхүүжилтийг хасаж олгодог гэдгийг мэргэжилтэн болон төсөл хөтөлбөр хариуцсан дарга нь хэлж байв.

Судалгаа хийгээд явж байхад иргэд төслийн санхүүжилтийг хасаж олгохгүй байх

Улирлын чанартай хийгдэх төслийн санхүүжилт хийх улирал нь дууссан хойно ирдэг гэдгийг онцолж хэлсэн.

Хөдөө орон нутагт төсөл хөтөлбөрийг олгохдоо ажлын байр, иргэнээ сайн судлахгүй өгдөг болох нь харагдаж байв.

Судлаачийн тайлан-5

Судлаачийн нэр

Г. Алтанчимэг, Т. Солонго

Байршил

Дархан-Уул аймаг

Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ-Санхүүгийн дэмжлэг авсан хүмүүсийн сэтгэл ханамж эерэг байсан хэдий ч санхүүгийн дэмжилгийн хэмжээ бага, авахыг хүссэн хэмжээгээр олгогддоггүй. Жишээ нь 5 сая төгрөгийн дэмжлэг хүсэхэд 2.5 сая нь л олддог. Энэ байдлаас харахад өгч байгаа дэмжлэгийг олон хүнд бага хэмжээтэй өгч байгаа нь үр дүнгүй тогтвортой үйл ажиллагаа явуулахад хангалттай дэмжлэг болж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ-Энэ арга хэмжээ нь үнэхээр үр өгөөжтэй дэмжлэг гэдэг харагдаж байлаа. Тухайн байгууллагад ХБИ-ийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бий болгож байна.

Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ-Энэ арга хэмжээ нь ковидийн үед нүдээ олсон арга хэмжээ байлаа. Дэмжлэг авсан хүмүүсийн сэтгэгдэл өндөр төр засаг үнэхээр ХБ-дээ дэмжин ажиллаж байгаад талархаж байгаагаа илэрхийллээ.

Судлаачийн тайлан-6

Судлаачийн нэр

Т.Оюунсүрэн

Г.Ринчин

Байршил

Дорнод аймаг

Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын, Хөдөлмөр хэлтсийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт-шинжилгээ үнэлгээг 2022оны 02сарын 12-18-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Хяналт үнэлгээг Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн хүрээнд 4 чиглэлт үйл ажиллагаанд хийлээ.

- Санхүүгийн дэмжлэгт
2019 оны- 17 иргэн
2020 оны -33 иргэн
2021 оны – 33 иргэн
- Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх
2019 оны – 4
2020 оны – 3
2021 оны – 3
- Ажлын байрны түрээсийн дэмжлэгт
2019 оны – 1
2020 оны – 2
2021 оны - 10
- Аж ахуй эрхлэлтийн сургалт
2019 оны – 4 удаа
2020 оны – 1 удаа
2021 оны – 3 удаа

Санхүүгийн дэмжлэгт орсон 83 иргэнээс түүвэрлэн 21 иргэнтэй хяналт шинжилгээг хийлээ. Одоогоор үйл ажиллагаа тогтмол явагдаж байгаа нь 6 иргэн байна. Үүнээс 6 иргэн ковид19 цар тахал, улирлын, хил хаасантай холбоотой үйл ажиллагаа тогтворгүй байна.

Ажил олгогчийн 10 байгууллагад хяналт, үнэлгээг хийхэд ажлын байрны тогтвортой хадгалж байгаа нь 6 байгууллага байна.

Ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд хамрагдсан иргэнээс ковид-19 цар тахалтай болон улирлын чанартай ажил гэдэг шалтгаанаас болоод 6 иргэн нь үйл ажиллагаа явуулаагүй байна. 6 иргэн ажил жигд явагдаж байна.

- Аж ахуй эрхлэлтийн сургалтыг 3 жилийн хугацаанд 1 л байгууллагад өгсөн байна. Энэ сургалтыг байгууллага, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын байранд сургалт явагддаг.

Судлаачийн тайлан-7

Судлаачийн нэр

-

Байршил

Дундговь аймаг

Мэдээлэл цуглуулах тэмдэглэл баримт хөтлөх үнэлгээ өгөх судалгааг газар дээр нь шалгаж үзлээ.

Ярилцлага авах хүмүүс хоорондын адил тэгш харилцааг эрхэмлэн бие биенээ сонсох, хүндлэх, зөвшөөрсөн нээлттэй хэлбэрээр судалгаагаа авсан болно.

- ХБИ –ийн ажлын байрын хангалт маш муу байна.
- ХБИ –ийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ ур чадвар олгох сургалтын хугацаа хоног цөөхөн байна.
- Зарим тохиолдолд 3-5 хоног заагаад л чадамжийн гэрчилгээ олгодог гэнэ.

- 2020 онд түрээсийн хөнгөлөлтөд хамрагдсан мөртлөө мөн 2020 ондоо багтаад иргэний санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд дахин давтан хамрагдсан байх юм .
- Нэг авсан иргэн л 2- 3 жил болоод л авдгаас хүнээ шинэчилдэггүй юм байна.
- Төсөл хөтөлбөрт хамрагддаг хүмүүс нь ах дүү төрөл садангууд ихэнх хувь нь байна.
- Төсөл хөтөлбөрийг шалгаруулж зөвшөөрөл өгдөг сумын амьжиргаа дэмжих багийн зөвлөлийн гишүүд олон жилээр ажиллаж байгааг анхаарч бүрэлдэхүүнийг шинэчилж баймаар байна.

Судлаачийн тайлан-8

Судлаачийн нэр Байршил

С.Дэлгэрбаяр
Завхан аймаг

Завхан аймгийн хөдөлмөр халамжийн газрын хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэн Дашдондогийн Мөнхбаттай ХБИргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаар ярилцлаа.

Сайшаалтай зүйл:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар байгуулагдаж төрөөс жилээс жилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд түлхүү хүрч анхаарч ажиллаж байна. Энэхүү хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр өмнө нь зөвхөн ХБИ-дэд хүрдэг байсан бол одоо ХБХ-дээ асарч байгаа эцэг эх болон ХБИ асарч байгаа иргэн хүртэл хамрагдах боломжтой болж байгаа нь их сайшаалтай байна. ХБИргэд маань өөрсдөө л хийж бүтээе гэвэл төрөөс харьцангуй сайн дэмждэг болсон ба нийгэмд эрх тэгш үйл ажиллагаа явуулаад, ажил амьдралаа дээшлүүлэх боломжтой байгаад баяртай байна.

Бэрхшээлтэй зүйл:

- Манай аймгийн хувьд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтарч ажиллахгүй, энд тэнд бүгд л тус тусдаа үйл ажиллагаа явуулж байна. Жилийн эцэс тайлан тооцоо болохоор л хэдэн холбоо, төрийн бус байгууллагууд болон дарга нар орж ирдэг. Мэдээ мэдээллээр маш муу байдаг. Бодлого барьж байгаа хүмүүс, засаг дарга, ХБХХЕГ гэх мэт газруудаас яг ямар хөтөлбөр, үйл ажиллагаа явуулж байна гээд судлаад мэдээд бүгд хоорондоо уялдаа холбоотой л ажиллах хэрэгтэй байна.
- Хувь хүний талаас өөрсдийн хандлага, хичээл зүтгэл муу санагдаж байна. Мэдээ мэдээллээр хангаад, сургалт зөвлөгөө зохион байгуулаад ажилд зуучлаад өгье гэхээр өөрсдөө ирэхгүй, ажлын ачаалал даахгүй, 5-6 хүн нэгдэж нийлээд боломжтой зүйлсээ хийгээчээ багийн байр бэлэн байна төсөв санхүүжилтээр дэмжье гэхээр ихэнхдээ хувь хувьдаа, би гэсэн үзлээр л ханддаг байдал ажиглагдсан.
- Гарц гаргалгааны хувьд гэвэл манай аймгийн хувьд хамгийн түрүүнд уялдаа холбоо, бүгдийн хамтын ажиллагаа, бид гэдэг зүйл л хэрэгтэй санагдаж байна.

Сонголтын хувьд бид хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн гаргасан журмыг баримтална.

- Сум болгонд байгаа мэргэжилтнүүдэд мэдээллээ өгөхөөс гадна фэйсбүүк онлайн орчинд буюу аймгийн хэмжээнд бүрэн мэдээллээр хангаж 21 хоногийн хугацаанд материалуудаа хүлээн авсан.
- Ажлын хэсэг гаргаад өргөдөл, хэрэгжих боломжтой шаардлага хангах эсэхийг нягтлах, биечлэн очиж үзэх

- Тэнцсэн төслүүдийг хамгаалах
- Гэрээ байгуулж, санхүүгийн дэмжлэгийг зөвхөн иргэдийн нэрийн дансанд шилжүүлэх
- Эцэст нь хяналтын буюу явцын хяналтыг хийх зэргээр хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
- Санхүүжилтийн хувьд дээрээс төсөвлөгдсөн хөрөнгө санхүүг аль болох хүргэхийг зорьдог. Харьцангуй санхүүжилт жил бүр өсч байгаа. Бид ч бас саналаа өгдөг. Үр дүнтэй байлгахыг л зорьж ажилладаг.

Судлаачийн тайлан-9

Судлаачийн нэр

Д. Одгэрэл ХБХЭЭХолбооны Орхон
салбарын Зохицуулагч

Байршил

Г.Оюунбилэг – Зөвлөгч ээж
Орхон аймаг

Төрийн байгууллагын үйл ажиллагаа нь нээлттэй бус, нууцын зэрэгтэй бичиг баримт өгөх гэж байгаа мэтээр бидэнтэй хандсан. Орхон аймгийн ХХҮГ, ХБХХЕГ-уудаас ирүүлсэн судалгаа хангалттай бус байсан. Зарим байгууллагын утас, хаяг тодорхой бус, дугаар андуурсан гэх мэт асуудлууд гарсан.

Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалт явуулж байгаа боловч эргээд иргэндээ хир хүртээмжтэй байгаа байдлыг олж харахгүй зээлийн эргэн төлөлтөд нь хэт их анхаарч байна.

Хөтөлбөрт богино хугацаанд хамруулах шаардлагатай байна. Жишээ нь, сарын 70 мянган төгрөгийн эргэн төлөлттэй иргэн 3 жил зээлээ төлөөд дараа нь хамрагдах эсэх нь шийдэгдэнэ гэдэг нь маш буруу заалт гэж үзсэн.

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллага болон иргэд ААН-үүдтэй холбоо уялдаатай байх, бүртгэл шинэчлэх ажлуудыг тогтмол хийх шаардлагатай. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл нь санхүүжилт нь 50 хувийн эргэн төлөлттэй байдаг. Харин ХБХ-ээ асарч буй эцэг эхэд төсөлийн санхүүжилт нь 100 хувь эргэн төлөлттэй байгаа нь ялгавартай хандаж байгаа жишээ юм.

ХБИ-ийн хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа нь сайшаалтай боловч төсөлд бичсэн санхүүжилтийг олгодоггүй, хасч олгодог нь дэмжлэг болж чадахгүй, хүссэн хэмжээндээ хүрч ажиллах боломжгүй, 3-4 жилд ахиад хөтөлбөрт хамрагдаж чадахгүй дэмий зээлийн эргэн төлөлттэй байгаа нь түгээмэл харагдсан.

Судлаачийн тайлан-10

Судлаачийн нэр

М. Алтанцэцэг, Э. Дэлгэрмаа

Байршил

Сүхбаатар аймаг

ХБХХЕГ, МСХ, ХБХЭЭХ хамтарсан гэрээний дагуу ХБХЭЭХ-г төлөөлж Сүхбаатар аймгийн салбар зөвлөлийн зохицуулагч М.Алтанцэцэг миний бие тэргүүлэгч Э.Дэлгэрмаагийн хамт Аймгийн ХХҮГ-ийн дэмжлэгтэйгээр Шалгуур 2,3,4,-ийн хүрээнд Баруун-Урт сумын 11 иргэн, ААН-д хяналт шинжилгээ үнэлгээ хийлээ. Мониторинг хийхэд арга зүйн удирдлагаар ХБХЭЭХ-ны тэргүүн Сэлэнгэ, ажилтан М.Пүрэвсүрэн, Мөнгөнчимэг нар хангаж байлаа. Аймгийн ХХҮГ-ын дарга Д.Гэрэлбадрахтай анхны уулзалт хийж хамтран ажиллах талаар зөвлөлдлөө.

2 дахь уулзалтыг 2-р сарын 7-нд хийж Сэлэнгээ захиралтай утсаар холбогдон үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч үйл ажиллагаагаа эхлэхээр боллоо. Гэрэлбадрах дарга ажил үүргийн дагуу мэргэжилтэн С.Балжиннямд шаардлагатай мэдээллээр хангах үүрэг өгч ажиллаа. Шаардлагатай мэдээллийг 2-р сарын 16-нд гарган өгч 19-нөөс хяналт шинжилгээний ажилд орж иргэдтэйгээ нэг бүрчлэн уулзаж тэмдэглэл хөтлөн аль болох тэдний санал бодлыг сонсоход анхаарлаа хандууллаа.

Аймгийн ХХҮГ-ын зүгээс ямар нэгэн чирэгдэл учруулаагүй ба хүссэн дэмжлэгийг тухай бүрт өгч, хүний нэр төр эрхийн асуудалтай холбоотой учир итгэлцүүрт үндэслэн мэдээллээр хангаж байгаагаа сануулж байв. Дэмжлэг авсан хүмүүсийн саналаас үүдэн доорх дүгнэлтийг хийлээ. Үүнд:

1. Сүүлийн 3 жилд үзүүлсэн дэмжлэгүүд нь очвол зохих эздэдээ хүрсэн байна.
2. ХБИ-дэд үзүүлсэн санхүүгийн болоод түрээсийн хөнгөлөлтийн дэмжлэгүүд нь тэдний амьдрал ахуйд нь эерэгээр нөлөөлж ялангуяа цар тахлын үед амьдрал ахуйд нь хэрэг болсныг дурдаж байв.
3. Тухайн дэмжлэгийг үр дүнтэй ашигласан хүн олонх нь байсан бөгөөд 1 хүн үр шимийг нь хүртэж чадаагүй төдийгүй эргэн төлөлтөө ч хийгээгүй шүүхэд шилжсэн байна.
4. Олонхийн гаргаж буй саналаас үзвэл ХБИ-ийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгдсэн төвтэй байхыг илүүд үзэж байна. Үүний давуу тал нь:
 - Тусгай хэрэгцээ хангагдах нөхцөл бүрдэнэ.
 - Тодорхой хамт олон бүрдэж нийгэмшихүйд нь эерэг нөлөө үзүүлнэ. - Борлуулалтад сайн нөлөө үзүүлж нэг цэгийн үйлчилгээнд төвлөрч хэрэглэгчдэд ойртоно.
 - Хамтран ажилладаг байгууллагын хамтын ажиллагаа, хяналт сайжирна... г м
5. Санхүүгийн дэмжлэгээс гадна мэргэжил олгох, болон нийгмийн харилцаанд хэрхэн оролцох талын сургалт хийх, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг орон нутагтаа болон улсын хэмжээнд цаашилбал олон улсын хэмжээнд зохион байгуулах хэрэгтэй байна.

Судлаачийн тайлан-11

Судлаачийн нэр

Ш.Ганзул- ХБХЭЭХ Сэлэнгэ дахь салбарын зохицуулагч,

Байршил

Г.Баясгалан- ХБИНХны Тэргүүлэгч
Сэлэнгэ аймаг

Орон нутагт дэмжлэг авах иргэний тоог нэмэгдүүлэхийн тулд төслийн квотыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. ХБИ-ээс маш олон төсөл ирдэг. Гэтэл квот цөөн тоотой байдаг учир хүртээмжтэй биш байдаг нь харагдаж байна.

ХБХ-дээ асран халамжилж байгаа эцэг эхийг дэмжих хөтөлбөрт хамрагдах тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. ХБИ-ний ажиллах орчинг бүрдүүлсэн тохируулгатай аж ахуй нэгжийг шагнах урамшуулах, торгуулиас чөлөөлөх арга хэмжээг авдаг байх хэрэгтэй.

Хөдөө орон нутгийн сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин хөнгөлөлттэй зээл авах боломжийг бүрдүүлж өгөх нь зүйтэй. ХБИ-г ажиллуулаагүй тохиолдолд төлдөг нөхөн төлбөрийн төсвийг төрийн байгууллагын төсөвт суулгаж өгөх шаардлагатай байна.

Судлаачийн тайлан-12

Судлаачийн нэр

Э.Баярмаа

Байршил

Төв аймаг

Хөдөлмөр эрхэлж буй ХБИ-нд зээлийн хэмжээ бага байна. Ажлын байраа нэмэгдүүлэх, хийж ажил, бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг олшруулах зэрэгт хүрэлцээ муу байна. Зээлийн хэмжээг нэмэгдүүлэх нь маш зүйтэй.

Харин ажил хийгээгүй хүмүүсийн хувьд хүнд үзүүлэх юм байхгүй байна. Сайн судалгаа хийж зээлээ олговол хөгжлийн бэрхшээлтэй ч ажил хийх хүсэл эрмэлзэлтэй хүмүүс нь үлдэхгүй давуу талтай. Энэ судалгаа хийхийг зөвшөөрсөн холбоондоо баярлалаа. Бас нэг шинэ зүйлийн талаар тодорхой мэдлэгтэй боллоо. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн талаар маш их зүйл, хууль тогтоомж мэдэж авлаа. Баярлалаа.

Судлаачийн тайлан-13

Судлаачийн нэр
Байршил

С.Нарантунгалаг
Увс аймаг

2022 оны 01 дүгээр сарын 28-нд ХХҮХ-ийн дарга Цогт-Очирт (99012335) өөрийн биеэр албан бичгээ хүргэж хүргэж, ярилцлага хийсэн. Мөн тэр өдөртөө ярилцлага хийх явцад ХБХЭЭХ-оос явуулсан албан бичиг шаардлага хангахгүй, учир мэдээлэл өгөхгүй гэсэн учир ХБХЕГ-аас 02 сарын 14-нд хоёрдахь удаагаа албан бичиг, ХХҮХ-т хүргүүлсэн. ХБИ хариуцсан мэргэжилтэн Мөнхсоёлд (99458496) албан бичгийн хариу өгөх заавар өгсөн боловч албан бичгийн хариугаа авч чадахгүй ХХҮХГ-т 9 удаа очиж, санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ (2) дээр 97 хүний мэдээлэл авсан.

Мэдээлэл дутуу ирж, нэр, утасны дугаар дутуу, санхүүжилт мөнгөн дүн дутуу, дан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн мэдээлэл байсан. ХБИ хариуцсан мэргэжилтэн Мөнхсоёл хөдөлмөр эрхлэлт хариуцсан Ганзориг (99667040) мэргэжилтэнгээс үлдсэн мэдээ мэдээллээ авахаар төлөвлөсөн боловч 02.14-03.21 хүртэл охиноос 3 удаа өөрийн биеэр уулзаад бүрэн хариугаа авч чадаагүй. Эцсийн байдлаар буюу 03.21-нд ХХҮХ-т очсон боловч тодорхой мэдээлэл өгөөгүй юм. Мөн "2019, 2021 онд 7 хүн сургалтанд суусан шүү, та өөрөө олоод мэдчих, би хариулт өгч чадахгүй" гэсэн хариу өгсөн.

50 хувийн эргэн төлөлттэй санхүүжилт авсан нийт 97 иргэдээс сонгон 14 иргэнтэй нь уулзаж ярилцсан. Судалгаанд хамрагдсан 14 иргэн нийгмийн даатгал төлдөггүй, 3 хүн нь эргэн төлөх үгүйгээ мэдэхгүй, ямар санхүүжилт авснаа мэдэхгүй, бас санхүүжилтээ зориулалтаар нь ашиглаагүй байсан.

"НДШ яагаад төлдөггүй вэ?" гэсэн асуултанд олонх нь групп болон тэтгэврийн мөнгөн дүнгийн хувьд адилхан тогтоогддог учир, төлөх шаардлагагүй гэж хариулсан. Мөн 5 иргэн авсан санхүүжилтээрээ тоног төхөөрөмжөө авч үйл ажиллагаагаа хэвийн явуулж байсан. Зарим иргэд зураг авахуулахыг зөвшөөрөөгүй. Зарим нь улирлын чанартай. Жишээ нь: Хадлан, газар тариалан эрхлэгчид зураг авахуулах боломжгүй зураг авах газар 30-аад км орчимд байсан.

Судлаачийн тайлан-14

Судлаачийн нэр
Байршил

А. Баярмаа, П. Алтанчимэг
Ховд аймаг

ХБХХЕГ болон Мэргэжлийн социологичдын холбооноос явуулж байгаа "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үнэлгээ"-нд оролцож 2019, 2020, 2021 оны хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийлээ.

2022 оны 2-р сарын 07-ноос 28-ны хооронд хийгдсэн уг судалгаанд Ховд аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон уг газартай хамтран ажиллаж хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулдаг төрийн өмчит Хөгжил Политехник коллеж, хувийн хэвшлийн байгууллагууд болон иргэд хамрагдан оролцлоо.

Үүнээс; Ховд аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар-1, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ-8, Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ-9, Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд оролцсон- 4 гээд нийт 22 оролцогчоос судалгаа авлаа.

2019 оны хувьд цар тахлын улмаас энэхүү хөтөлбөрийн зарим зорилт биелээгүй хойшлогдсон байдаг юм байна. Тухайлбал хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалтууд явагдаагүй бол 2021 онд ХХҮГ-т хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх цогц арга хэмжээний санхүүжилт ирсэн ч уг арга хэмжээний хэрэгжилт ойлгомжгүй байсан учраас санхүүжилтийг буцаан татуулсан байна.

Нийт судалгаанд оролцсон байгууллагын хүмүүс болон иргэдийн санал хүсэлт, сэтгэгдлийг судалгааны маягтын дор нэмэлтээр оруулсан.

Судлаач бидний хувьд энэхүү хөтөлбөрийн хэрэгжилт зорилтот байгууллага, хүнээ олж хэрэгжиж байгаа ч мөнгө санхүүгийн хувьд хангалттай хэмжээгээр олгогдохгүй байна гэж дүгнэлээ. Өдрөөс өдөрт өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэж хэрэгцээтэй тоног төхөөрөмж авах, түрээсийн төлбөр төлөх, бусад урсгал зардал гээд олон олон зарлага гарч байдаг нь ашиг олох гэж байгаа иргэдэд хүндээр тусч дэмжлэг хүссэн мөнгө нь ч хангалттай хүрэлцэхгүй амь зогоох төдий байгаад байгааг нэгэн дуугаар хэлж байлаа.

Хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалтанд сууж төгссөн иргэдийн хувьд төгсөөд баталгаатай ажлын байраар хангагдах, хувиараа ажиллах шийдвэр гаргасан тохиолдолд үргэлжлүүлэн урт хугацааны хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулах хэрэгцээтэй байна гэж үзэж байна.

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн цөөн тооны хувь нь сэтгэл хангалуун байсан бол ихэнх нь зээлийн хэмжээ нь буурч олгогдсон гэдгийг онцолсон. Цаашид хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийнхээ дуу хоолой, санал хүсэлтийг нь сонсон харилцан ойлголцож илүү үр дүнтэй хамтран ажиллах нь зүйтэй байна гэж үзэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй маш олон иргэд ажлын байргүй байгааг харгалзан бүх хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар тэгш хангах боломж нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Цаашид хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан албан байгууллага, хувийн хэвшил, иргэдийн ажлын байрны онцлог нөхцөл байдалд бодитой дүн шинжилгээ, тооцоо судалгаа хийж бизнест нь хангалттай хэмжээгээр зээлийг олгох зайлшгүй шаардлага тулгарч байна.

Судлаачийн тайлан-15

Судлаачийн нэр Байршил

Ч.Лхагвасүрэн, Г.Хажидмаа
Хөвсгөл аймаг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2019-2021 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх мэдээллийг 2022 оны 1 сарын 27-оос 02 сарын 17 өдөр хүртэлх хугацаанд удирдамжийн дагуу дараах төлөвлөлтөөр хийж гүйцэтгэлээ.

Цаг үеийн байдлаас шалтгаалж Эгэл билэг ХХК, Улаангозгор ХХК-ны талаарх мэдээлэл тодорхойгүй байсан тул АЗДТГ-ын статистикийн хэлтэс дээр очиж хайлган байршил, утас, ААН-н дарга нарын талаарх мэдээллийг авсан болно. Судалгааны гарын авлага зөвлөмжийн дагуу аймгийн ХХҮГ-аас авсан мэдээлэл дээр тулгуурлан Эгэл билэг ХХК, /2019 он /, Эрхэм үндэс ХХК, Улаангозгор ХХК, Мөнхцаглашгүй ХХК, /2020 он /, Эх зөгийн аз ХХК, Гандан нуурийн хөвөө ХХК, Төгөлдөр орчлон ХХК /2021 он/ зэрэг аж ахуй нэгж байгууллагаас 2 нь аймгийн төв Мөрөн суманд, 2 нь Түнэл, Жаргалант суманд 3 нь УБ хотод байршилтай болохыг олж тогтоосон. Аймгийн төвд байдаг 2 аж ахуйн нэгжтэй биечлэн очиж танилцав. Бусад 5 аж ахуй нэгтэй утсаар холбоо тогтоож мэдээлэл авлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд 2019 онд 20, 2020 онд 32, 2021 онд 29 нийт 81 иргэний мэдээлэл авлаа. Эдгээр иргэдээс санамсаргүй түүврээр 10 иргэнийг сонгон авч очиж, танилцан ярилцлага хийв. Бусад иргэдтэй утсаар танилцаж мэдээлэл солилцсон болно. 2021 онд Цар тахлын үед ажлын байрыг хадгалах хүрээнд түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан 15 иргэн байсан. Уг иргэдтэй нэг бүрчлэн утсаар ярьж 6 иргэнтэй ажлын байран дээр нь очиж уулзлаа.

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны үед байсан ололттой тал нь:

- ХХҮГ нь ямар ч бэрхшээл учруулалгүй мэдээллийг өгч биднийг ажлаа явуулах боломжоор хангасан.

- Ихэнх иргэд 3-4 сая төгрөгт багтсан санхүүгийн дэмжлэг авч өрхийн үйлдвэрлэл эрхэлж орлоготой болсон байсан.
- Иргэд, ААНБ- тай уулзах үед харилцааны элдэв зөрчил гаргалгүй, бие биенээ хүндэтгэсэн харилцаагаар мэдээллээ цуглуулж чадсан.
- Байршил нь болон утас, ажил олгогч нь тодорхойгүй хоёр ААНБ-г аймгийн статистикийн хэлтэс олж өгч дэмжлэг үзүүлсэн.
- Түрээслэгчдийн 80 хувь нь ажлын байраа хадгалж ажил үйлчилгээг явуулж байгаа.
- Түүврээр сонгогдсон иргэд санхүүгийн дэмжлэгийг ихэнх нь үр өгөөжтэй ашиглажээ.

Мэдээлэл цуглуулах явцад гарсан анхаарах асуудал :

- ХХҮГ-ын гаргаж өгсөн мэдээлэл дотор ААНБ, иргэдийн хаяг утас нэр нь дутуу байсан.
- Түрээсийн төлбөрийн дэмжлэг авсан иргэдээс 3 хүн буюу 20 хувь нь ажлын байраа хадгалж чадаагүй байна.

Иргэн Ч. Б нь “Сайхан” салонд үс угаадаг гэсэн боловч очиж үзэхэд тийм хүн байхгүй гэсэн тайлбарыг өгсөн. Тэрээр санхүүгийн дэмжлэгт 2020 онд хамрагдсан Б овогтой Э РХ61120912 регистртэй Мөрөн сумын 12-15-19 д оршин суудаг мөртлөө Алаг-Эрдэнэ сум 5-р баг гэж хаяг дээр дэмжлэг авсан. Мэдрэлийн гаралтай өвчнөөр группд байдаг иргэн. Энэ хүнтэй ярихад “би мэдэхгүй, эмгэнээс асуу” гэсэн. Эхнэртэй нь ярихад “манай бэр авсан” гэж хэлсэн. Энэ кейсээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр дээр төрийн албан хаагчид хөтөлбөрийн дэмжлэгээс хүртдэг байж болзошгүй гэсэн эргэлзээнд хүргэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд хамрагдахгүй байгаа нь тэдэнд хөтөлбөр төслийн талаар мэдээллийг ил тод танилцуулдаггүйтэй холбоотой байгаа нь уулзалтад оролцсон иргэдийн ярилцлагаас харагдаж байсан.

Санхүүгийн дэмжлэгийг зорилго, хэрэгцээг харгалзахгүй олон хүнд хүртээж өгснөөс болж амьжиргааны болон өрхийн үйлдвэрлэлийг цааш нь үргэлжлүүлэх боломжгүйд хүргэж байна. Цар тахалтай холбоотойгоор бараа материалын үнэ өссөн, хүмүүсийн худалдан авах чадвар буурсан, санхүүгийн дэмжлэгийн хэмжээ хэт бага зэрэг шалтгаанаас хамаарч хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтэд эерэг ахиц өөрчлөлт гарахгүй байгаа нь мэдээлэл цуглуулах ажлын явцад харагдлаа.

Судлаачийн тайлан-16

Судлаачийн нэр

Т.Оюунсүрэн, Г.Ринчин

Байршил

Хэнтий аймаг

Хэнтий аймагт 2022оны 02 сарын 21-22 ны өдрүүдэд ажиллаж хяналт үнэлгээг хийлээ. Хяналт үнэлгээг хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд 2 чиглэлийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийлээ. Бусад 3-н чиглэлд шаардлага хангаагүй учраас дэмжлэг олгогдоогүй байна.

Санхүүгийн дэмжлэг:

- 2019 онд 13 иргэнд дэмжлэг олгосноос аймгийн төвд 4
 - 2020 онд 22 иргэнд дэмжлэг олгосноос аймгийн төвд 4
 - 2021 онд 20 иргэнд дэмжлэг олгосноос аймгийн төвд 7 иргэнд тус тус дэмжлэг үзүүлсэн байна.
1. Ажил олгогчийн урамшууллыг
2019 онд 2 аж ахуй нэгж байгууллага
2020 онд 13 аж ахуй нэгж байгууллага
2021 онд олгогдоогүй байна.

Санхүүгийн дэмжлэгт нийт 45 хүн хамрагдсанаас 34 нь сумдад үйл ажиллагаа явуулж байгаа юм байна. Ажил олгогчийн урамшууллыг 15 иргэнд олгосноос 5 иргэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байсан. Бусад нь 6 сар бүртгэгдсэн, хорих ангийн суллагдсан иргэн зорилтот бүлгийн иргэнд олгосон байна.

Аймгийн төвд санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Судлаачийн тайлан-17

Судлаачийн нэр

-

Байршил

Баянгол дүүрэг

Үнэлгээ хийхэд бэрхшээлтэй асуудлууд олон байсан. Судалгаа авахад “хувь хүний регистрийн дугаар асуулаа, авлаа” гэж дургүйцэж байсан. Утас нь холбогдохгүй, эрх нь хаагдсан, утас буруу олон байгууллагууд байсан.

Ажлын байртай гээд хэлээд байгаа мөртлөө гэрээрээ ажиллаж байгаагаа цар тахалтай холбоотойгоор тайлбарлаж байсан.

ХБИ 1-2 хүн ажиллуулдаг, үр бүтээл маш муу байдаг их ядардаг, сульддаг, дархлаа муу, ковидоор амархан өвчилж байсан гэж ярьсан. Олгосон санхүүжилтээрээ ТББ, ААН, иргэнд бараа материал, тоног төхөөрөмж, ажлын байрны түрээсэнд зарцуулсан гэх мэтээр бичиг цаасаа, материал, тоног төхөөрөмжөө үзүүлсэн.

“УРАН ҮЙЛС” ТББ 2021 оны 12 сарын сүүлчээр сургалтын эрхээ авсан байна. Цаашдаа цогцоор ажиллах сонирхолтой. Захиралтай нь биеэрээ очиж уулзаж танилцсан.

2 ААН санхүүжилт аваагүй байхад маш олон утасдаж, төрөл бүрийн юм асуудаг. Бидний бичсэн төсөл дээр авсан байна гэж бухимдаж байсан. ХБИ Батхишиг сонсголын 100 хувийн алдагдалтай, байнгын орчуулагч асран хамгаалагчтай байдаг дүү Мөнхчимэг тусалдаг. Цар тахлын үеэр түрээс, ажилчдын НДШ, цалингаа тавьж чадахгүйн улмаас бүх төлбөр, тооцоо тооллого, тайлангаа хийж өгөөд дууссан байна. ТББ эргэн төлөлт хийдэггүй. ААН эргэн төлөлт хийдэг, хувь хүмүүс төлөвлөсөн САНХҮҮЖИЛТЭЭ авч чаддаггүй гэсэн шүүмжлэлүүд их байна.

Судлаачийн тайлан-18

Судлаачийн нэр

-

Байршил

Баянзүрх дүүрэг

Нээлттэй зах зээлд ажилд оруулахад хүндрэлтэй байгаа болохоор өөрийн байгууллагадаа ажилд авсан гэж байлаа. Дадлагажиж сурч байгаа хугацаанд НДШ яагаад төлөх гэж. Бэлэн болоод зах зээлд гарсны дараа НДШ төлнө гэж ойлгож байна.

Ажлын байраа сарын 1.500.000₮ түрээсэлдэг. Түрээсийн мөнгө гээд 1.500.000₮ орж ирэхээр нэг сарынх гэж ойлгосон. Түрээсийн дэмжлэгийн тусламж их бага санагдсан.

Ажилд авсан ХБИ бариа заслын үйл ажиллагаа явуулж, харааны бэрхшээлтэй 2 хүнийг ажлын байраар хангаж байсан. Тэрээр ХБИ-нд болон хөдөлмөр эрхлэлтэд үүсч байгаа бэрхшээлийг яриу.

Манайх төсөл батлагдаад 06 сард гэрээ хийж санхүүжилт 10 сард орж ирсэн гэтэл ажлаа гэрээ хийнгүүт эхлээд НДШ болон түрээсээ төлөөд яваад байсан. Энэ нь жаахан хүндрэл үүсгэж байсан. Зах зээлээ бодоод хотын төвд байр түрээслэхээр түрээс арай өндөр гэтэл түрээсийн дэмжлэг 250,000₮ өөр бодогддог. Манай одоо байгаа энэ байр сарын 1,500,000₮. Массаж энгийн байр түрээслэх боломжгүй. Бид хамгийн их бусдад өгдөг зүйл бол түрээс байдаг. Манайх одоо өгч байгаа түрээсээ бодохоор жилд 18 сая төгрөг өгдөг. Энэ мөнгөө байр авахад хийж байсан бол аль хэдийн өөрийн гэсэн ажлын байртай болчихсон байна шүү дээ.

Бизнесийн ипотекийн хуультай болмоор санагддаг. ЖДҮ 5жилд 1,6 хувийн хүүтэй зээл өгдөг. Гэхдээ бид хөдөлмөрийн хуулиар хорогдуулсан цагаар ажилладаг. Тэгэхээр 5 жилийн ажиллах хугацаагаа ч мөн бодолцон урт баймаар 8 жил ч юм уу баймаар. ХБИ НДШ төлөх нь цалингийн зээл лист авахад л хэрэгтэй ЭМД төрөөс төлчихдөг. Ажил эрхэлж байгаагүй халамжийн тэтгэмж 188,000₮ авдаг хүмүүст бол хэрэгтэй л дээ. Харин 400,000₮ групп авдаг бидний хувьд нэг их нэмэр байхгүй.

Тэтгэвэрт гарахад харин ч бүр их хэцүү болдог. Одоо бид ажиллаад явахад цалин дээрээ группээ нэмээд авдаг. Энэ группыг улсаас эрүүл мэнд болон бусад нэмэлт шаардлагатай хэрэглэгдэхүүндээ /памперс, эм .../хэрэглэ гэж өгдөг гэж би боддог. Цалин групп хоёроо авч байхад өөрийн болоод өрхийн хэрэгцээгээ хангаад байна гэтэл тэтгэвэрт гарахад энэ мөнгө хасагдана шүү дээ. Тэгэхээр энэ байдлыг минь харж үзээд НДШ төлж байсан хүмүүст тэтгэвэрт гарахад нь НДС-аас жаахан нэмэгдэл өгдөг бол хүн болгон л НДШ төлнө.

Судлаачийн тайлан-19

Судлаачийн нэр

-

Байршил

Багануур дүүрэг

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээг хийх явцад ХХҮХ-ийн судалгаа, мэдээлэл хангалтгүй, шаардлага хангахгүй байна. Асуулга ярилцлагын үед мэдээллээ бүрэн зөв өгч чадаагүй. Шалтгаан нь хариуцсан мэргэжилтэн нь солигдсноос болсон. Шинэ хүн нь өнгөрсөн онуудын үйл ажиллагааг сайн мэдэхгүй гэж тайлбарлаж байгаа нь хөтөлбөр, төсөл дээр ажиллах чадвартай болсон мэргэжилтнээ солихгүй байхад анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Төсөл хөтөлбөрүүд бүрэн хэрэгждэггүй. ХБИ-нд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжээгүй. Бусад хөтөлбөрүүд болох ХБИ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ \цогц арга хэмжээ\, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах гэсэн хөтөлбөрүүд хангалттай хэрэгжээгүй байгаа нь хоорондын уялдаа холбоог бий болгон ажилд зуучлан оруулахыг зорилго болгоогүй, зөвлөгөө, мэдээлэл өгдөггүйтэй холбоотой байна.

Цар тахлын үед ажлын байрыг хадгалах хүрээнд ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ 3 жилийн дотор ганц иргэнд олгогдсон нь ХБИ бүрэн чадваржиж ажлын байртай болдоггүй зөвхөн өрхийн хэмжээнд үйл ажиллагаа нь явагддаг гэдэг нь харагдаж байна.

Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хүрээнд сургалт зохион байгуулж олон иргэд хамрагдсан гэсэн ч ажлын байранд зуучлагдаагүй байдал нь дүүрэгт тохиргоотой ажлын байр бий болгох сонирхолтой төрийн байгууллага, ААН-үүд байхгүй байна.

Уг хөтөлбөрүүдийг хоорондоо холбоотой нэгнээр нь дэмжиж уялдуулан хийвэл үр дүнтэй болох байсан. Хөтөлбөрийн арга хэмжээнүүдийн зорилго үр дүнг хянаагүй.

Хөтөлбөрт хамрагдсан иргэд нь зээлийнхээ нэрийг мэдэхгүй, мэдээлэл тааруу. Мөн зориултаар ашиглаж чадаагүй байдал харагдаж байна. Санхүүгийн дэмжлэг авсан ХБИ-ийг жижиг бизнес болон өрхийн санхүүгийн сургалтанд хамруулж байх хэрэгтэй гэдэг нь уулзалт ярилцлагын үед ажиглагдсан.

Мөн ижил төстэй аж ахуйн болон өрхийн бизнес эрхлэгчдийг хооронд нь холбон нөхөрлөл үүсгэх гэх мэт бие биенээ дэмжин хамтран бизнесээ өргөжүүлэн ажиллах боломжийг судлан хэрэгжүүлэх боломжуудыг судлах хэрэгтэй.

Судлаачийн тайлан-20

Судлаачийн нэр

С.Сэлэнгэ

Байршил

Сүхбаатар дүүрэг

СБД-т 2022 оны 2 сарын 10-аас эхлэн судалгааг хийж, 3 сарын 2-ны өдөр дуусгасан. 1 сарын 24-нд СБД-ийн ХХҮХ-т албан бичгээ өгч. Шаардлагатай мэдээллийг цаасан хэлбэрээр шууд авсан бөгөөд ярилцлагыг ХХҮХ дарга М.Отгонтуяа болон Мэргэжилтэн Мөнхбат нараас авсан. ХХҮХ-ээс мэдээлэл авахад хүндрэл бэрхшээл тулгараагүй. Харин дээрээс шалгалтаар ирж шалгадгаас ингэж санаа бодол асууж, ажлаа сайжруулахын тулд юу хийх вэ гэж биднээс асуудаг үнэлгээнд хамрагдаж байсангүй гэж байсан.

Харин ХБХХЕГ-аас Цогц дэмжлэгийн болон Сургалтын байгууллагуудын мэдээлэл дүүрэг, аймгаар нь бүрэн авч чадаагүйтэй холбоотой ХБХЭЭХ-ны ажилтан дахин бүх утас руу нь ярьж оройтож авсантай холбоотой Цогц дэмжлэг авсан байгууллагуудтай уулзалтаа хамгийн сүүлд хийсэн.

Нийтдээ 21 биечилсэн уулзалтыг хийсэн бөгөөд Шалгуур үзүүлэлт 1-4 дэмжлэг авсан ААН, ТББ болон хувь хүмүүс хамрагдсан.

СБД дээрх уулзалтыг ХБХЭЭХ-ны ажилтан С.Сэлэнгэ, М.Пүрэвсүрэн нар хийж гүйцэтгэсэн.

Цогц дэмжлэгийн хувьд шинээр ХБХХЕГ-аас зохион байгуулж байгаа арга хэмжээ бөгөөд ХБХүндээ Ажлын дадлагажуулагчийн заавар дэмжлэгтэйгээр /Job coach/ хөдөлмөр эрхлэх боломжийг олгож байгаагаараа ХБИ-дэд маш хэрэгтэй. Оюуны бэрхшээлтэй болон сэтгэцийн өвчтэй хүмүүст хамгийн чухал ач холбогдолтой арга хэмжээ юм. СБД-т 4 цогц дэмжлэг авсан ТББ-тай уулзалт хийсэн.

Санхүүгийн мөнгөн дэмжлэгийг 2-р шалгуур үзүүлэлтийн хүрээнд үзүүлж байгаа бөгөөд 1-р хэсгийг Дүүргийн ХХҮХ-ээс нь хувь хүмүүст тодорхой шалгуурын дагуу шалгаруулж өгдөг. Жилдээ 20 хувь хүнд өгдөг бөгөөд 3 жилийн хугацаанд 60 гаруй хүмүүст энэхүү дэмжлэгийг үзүүлсэн бөгөөд 8 иргэний хувиараа хөдөлмөр эрхэлж байгаатай очиж танилцсан. Үүнд Өөрөө хөгжлийн бэрхшээлтэй болон ХБХ эцэг, эх байгаа юм.

Санхүүгийн дэмжлэгийн 2-р хэсэг болох ТББ-д буцалтгүйгээр мөнгөн дэмжлэг үзүүлдэг бөгөөд 6 ТББ-аар очиж уулзалт хийж бизнестэй нь танилцсан. Одоогоор амжилттай бизнесээ үргэлжлүүлж, бараа бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж, борлуулж чадаж байгаа нь ер нь 50 хувьтай байсан.

Санхүүгийн дэмжлэгийн 4-р хэсэг нь Ажлын байр хадгалах дэмжлэг дэмжлэгийн хүрээнд 1 ТББ энэхүү дэмжлэгийг ХБХХЕГ-аас авсан бөгөөд уулзалт ярилцлага хийсэн.

3-р шалгуур нь Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээ байгаа бөгөөд 2 Ажил олгогчтой уулзсан.

Уулзалт ярилцлага хийхэд ХБХ ажиллаж байгаатай уулзаж, өвчтэй эсвэл чөлөөтэй байвал НДШ төлсөн эсэхийг баталгаажуулан асууж, төлсөн баримтыг үзсэн.

Уулзалтаа зургаар баримтжуулж явсан.

Уулзалт бүрийг урьдчилан ярьж тохирон товлож байсан тул цаг алдах, хий хаалга мөргөх асуудал гарч байсангүй.

Судлаачийн тайлан-21

Судлаачийн нэр

-

Байршил

Сонгинохайрхан дүүрэг

Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үнэлгээ хийх ажлын хүрээнд СХДүүрэгт нийт 42 оролцогчоос судалгаа авлаа.

Үүнээс судалгаанд:

Шалгуур үзүүлэлт 2. Нийт 23 (ААН 2, ТББ 4, Иргэн 17)

Шалгуур үзүүлэлт 3. Нийт 4 (ААН 4)

Шалгуур үзүүлэлт 4. Нийт 13 (ААН 3, Иргэн 10)

Шалгуур үзүүлэлт 5. Нийт 2 (Иргэн 2) хамрагдлаа.

- Санхүүгийн дэмжлэгийг СХД-т олон иргэн байдаг учир хүртээмжтэй болгох үүднээс нэг хүнд олгох 5 сая төгрөгийг хувааж 1 сая, 2 сая, 3 сая гэх мэтээр иргэдэд олгодог

юм байна. Иргэдээс судалгаа авахад анх төсөл бичихдээ тоног төхөөрөмж авах, эсвэл тоног төхөөрөмжөө сайжруулах гэж 5 сая төгрөг хүсдэг ч иргэдэд дэмжлэгийг хувааж өгснөөр тоног төхөөрөмж авч хүрэлгүй бараа материал, аар саархан зүйлд мөнгөө зарцуулдаг байна. ХБХүүхдэдтэй өрх толгойлсон эх, байнга хэвтэрт байдаг нөхөрөө асардаг бага насны хүүхдүүдтэй ээж гэх мэт хажуудаа туслах хүнгүй ганцаараа ажиллаж байгаа хүмүүсийн байдал нэн хүнд байна. Иймээс иргэдэд дэмжлэгийг хувааж өгөх биш ахиу дүнгээр дэмжлэг олгох нь зөв эсвэл дэмжлэг хүссэн иргэд 4,5 аар нь баг болж ирээд дэмжлэг хамтаараа хүсэж, хамтаар нь зээл олгох нөхцөл байж болох юм гэж судлаачийн зүгээс дүгнэж байна

- ААН, ТББ-ууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ ажиллуулж байгаа боловч ХБИ нэг ажлын байранд удаан тогтдоггүй, өөртөө итгэлгүй, жоохон байж байгаад ажлаа хийхгүй алга болчихдог гэж судалгаанд оролцогчид хэлж байлаа. Тиймээс ХБИ-г нийгэмшүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээгээр дэмжих, ажлын цагийг тогтоож өгөх гэж мэт ажлуудыг нэмэлтээр хийж өгөх шаардлагатай байна.
- ТББ-уудад буцалтгүй тусламж хэлбэрээр дэмжлэг өгөх нь зөв үү? Гэдэг дээр судлаач эргэлзээтэй байр суурьтай байна. Ихэнх нь ажлаагүй байгаа ба ААН-тай адилхан ашиг олоод адилхан зарчмаар явж байна гэж харж байна.
- Түрээсийн дэмжлэг авсан ААН-ууд судалгаа авахад маш хүнд сурталтай, олон удаа залгуулж байж 3 ААН-тай очиж уулзсан ба үлдсэн ААН-уудын утасны дугаар руу 10аад өдөр дараалж залгасан ч утас нь холбогдоогүй болно. ААН-аас байр түрээсэлж байгаад түрээсийн өрөнд орсон иргэд дэмжлэг авч ААНдаа өрөө дарсан, одоо огт ажиллахгүй байгаа тохиолдол байна.
- Сургалтанд хамрагдаж чадамжийн гэрчилгээ авсан иргэдээс судалгаа авахад ХБИргэндээ ээлтэй орчин бүрдүүлээгүй байгаа нь тогтоогдсон. Тиймээс ХБИ-дээ хүртээмжтэй орчин бий болгосон сургалтын байгууллагууддаа сургалт зохион байгуулах эрхийг өгөх нь зөв гэж дүгнэж байна. Мөн сургалтанд суусан иргэдийг ямар нэгэн ажлын байранд зуучилж өгөөгүй ба одоо болтол ажилгүй байгаа 2 иргэн манай түүвэрт таарч судалгаа өгсөн болно.

Судлаачийн тайлан-22

Судлаачийн нэр

Байршил

Хан-Уул дүүрэг

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” –ийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт- шинжилгээ, үнэлгээ /мониторинг/ хийх зорилгоор ХУД ХБХЭЭХ-ны зөвлөх ээж Ч.Элбэгдорж, С.Батмягмар нар 2022 оны 01 сарын 23 наас 03 сарын 04 өдрүүдэд нийт сар гаруй хугацаанд 47 албан газар, мэргэжилтнүүд, аж ахуй нэгж, ТББ, иргэдтэй өөрсдийн биеэр ажлын байран дээр очиж уулзалт, ярилцлага зохион байгуулж судалгаа авч ажиллалаа.

Судалгаанд 2019, 2020, 2021 онуудад хөтөлбөрт хамрагдсан нийт 86 иргэнээс 20 иргэнтэй холбогдон 8 иргэнтэй цаг товлон уулзалт зохион байгуулж судалгаа авсан. Түүврийн аргаар авсан иргэд маань 3 иргэн ковид туссан уулзах боломжгүй, 2 иргэн хаягандаа байхгүй уулзах боломжгүй, 1 иргэн нялх хүүхэдтэй уулзах боломжгүй, 1 иргэн эмнэлэгт хэвтсэн, 5 иргэн гадуур явж байна гэртээ байхгүй гэсэн тайлбаруудыг өгч байсан тул дахин сонголт хийнэ 8 иргэний гэрт нь очиж судалгаа авсан.

ТББ-ууд болон ААН-тэй нэг бүрчлэн холбогдон очиж уулзсан бол, ХУД-н Халамжаас өгсөн мэдээллийн дагуу явахад: ажил олгогчдын буцаан олголт авсан байгууллагын ажилчин гэх 2 хүн нь огт ХБХүн биш байсан. Мөн нэг ААН, нэг ТББ өөрсдөө уулзалтыг зөвшөөрөөгүй тул удаа дараа яриад амжилтгүй болсон./Нетворкс ААН 20сая, ХУД-н бие даан амьдрах төв ТББ 20сая/ төгрөгийн санхүүжилт авсан боловч уулзалт хийхийг зөвшөөрөөгүй.

Утсаар мэдээлэл өгнө гэж хэлсэн. Судлаач бид 2 нь үнэн бодит мэдээлэл авахын тулд утсаар мэдээлэл авахаас татгалзсан.

Дараах зүйлүүд ажиглагдсан болно. Үүнд:

- Судалгааны асуулгууд зөвхөн тогтвортой, тогтворгүй үгүй, нийцсэн, нийцээгүй гэх мэт асуулт асууж байгаа нь, зөвхөн судалгаанд оролцож байгаа ганц хүний үгээр л бүх зүйлд дүгнэлт өгөхүйц асуулгуудтай их бүрхэг санагдсан. Олон удаа холбогдон энэ их түгжрэлд олон цаг зарцуулж очиход яг судалгааны хэдэн хаалттай асуултууд асуугаад дуусгавал их дутмаг санагдсан. Жишээ нь: Санхүүжилтийн зарцуулалтыг асуух хэсэг, ТББ-аас НДШ төлсөн эсэхийг асуух асуулт байхгүй, зөвхөн судалгаанд оролцогчдын асуулгатай ажилд орсон хүнээс асуух асуумжийн хэсэг гэж огт байхгүй гэх мэт судалгааны асуулга бүрэн бус байсан гэж үзэж байна.
- Боломжоороо дэлгэрүүлж асуусан боловч зарим газар илт хийсэн юмгүй байгаач "тогтвортой" гэсэн хариулт өгч байсан бөгөөд судлаачид хүний өгсөн хариултыг засах ёсгүй учир түүгээр нь илгээсэн.
- Хаяг утасны дугаар зөрөөтэй олон ААН, ТББ-ууд хаягандаа байхгүй удаа дараа эрж хайж олсон.
- Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилд авсан ААН, ТББ-р ороход ХБ ажилчид ихэвчлэн ажлын байрандаа байхгүй, асуухад ковидын үед гэрээр ажиллаж байгаа, эмнэлэгт хэвтсэн, хүүхэд гаргасан эмнэлэгээр үзүүлж яваа гэх мэт олон шалтгаануудыг тоочиж байсан.
- Судалгаанд оролцсон нийт ААН,ТББ-ууд иргэдээс Сэтгэц оюун ухааны бэрхшээлтэй хүн зөвхөн 3 хүн ажилд орсон байгаа нь ХБХХЕГ, ХХҮЕГ анхааралдаа авч хөтөлбөртөө энэ төрлийн бэрхшээлтэй хүнийг ажил хөдөлмөр эрхлүүлэхэд тусгайлан анхаарах хэрэгтэй санагдсан.
- Хөтөлбөрийн тогтвортой байдалд анхаарах ёстой санагдсан нэг жил ч юмуу хугацаа дуусаа л ажилгүй болсон тохиолдлууд байсан.
- Ихэнх байгууллагууд хөнгөн бэрхшээлтэй хөдөлмөрийн нээлттэй зах зээлд ажиллаж болох хүмүүс (харшил, үе мөч,дотор эрхтэн гм 50, 60 хувь чадвар алдалттай харааны) авч ажиллуулсан байгаа нь ажлын байранд тохируулга хийх шаардлагагүй байгаа нь тохирсон ажлын байраар хангах гэдэг хөтөлбөрийн зорилгод нийцсэн эсэх нь эргэлзээтэй.
- Олгосон санхүүжилтээр бүгд бараа материал тоног төхөөрөмж худалдаж авсан байсан.
- ХУД-н Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах ТББ-ын тэргүүн гэх н. УРАНЧИМЭГ нь судалгаанд явж буй хүмүүсийг хэл амаар удаа дараа доромжилж ТББ-н хүн явууллаа, ХБХ-н ээж нар гэх авгайгаар шалгуулахгүй гэх мэтээр дайрч доромжлоод асуултуудыг хувийн нууц загнасан. 4 удаа утсаар ярьж 2 удаа ажлын байран дээр очиход уулзалтад уриад та нар шиг юмтай уулзахгүй гэж загнуулан 1 цаг гаруй ярьж утсаар цөөн юм асууснаар дуусгавар болгосон. Мөн Увдал хэмээх ХБИ түрээсийн дэмжлэг авсан байсан миний ажилтан руу ярьлаа хэмээн уурлаж байсан боловч авсан дэмжлэг хөтөлбөр нь өөр байсан тухай удаа дараа тайлбарлан байж Увдалтай холбогдон нэхээсний үйлдвэр дээр очиж уулзалт хийж судалгаагаа авсан.
- ХУД-н бие даан амьдрах төвийн тэргүүн гэх хүн ажлын байр төв аймагт ,би БГД-т байгаа гэсэн тул, ХБХЭЭХ-ны Төв аймаг дахь судлаач Баярмааг холбогдож ажлын байрыг үзүүлэхээр явуулсан боловч, ямар олон хүн залгадаг юм вэ гэж уурлаж, улирлын чанартай ажил одоо ажиллаагүй байгаа гээд судалгаа авч чадаагүй.
- НОТВОРК..... гэсэн мэдээлэлтэй иргэн намайг хүний хөгжлийн газрынхан мэднэ би ажлын байрандаа байхгүй орж юмаа аваа л гардаг гээд утсаар мэдээлэл авбал өгье гэсэн. Судлаачийн зүгээс утсаар мэдээлэл авах нь үнэн бодит эсэхэд эргэлзээтэй гэж үзэж утсаар мэдээлэл авахаас татгалзсан, 3 удаа залгахад ахиж дуудлага аваагүй тул судалгаа авч чадаагүй.
- Дээрх 2 байгууллагаас бусад нэр өгсөн бүх байгууллагаар орж судалгаа авсан болно.

Судалгаанд хамрагдсан нийт иргэд, аж ахуй нэгж, ТББ-хан хөтөлбөрийн талаарх мэдээлэл дутмаг, олон нийтэд нээлттэй бус, зарлагдаж буй хугацаа богино байдаг гэсэн саналуудыг хэлсэн. Мөн ковидтой холбоотой үйл ажиллагаа зогсонги болсон гэх нийтлэг шалтгаантай мөн түрээсийн дэмжлэг авсан хүний ихэнх нь дэмжлэг болсон хэмээн сэтгэл өндөр байсан. ХБИ-д ялангуяа харааны бэрхшээлтэй иргэдийн бариа засал, массажистийн үйл ажиллагаа нилээн жигдэрсэн, тогтмол үйл ажиллагаатай ч хамаг олсон мөнгө түрээсэндээ өгөөд, өөрсдөө баяр ёслолоор амраад хурдан ажилдаа ордог тухай ярьж байсан. Нийт ХБИ-дийн ихэнх нь ажлын байр өндөр үнэтэй нэг дор худалдан авах мөнгө байддаггүй тул төр засаг нэгдсэн нэг ч юмуу тухайн хүнд ч зээлээр ажлын байрыг бий болгож өгвөл түрээсэнд өгч байгаа мөнгөө улсдаа өгөөд дуусахад хөрөнгөтэй үлдэнэ хэмээн саналаа илэрхийлж байсан

Цөөнгүй иргэн ААН,ТББ-ууд түрээс болон бусад санхүүгийн дэмжлэг давхардуулж авснаас харахад цөөн хүмүүс төсөл хөтөлбөрт хамрагдаад давхардаж аваад байгаа боловч, 3-4 удаа хүсэлтээ өгөөд санхүүжилт авч чадаагүй анх удаа хамрагдаж байна гэх газрууд ч байв.

Мөн найдвартай зээлээ аваад хугацаанаас өмнө болон хугацаандаа төлж дууссан иргэн аж ахуй нэгжүүдийг дараа дахин хамрагдах хугацааг нь харах санхүүгийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалт хэрэгтэй байна гэж дүгнэв.

Судлаачийн тайлан-23

Судлаачийн нэр

Ц.Уянга ХБХЭЭХ-ны Паралегал

Байршил

Чингэлтэй дүүрэг

2022 оны 01 сарын 24 өдөр ЧД-гийн ХХҮХ-ийн ахлах мэргэжилтэн Н.Одгэрэлд ХБХЭЭХ-ны албан бичгийг хүргэж өгсөн. Мэргэжилтэн Н.Одгэрэл нь 2022.01.27-ны өдөр ирж хариугаа аваарай гэсэн. Хэлсэн өдөр нь 10 цагт очиход судалгаа дутуу байна. Хариуцсан ажилтан нь судалгаагаа бүрэн гаргаж өгөөгүй байгаа одоогоор гадуур ажилтай байгаа учир мэйл хаягаар чинь явуулчихъя гээд мэйл авч үлдсэн. Мэйлээр судалгаа явуулаагүй учир маргааш нь буюу 2022.01.28 өглөө 10 цагт очиж судалгаагаа хүлээн авлаа. ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөр 2019, 2020, 2021 оны судалгаа, ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн судалгаа 2019, 2020, 2021 оных, Ажлын байрны түрээсийн \АБТ\ дэмжлэг олгох 2019, 2020, 2021 оны судалгааг хүлээн авлаа. Судалгааг авахад АБТ-ийн судалгаанд утасны дугаар байгаагүй. Ажил олгогчын судалгаанд ажил олгогчын утас байгууллагын хаяг байхгүй. Зөвхөн ажилд орсон иргэний мэдээлэл байсан нь хайж олоход цаг хугацаа алдах, олон хороо хэсгийн ахлагч нартай уулзах гэх мэт судалгаа хийх явцад хүндрэлтэй байсан.

ХБИргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан 4 байгууллага оролцсон.

Ажлын байрны түрээсийн дэмжлэг – 2 байгууллага \3 удаа өгсөнөөс 1 нь давхардсан\ хамрагдсан.

Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөр

2.1 ХБИ-ий ажлын байрыг дэмжих арга хэмжээний хүрээнд 8 иргэнээс судалгаа авсан. 19-нь иргэнтэй холбогдсоноос гадагшаа явсан 1, судалгаа өгсөн 8, үйл ажиллагаа зогссон 6, утас нь холбогдохгүй буюу холбоо барьж чадаагүй 4 хүн байсан.

2.2 ТББ – 5 байгууллагаас судалгаа авсан.

Нийт 6 байгууллага байснаас 1 байгууллагатай \Марал элч ТББ\ холбогдож чадаагүй, хаягаар нь хайж очсон боловч олсонгүй.

2,3 Санхүүгийн дэмжлэг- 4 байгууллагаас судалгаа авсан.

Нийт 5 байгууллага байсан. 1 байгууллага /Нэгдэл өргөө ХХК/ судалгаа өгөхөөс татгалзсан.

Цогц дэмжлэгийн хүрээнд 3 байгуулагаас судалгаа авсан бол хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулсан 2 байгууллагаас судалгаа авсан. Нийт 28 байгууллага, иргэнээс судалгаа авав.

Дүгнэлт:

- ЧД-гийн ХХҮХ, ХБХХЕГ уудаас ирүүлсэн судалгаа хангалттай бус байсан. Зарим байгууллагын утас, хаяг тодорхой бус дугаар андуурсан гэх мэт асуудлууд гарсан.
- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллага болон иргэд ААН үүдтэй холбоо уялдаатай байх, бүртгэл шинэчлэх ажлуудыг тогтмол хийж баймаар санагдав.
- ХБИргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл нь санхүүжилт нь 50% ийн эргэн төлөлттэй байдаг бол ХБХ-ээ асарч буй эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлийн санхүүжилт нь 100% ийн эргэн төлөлттэй байгаа нь ялгавартай хандаж байгаа мэт санагдлаа.
- ХБИ ийн хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа нь сайшаалтай боловч хүссэн санхүүжилтийг олгодоггүй хасч олгодог нь тухай нь хүмүүсийн хувь бүрэн дүүрэн дэмжлэг болж чадахгүй байгаа нь харагдсан.

ХАВСРАЛТ 2

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ /МОНИТОРИНГ/ ХИЙСЭН ХБХЭЭХ-НЫ СУДЛААЧИД

№	Аймаг, Дүүрэг	Судлаачдын нэрс	Код
1	Архангай	Т. Чимэдлхам	1
		Ч.Тунгалагтамир	2
2	Баянхонгор	Н.Цэдэвсүрэн	3
		М.Дулмаа	4
3	Баян-Өлгий	Т. Ерлан	5
		А.Айжан	6
4	Булган	Д.Одгэрэл	7
		Г.Оюунбилэг	8
5	Дархан Уул	Г.Алтанчимэг	9
		Э.Солонго	10
6	Дорнод	Т.Оюунсүрэн	11
		Г.Ринчин	12
7	Дундговь	Ц.Батсайхан	13
8	Хэнтий	Т.Оюунсүрэн	11
		Мөнхтунгалаг	38
9	Увс	С.Нарантунгалаг	25
		Б.Бадамсүрэн	26
10	Багануур	Б.Ариунаа	27
11	Баянгол	П.Мөнхчимэг	28
		Ч.Цэнд	29
12	Баянзүрх	Ж.Алтантүлхүүр	30
13	Налайх	Г.Туяа	31
		Д.Март	32
14	Сүхбаатар дүүрэг	С.Сэлэнгэ	33

15	Сонгинохайрхан	М.Пүрэвсүрэн	34
16	Чингэлтэй	Ц.Уянга	35
17	Хан-Уул	Ч.Элбэгдорж	36
		С.Батмягмар	37
18	Завхан	Б.Мягмарсүрэн	14
		Ж.Наранцацрал	15
19	Орхон	Д.Одгэрэл	7
		Г.Оюунбилэг	8
20	Сүхбаатар аймаг	М. Алтанцэцэг	16
		Дэлгэрмаа	17
21	Сэлэнгэ	Ш.Ганзул	18
		Г.Баясгалан	19
22	Төв	Э.Баярмаа	20
23	Ховд	А.Баярмаа	21
		П.Алтанчимэг	22
24	Хөвсгөл	Ч.Лхагвасүрэн	23
		Г.Хажидмаа	24